

ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ ОНОЛ, АРГА ЗҮЙН СЭТГҮҮЛ

2014 №2 /48/

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

1. Авлигын улмаас бий болсон хөрөнгө, мөнгийг угаах гэмт хэрэгтэй тэмцэх арга зам.....Б.Батзориг
2. Монгол эмэгтэйчүүдийн биеэ үнэлэх явдалтай тэмцэхэд анхаарах асуудал.....С.Гантулга
3. Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам.....Б.Наргулан
4. Хүчирхийлэл гэмт явдал болох нь.....Г.Бямбадорж
5. Түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах зарим асуудал.....Д.Бямбахүү
6. Гадаадын зарим орны мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцдэг санхүүгийн тагнуулын байгууллагын үйл ажиллагааны онцлог, туршлага..... Ж.Төгс-Очир

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

1. 1921 оны хувьсгалаас хойшхи үеийн Монголын хууль цаазын түүхэн дэх ашигт малтмалын эрүүгийн эрх зүйн хамгаалал, уламжлал ба шинэчлэлийн асуудал.....Ж.Нямдулам
2. Гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектын насыг хуульчилж ирсэн түүхэн уламжлал.....Б.Мөнхзул

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

1. Цахим гавны тухай.....З.Төрмандах
2. Цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын өнөөгийн байдал, чиг хандлагаБ.Баянмөнх
3. Цагдаагийн албан хаагчийн агсамж, түүний эрх зүйн зохицуулалтын зарим асуудал.....Ш.Чулуун
4. Галт зэвсгийн талаарх эрх зүйн зохицуулалтын зарим асуудал.....Д.Булган

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

1. Албадан ажил хийлгэх ялын ач холбогдол, ял оногдуулахдаа шүүгдэгчийн хувийн байдлыг харгалзах нь.....О.Пүрэвсүрэн

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

1. Шүүхийн шинжилгээний байгууллагын үйл ажиллагааны орчныг боловсронгуй болгох арга зам.....Ж.Өнгөтхүү

ТӨР, ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

1. Олон нийтийн газар суурилуулсан видеокамерийг ашиглах асуудлыг хүний эрхийн үүднээс авч үзэх нь.....Б.Отгондалай
2. Шүүхийн болон Монгол Улсын Эрүүгийн хуулийн тухай өмгөөлөгчийн эргэцүүлэл.....Б.Соёл-Эрдэнэ

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ



АВЛИГЫН УЛМААС БИЙ БОЛСОН ХӨРӨНГӨ, МӨНГИЙГ УГААХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ АРГА ЗАМ¹

*Б.Батзориг
Тахарын Ерөнхий газрын дэд дарга,
доктор /Ph.D/*



Мөнгө угаах явдал нь гэмт явдлын улмаас бий болсон хууль бус хөрөнгө, мөнгөтэй холбоотой үүсдэг нийгмийн сөрөг үзэгдэл. Зохион байгуулалттай үндэстэн дамнасан гэмт хэрэг, террорист бүлэглэлийн үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах, өөрсдийгөө хамгаалах,

¹ 2013 оны 9 дүгээр сарын 23-27-ны өдөр зохион байгуулагдсан Типологийн олон улсын хуралд хэлэлцүүлсэн илтгэл

хууль бус хөрөнгө, мөнгөө угаах гол арга хэрэгсэл нь авлига гэдэгтэй та бүхэн санал нийлнэ гэдэгт эргэлзэхгүй байна. Иймд би энэ удаагийн илтгэлээр дээр дурдсан /зураг 1/ мөнгө угаагчдаас авлигын улмаас бий болсон хөрөнгө, мөнгийг угаахтай тэмцэх арга замын талаар авч үзье.

Юуны өмнө АТГ-аас явуулдаг Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн судалгаанд Монгол Улс дахь авлигын ерөнхий нөхцөл байдлын талаар хэрхэн тусгасан талаар дурдъя.

Улс төрийн хүрээн дэх авлигад өртөмтгий байдлын үнэлгээгээр Засгийн газар, яам, төрийн бусад байгууллага 4.25 (1-огт үгүй, 5-маш их), бүх шатны Засаг дарга, Засаг даргын Тамгын газар 4.08, улс төрийн намууд 3.69, нутгийн өөрөө удирдах байгууллага буюу аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, баг, хорооны ИНХ 3.67, Улсын Их хурал 3.27 гэж үнэлэгджээ. Эдгээр улс төрийн институцуудын авлигад өртөмтгий байдлын дундаж үнэлгээ 2012 онд 3.52 гарч өмнөх оныхоос 0.30 пунктээр буурсан нь авлигад өртөмтгий байдлын төсөөллийн түвшин буурсан болохыг харуулж байна.

Авлигад өртөмтгий байдлын 2012 оны үнэлгээ өмнөх оныхоос Засгийн газар, яам, төрийн бусад байгууллага, бүх шатны ИТХ болон ИНХ-ын хувьд 0.12-0.25 пунктээр нэмэгдсэн бол Улсын Их хурал, улс төрийн намуудын хувьд 0.48-0.58 пунктээр буурчээ. Харин бүх шатны Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын авлигад өртөмтгий байдлын үнэлгээ өмнөх оны түвшинд байна (Хүснэгт1).

Хүснэгт 1. Авлигад өртөмтгий байдлын үнэлгээ

	2008	2009	2010	2011	2012
Засгийн газар, яам, төрийн бусад байгууллага	4.38	4.29	4.40	4.25	4.00
Бүх шатны Засаг даргын Тамгын газар	4.14	4.23	4.00	4.27	3.69
Улс төрийн намууд	4.36	3.92	4.00	4.27	3.69
Нутгийн өөрөө удирдах байгууллага /Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, баг, хорооны ИНХ/	3.77	3.62	3.25	3.55	3.67
Улсын Их Хурал	3.71	4.46	4.00	3.75	3.27
Ерөнхийлөгч	-	2.91	3.75	3.27	2.18
	4.25	4.28	4.14	4.26	4.25

Албан тушаалтнуудын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ

Авлигад өртөмтгий байдлын үнэлгээ өндөр байгаа төрийн захиргааны байгууллага дахь албан тушаалтнуудын авлигад өртөх эрсдлийг албан тушаалын түвшингээр нь авч үзвэл 2012 оны байдлаар төрийн захиргааны байгууллагын удирдлагын буюу сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга нарын түвшинд 4.17 гэсэн үнэлгээтэй буюу авлигад өртөх эрсдэл хамгийн өндөр байгаа бол төрийн захиргааны байгууллагын дунд шатны албан хаагчдын буюу яам, агентлагийн газар, хэлтсийн болон салбар нэгжийн удирдлагуудын түвшинд 3.46 гэсэн үнэлгээтэй байна (Зураг 1). Албан тушаалтнуудын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ өмнөх оныхоос төрийн захиргааны байгууллагын

удирдлагын түвшинд 0.09 пунктээр өссөн бол төрийн захиргааны байгууллагын гүйцэтгэх, туслах албан хаагчийнх 0.81 пункт, төрийн байгууллагын захиргааны байгууллагын дунд шатны албан хаагчийнх 0.77 пункт, төрийн үйлчилгээний албан хаагчийнх 0.55 пунктээр буурчээ.

Зураг 1. Төрийн байгууллагын албан тушаалтнуудын авлигад өртөх эрсдэл



Улс төрийн хүрээнд өөрт болон бусдад ашигтай давуу байдал бий болгох шийдвэр гаргуулахдаа хийдэг үйлдлийн давтамжийн үнэлгээний дундаж түвшин 2012 онд 4.09 болж өмнөх оныхоос 0.24 пунктээр нэмэгдэж эдгээр үйлдлийг ашиглах давтамж өссөн байна.

Үйлдэл тус бүрээр авч үзвэл шийдвэр гаргуулахдаа мөнгө /хөрөнгө/ өгөх (давтамжийн үнэлгээ 4.67), бэлэг өгөх (4.58), олсон ашиг, орлогоо хуваахаар амлах (4.54), гадаад арга хэмжээний зардал даах (4.45) зэрэг үйлдлийг харьцангуй олон давтамжтайгаар ашигладаг байна (Хүснэгт 2). Энэ бүхнээс харахад авлигаас олсон хөрөнгө хэрхэн зарцуулагддагийг харж болно.

Хүснэгт 2. Улс төрийн хүрээнд өөрт болон бусдад ашигтай давуу байдал бий болгох шийдвэр гаргуулахдаа хийдэг үйлдлийн давтамжийн үнэлгээ, оноор

	2008	2009	2010	2011	2012
Мөнгө /хөрөнгө/ өгөх	4.07	4.70	4.42	4.15	4.67
Бэлэг өгөх	3.73	4.70	4.45	4.00	4.58
Олсон ашиг, орлогоо хуваахаар амлах	3.80	4.20	4.36	4.00	4.54
Гадаад арга хэмжээний зардал даах	-	3.80	4.33	4.08	4.45
Аялал, жуулчлалын зардал даах	3.33	3.90	4.09	4.08	4.36
Баяр ёслолын үеэр өндөр үнэтэй бэлэг өөрт нь өгөх, авах	-	4.30	4.11	3.83	4.33
Албан тушаалд томилох	-	4.40	4.67	4.38	4.23
Гэр бүлийнхэнд нь өндөр үнэтэй бэлэг өгөх, авах	-	3.60	3.56	3.73	4.20

Өндөр цалинтай, сул ажилд оруулах	-	4.10	3.89	3.92	4.18
Сургалтын зардал даах	-	3.80	3.83	3.77	4.10
Өрийг нь төлөх	-	2.80	3.45	3.22	4.00
Хэн нэгэнд зориулж ажлын байр шинээр бий болгох	-	4.00	4.00	4.00	3.77
Эмчилгээ, сувилгааны зардал даах	-	3.60	3.82	3.60	3.75
Гадаадын банкинд данс нээж өгөх /мөнгө өгөх/	-	2.90	3.63	3.33	3.75
Хувьцаа өгөх	-	2.70	3.33	3.36	3.67
Төрийн одон, медаль, салбарын тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнах	-	3.80	4.36	4.25	3.50
Өндөр бооцоо тавьж тоглоомд санаатайгаар хожигдох	-	3.50	3.56	3.80	3.50

Улс төрийн хүрээний авлига голлон чиглэгдэж буй үйл ажиллагааны үнэлгээ

Улс төрийн хүрээний авлига голлон чиглэгдэж буй үйл ажиллагааны үнэлгээний дундаж 3.40 болж өмнөх оныхоос 0.13 пунктээр буурчээ. Энэ бууралтад бизнест эрх мэдлээ тогтоох 0.27, дэд бүтцийн бүтээн байгуулалт 0.15 пунктээр өссөн ч хэвлэл мэдээллийн хэрэгсэл 0.87, уул уурхай 0.21, өмч хувьчлал 0.20 пунктээр тус тус буурсан нь нөлөөлжээ. Улс төрийн хүрээний авлига хамгийн их чиглэгдэж буй байдлаар нь авч үзвэл дэд бүтцийн бүтээн байгуулалт (4.45), уул уурхайн салбар (4.33), намд эрх мэдлээ тогтоох (4.20), бизнест эрх мэдлээ тогтоох (4.18), орон сууц, барилга байгууламж барих (4.08), өмч хувьчлах үйл ажиллагаа болон гадаадын хөрөнгө оруулалт (4.00) зэрэг үйл ажиллагаа болж байна (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Холбогдох үйл ажиллагаануудад улс төрийн хүрээний авлига чиглэгдэж буй байдлын үнэлгээ, оноор

	2009	2010	2011	2012
Дэд бүтцийн бүтээн байгуулалт	4.50	4.17	4.30	4.45
Уул уурхайн салбар	4.67	4.42	4.54	4.33
Намд эрх мэдлээ тогтоох	4.55	4.42	4.33	4.20
Бизнест эрх мэдлээ тогтоох	4.27	4.45	3.92	4.18
Орон сууц, барилга байгууламж барихад	4.08	3.92	4.23	4.08
Өмч хувьчлал	3.73	4.10	4.20	4.00
Гадаадын хөрөнгө оруулалт	3.82	3.92	4.17	4.00
Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	4.38	4.27	4.54	3.67
Газар тариалан	3.60	3.00	3.25	3.40
Сургалтын зардал даах	3.80	3.83	3.77	4.10
Өрийг нь төлөх	2.80	3.45	3.22	4.00
Хэн нэгэнд зориулж ажлын байр шинээр бий болгох	4.00	4.00	4.00	3.77

Эмчилгээ, сувилгааны зардал даах	3.60	3.82	3.60	3.75
Гадаадын банкинд данс нээж өгөх /мөнгө өгөх/	2.90	3.63	3.33	3.75
Хувьцаа өгөх	2.70	3.33	3.36	3.67
Төрийн одон, медаль, салбарын тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнах	3.80	4.36	4.25	3.50
Өндөр бооцоо тавьж тоглоомд санаатайгаар хожигдох	3.50	3.56	3.80	3.50

Авлигын хэлбэрүүдийн тархцын үнэлгээ

Улс төрийн хүрээнд 2012 онд улс төрийн зорилгоор хууль бус хандив өргөх, авах, (тархцын үнэлгээ 4.50), намд хандив авах (4.50), ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргах, гаргуулахаар лоббидох (4.50), төсвийн мөнгийг зориулалтын бусаар, өөрийн ашиг сонирхлоор зарцуулах (4.17), өөрийн өмчийн компани, аж ахуйн нэгжид давуу байдал бий болгох (4.15), өөрийн эрх мэдлээ худалдах (4.09) зэрэг авлигын хэлбэрүүд илүү өргөн тархсан гэж шинжээчид үзжээ (Хүснэгт 4). Харин 2011 онд мөнгө угаах, намд хандив авах, улс төрийн зорилгоор хууль бус хандив өгөх, авах, бизнесийн бүлэглэлийн нөлөөнд автах, тэдний төлөө үйлчилж хууль санаачлан батлуулах, сонгогчдын саналыг худалдан авах зэрэг хэлбэрүүд илүү өргөн тархсан байжээ. Улс төрийн хүрээн дэх авлигын хэлбэрүүдийн тархцын дундаж үнэлгээ өмнөх оныхоос 0.13 пунктээр буурсан нь дээрх авлигын хэлбэрүүдийн тархац буусан болохыг харуулж байна. Энэ бууралтад нь мөнгө угаахтай холбоотой авлигын хэлбэрийн үнэлгээ 1.07 пунктээр буурсан нь голлон нөлөөлжээ.

Сүүлийн дөрвөн жилийн хугацаан дахь ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргах, гаргуулахаар лоббидох авлигын хэлбэрийн үнэлгээний дундаж хамгийн өндөр буюу 4.46 байна. Үүний дараа улс төрийн зорилгоор хууль бус хандив өргөх, авах авлигын хэлбэр болон намд хандив авах авлигын хэлбэрүүд 4.45 дундаж үнэлгээтэй байна. Сонгогчдын саналыг худалдан авах авлигын хэлбэр 4.35, бизнесийн бүлэглэлийн нөлөөнд автах, тэдний төлөө үйлчилж хууль санаачлан батлуулах авлигын хэлбэр 4.32 гэсэн дундаж үнэлгээтэй байна. Хууль бусаар дампууруулах хэлбэрийн үнэлгээ 2009-2012 оны дунджаар хамгийн бага буюу 3.60 байлаа.

Хүснэгт 4. Улс төрийн хүрээн дэх авлигын хэлбэрүүдийн тархцын үнэлгээ

	2009	2010	2011	2012
Улс төрийн зорилгоор хууль бус хандив өгөх, авах	4.42	4.50	4.38	4.50
Ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргах, гаргуулахаар лоббидох	4.54	4.58	4.23	4.50
Намд хандив авах	4.42	4.25	4.62	4.50
Төсвийн мөнгийг зориулалтын бусаар, өөрийн ашиг сонирхлоор зарцуулах	4.15	4.36	4.08	4.17
Өөрийн өмчийн компани, аж ахуйн нэгжид давуу байдал бий болгох	4.46	3.25	4.15	4.15
Өөрийн эрх мэдлээ худалдах	4.00	4.17	3.91	4.09
Бизнесийн бүлэглэлийн нөлөөнд автах, тэдний төлөө үйлчилж хууль санаачлан батлуулах	4.33	4.64	4.33	4.00
Төрийн өмчийг шамшигдуулах, хувьдаа	4.00	4.00	4.08	3.92

завших				
Сонгогчдын саналыг худалдан авах	4.69	4.50	4.31	3.91
Хувийн байгууллага, санд хандив авах	3.75	3.64	3.73	3.90
Мөнгө угаах	4.00	3.80	4.67	3.60
Хууль бусаар дампууруулах	3.56	3.56	3.78	3.50

Улс төрийн хүрээнийхний хээл хахууль өгөх, авах аргуудын тархцыг үнэлсэн шинжээч нар үйл ажиллагааны зардал болгож өгөх, зуучлагчаар дамжуулах, эд зүйлийг зах зээлийн үнээс доогуур үнээр худалдах, худалдан авах, мөрийтэй тоглож, санаатай алдах, ойр дотнын хүн, тэдний гэр бүлийн гишүүд, тэдний өмчлөлийн компанид давуу байдал олгох зэрэг аргуудыг 2012 онд илүү өргөн тархалттай байна гэж үзжээ. Энэ нь 2011 оныхоос хувьцаа, эд хөрөнгө өмчлүүлэх, үйл ажиллагааны зардал болгож өгөх, аргуудын тархцын үнэлгээ 0.74 - 0.83 пунктээр нэмэгджээ. Эндээс авлигын хөрөнгийг хэрхэн хувиргадагийг харж болно. (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Улс төрийн хүрээн дэх авлигын хэлбэрүүдийн тархцын үнэлгээ

	2009	2010	2011	2012
Үйл ажиллагааны зардал болгож өгөх	3.36	4.27	3.5	4.33
Зуучлагчаар дамжуулах	4.10	4.09	4.00	4.11
Эд зүйлсийг зах зээлийн үнээс доогуур үнээр худалдах	3.50	3.45	3.78	4.11
Мөрийтэй тоглож санаатай алдах	3.44	3.75	3.90	4.08
Ойр дотны хүн, гэр бүлийн гишүүд, тэдгээрийн компанид давуу байдал олгох	4.20	4.08	3.90	4.08
Хувьцаа, эд хөрөнгө өмчлүүлэх	4.08	4.22	3.18	3.92
Ойр дотны хүмүүсээр дамжуулах	3.89	3.75	3.75	3.90
Эд зүйлсийг зах зээлийн үнээс дээгүүр үнээр худалдан авах	3.56	3.55	3.80	3.90
Шууд өөрт нь өгөх	3.45	3.8	3.33	3.67
Мөнгө зээлдүүлээд мартаx	3.00	3.56	3.40	3.38

Авлигын улмаас бий болсон хөрөнгө, орлогын зарцуулалтын хэлбэрийн тархцын үнэлгээ

Улс төрийн хүрээнийхэн авлигаар олсон хөрөнгөө ихэвчлэн орон сууц худалдан авахад, өөрийн болон гэр бүлийн эзэмшлийн компанид хувь оруулахад, гадаад болон дотоодод үл хөдлөх худалдаж авахад болон зугаа цэнгэлд илүүтэй зарцуулдаг гэж шинжээчид 2012 онд үзсэн байна.

Өмнөх оны судалгааны дүнтэй харьцуулахад дотоодын банкинд хадгалах хэлбэрийн тархац 1.67 пункт, гадаадад үл хөдлөх хөрөнгө худалдаж авах хэлбэрийн тархац 1.53 пункт, гадаадын банкинд хадгалах хэлбэрийн тархац 0.86 пункт, дараагийн сонгуульд зарцуулах хэлбэрийн тархац 0.83 пунктээр нэмэгдсэн нь хамгийн өндөр үзүүлэлтүүд болж байна. Хүүхдийн сургалтын төлбөрт зарцуулдаг гэсэн хэлбэрийн тархцын үнэлгээ 0.80 пунктээр буурсан нь хамгийн их бууралт болж байна (Хүснэгт 9).

Хүснэгт 9. Улс төрийн хүрээнийхэн авлигаар олсон хөрөнгөө зарцуулдаг хэлбэрүүдийн тархцын үнэлгээ

	2009	2010	2011	2012
Орон сууц худалдан авдаг	4.82	4.45	4.82	5.00
Өөрийн болон гэр бүлийн эзэмшлийн компанид хувь оруулдаг	4.60	4.27	4.78	5.00
Гадаадад үл хөдлөх хөрөнгө худалдаж авдаг	3.40	3.44	3.25	4.78
Үл хөдлөх хөрөнгө худалдан авдаг	4.82	4.45	4.80	4.75
Зугаа цэнгэлд зарцуулдаг	4.40	4.20	4.45	4.75
Өдөр тутмынхаа хэрэгцээнд зориулах	4.33	4.64	4.40	4.67
Дотоодын банкинд хадгалдаг	4.00	3.67	3.00	4.67
Машин худалдан авдаг	4.45	4.45	4.80	4.50
Дараагийн сонгуульд зарцуулах	3.25	4.00	3.60	4.43
Хүүхдийнхээ сургалтын төлбөрт зориулдаг	4.60	4.82	4.80	4.00
Гадаадын банкинд хадгалдаг	3.44	4.00	3.00	3.86
Хувьцаа худалдан авдаг	3.00	3.67	3.22	2.75

Улс төр хууль хяналтын хүрээний авлигын төсөөллийн судалгаанаас харахад Монгол улсад бизнесийн бүлэглэл улс төрчидийг эрхшээлдээ оруулан улмаар улс төр, бизнесийн бүлэглэлийн нөлөө хүчтэй болсоор байгааг харуулж байна. Тэр дундаа гадаадын бизнесийн бүлэглэл монголын улс төрийн нам бүлэглэлд сүүлийн 2011, 2012 онд жилд маш хүчтэй нөлөөгөө тогтоож байна гэж шинжээчид үзжээ. Түүнчлэн хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан, нам тойрсон бүлэглэл, бизнес бүлэглэлийн үйл ажиллагаа идэвхжиж байна.

Авлигын улмаас бий болсон хөрөнгө, мөнгийг угаахтай тэмцэх чиглэлээр явуулж буй төрийн бодлого, анхаарах зарим асуудал

Монгол Улс сэжигтэй гүйлгээ хянах тогтолцоог хянан эрх зүйн үндэс болсон Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль батлагдсан. Түүнчлэн Төрийн албан хаагчдын хөрөнгө орлого, ашиг сонирхлын талаар мэдээллийг бүртгэх, хянах тогтолцоог Авлигатай тэмцэх газар Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн дагуу улам боловсронгуй болгож байна. Тухайлбал, бүх хөрөнгө орлого, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг бүрэн хэлбэрт оруулж хянах техникийн орчин бүрдүүлж байна.

Төрийн байгууллагын хөрөнгө авлигад зарцуулагдахаас сэргийлэх зорилгоор Мэдээллийн ил тод болон мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг Авлигатай тэмцэх газар хуулийн дагуу хяналт тавьж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 88 дугаар зарлигийн дагуу 2013 оны есдүгээр сарын 1-нээс эхлээд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төсвийн орлого, зарлага болон тайлангийн бүх мэдээлэл олон нийтэд нээлттэй байхаар боллоо.

Эрүүгийн хуульд Төрийн албан хаагч хууль ёсны орлогоосоо гадна их хэмжээгээр эд хөрөнгө, орлого олсон нь тогтоогдсон эрүүгийн хариуцлага хүлээхээр заасан. Гэвч

төрийн албан хаагчдын хөрөнгө, орлогын талаарх бүх мэдээлэл цугларсан авлигатай тэмцэх газарт энэ гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулах харъяалал байдаггүй.

Банкны системээс гадуурх /банкнаас гадуурх/ мөнгө 2013 оны 8 сарын байдлаар 72.9 хувьтай байгаа² нь бид нийт мөнгөний гүйлгээ 30 орчмыг хянаж чадаж байна гэсэн үг. Шинэчлэн найруулсан Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар нотариатчдын үйл ажиллагааг хянах боломжтой болсон боловч бүх гүйлгээ бэлэн бусаар хийгдэж байгааг өөрчлөхгүйгээр энэ хуулийн хэрэгжилтийг хангахад хүндрэлтэй байна.

Түүнчлэн бэлэн бус гүйлгээ хийхэд үйлчлүүлэгч хуульд зааснаас хэтэрсэн гүйлгээ хийх тохиолдол болгонд нэмэлт мэдээлэл шаардах, удаах зэрэг нь тэднийг бэлэн бусаар эсхүл гадаад дансаар гүйлгээ хийлгэхэд түлхэж байгааг анхааралдаа авах хэрэгтэй байна.

²<http://www.mongolbank.mn>



С.Гантулга

*ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн
ахлах багш, докторант, цагдаагийн ахмад*

МОНГОЛ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН БИЕЭ ҮНЭЛЭХ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ

Нийгэм, улс төр, эдийн засгийн тогтворгүй байдал, инфляци, ажилгүйдэл, ядуурлын түвшин өндөр, тогтвортой буурахгүй байгаа, иргэд гадаад улсуудад ажиллах, суралцах сонирхол нэмэгдэж, гадагшаа чиглэсэн ажиллах хүчний урсгал бий болсон, иргэдийн хялбар аргаар мөнгө олох гэсэн хүсэл, эрмэлзлэл нэмэгдсэн зэрэг нь энэ төрлийн гэмт явдлын суурь шалтгаан болж байна.

Эдийн засгийн хөгжил сул орнуудад шунахайн болон хүч хэрэглэсэн гэмт хэргийн гаралт их байдаг. Хөгжиж буй, шилжилтийн үедээ буюу төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцооноос зах зээлийн эдийн засагт шилжсэн улсуудын эмэгтэйчүүд биеэ үнэлэх замд татагдан орж байна.

Монгол эмэгтэйчүүд гадаадын орнуудад болон дотоодод биеэ үнэлэх явдал сүүлийн жилүүдэд эрс нэмэгдсэн болох нь төрийн болон төрийн бус байгууллагуудын хийсэн судалгааны үр дүн, цагдаагийн байгууллагын статистик тоон мэдээнээс харагдаж байна. Тухайлбал, Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага, Үндэсний статистикийн хорооны 2012 онд хийсэн судалгааны тайлангаас үзэхэд манай улсад 4683 хүн биеэ үнэлж байгаагаас 13.6% нь гудамж талбай, 86.4% нь ямар нэгэн үйлчилгээний газар, дуудлагаар биеэ үнэлж байна гэжээ. Энэ бол хүн ам цөөн манай улсын хувьд өндөр үзүүлэлт юм.

Биеэ үнэлэх, түүнийг зохион байгуулах, татан оролцуулах гэмт явдалтай төрийн бодлогын түвшинд тэмцэх шаардлагатай байна. Юуны өмнө энэхүү гэмт явдлын шалтгаан, нөхцлийг тодорхойлох, түүнд дүн шинжилгээ хийж, төрийн байгууллагууд үүргээ маш нарийн тодорхойлон, удирдамж, төлөвлөгөөг боловсруулан, төлөвлөгөөний дагуу шат дараатай урьдчилан сэргийлэх арга хэмжээг иргэдийн оролцоо, дэмжлэгт тулгуурлан авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

Энэхүү гэмт явдалтай тэмцэхэд /урьдчилан сэргийлэх, илрүүлэх/ Улсын Их Хурал, Засгийн газар, нутгийн захиргааны байгууллагууд болон хууль сахиулах байгууллагууд, төрийн бус байгууллага, иргэдийн гүйцэтгэх үүрэг, эрх хэмжээг тодорхойлж өгөх нь үр дүнтэй. Учир нь биеэ үнэлэх, түүнийг зохион байгуулах гэмт явдалтай дан ганц цагдаагийн байгууллага, цагдаагийн албан хаагч тэмцээд тодорхой үр дүнд хүрэхгүй болох нь практикт нотлогдсон. Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажил нь хөрөнгө, хүч, цаг хугацаа их шаарддаг **"Бухал өвснөөс зүү хайж олохтой адил"** бэрх, хүнд хүчир ажил бөгөөд гэмт явдлын шалтгаан, нөхцлийг судлалгүй, түүний мөн чанарыг танин мэдэхгүйгээр түүнтэй тэмцэх нь **"Бухал өвснөөс нүдээ боогоод зүү хайж олохтой адил"** илүү хүнд бэрх, тодорхой үр дүнд хүрэхгүй, дэмий хүч, хөрөнгө, цаг хугацаа үрсэн ажил болж хувирдаг.

Нийгэм, нийгмийн хүчин зүйл нь өөрөө охид, эмэгтэйчүүдийг биеэ үнэлэхийг шаардаж, энэ зам руу тэднийг түлхэж байна. Саун, массажны газруудыг хааснаар *"Энд биеэ үнэлж болохгүй, гадаадад гарч, эсхүл интернет, TV chat, лавлах утас, сонин ашиглаж биеэ үнэл"* гэсэнтэй адил юм.

Цагдаагийн байгууллага, түүний албадаас явуулж байгаа үйл ажиллагаа нь энэ төрлийн гэмт хэргийг нуугдмал болгож байна.

Цагдаагийн байгууллага эмэгтэйчүүдийг биеэ үнэлэхэд нөлөөлж буй шалтгаан нөхцөл, хүчин зүйлийг судлалгүй, түүний мөн чанарыг танин мэдэлгүй, ямар ч нэгдсэн төлөвлөгөө, удирдамжгүй тэмцэл явуулж, олноор нь саатуулан, тэдний алдар хүнд, нэр төрд нь халдаж байгаа нь эргээд хүн худалдаалах, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах болон бусад төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөл болж байна.

Судалгаанаас үзэхэд биеэ үнэлж буй Монгол эмэгтэйчүүдийн ялангуяа /оюутан/ биеэ үнэлэхэд нөлөөлж буй хүчин зүйлүүдэд:

- Хүн амын төвлөрөл, нийслэл хотод нийт хүн амын талаас илүү хувь нь амьдардаг,
- Их, дээд сургуулиудын дийлэнх нь нийслэлд үйл ажиллагаагаа явуулдаг учраас хөдөө орон нутгийн оюутнуудад дотуур байрны хүрэлцээ хангалтгүй,³
- Иргэдийн амьжиргааны түвшин доогуур,
- Их, дээд сургуулиудын төлбөрийн хэмжээ иргэдийн амьжиргааны түвшинтэй харьцуулахад харьцангуй өндөр,
- Оюутан, сурагчдын хичээлийн бус цагаар хийх цагийн ажлын боломж, хүрэлцээ байхгүй,
- Анги, хамт олны нөлөө,
- Оюутан, суралцагсдын амар хялбар аргаар мөнгө олох гэсэн хүсэл, эрмэлзлэл,
- Сургалтын тогтолцооны гажуудал,
- Сургууль, анги хамт олон, ангийн багш мөнгө, бусад зүйлсийг суралцагсдаас татах үзэгдэл газар авсан,
- Сургууль, эцэг, эхээс оюутанд тавих хяналт сул зэрэг нөлөөлж байна.

Оюутнууд бар, ресторан, саун массажны газруудаар болон интернет кафе, гэрээсээ интернет ашиглах, лавлах утаснуудаар зуучлуулах зэргээр биеэ үнэлэх явдал ихэссэн. Тэд онлайн чатад нэвтэрч *"Мөнгөтэй ах нар наашаа"*, *"Нүцгэн хөх базах уу"*, *"Яг одоо санхүүгээр туслах хүн байна уу"* гэх зэргээр анхаарал татахуйц нэр өгч "худалдан авагч"-аа олдог болсон. Улмаар компьютерийн вэб камер ашиглан нүцгэлэх боломжтой газар байвал хөх, өгзөг, нүүр царай, бие галбираа харуулж, хоногийн 30-50 мянган төгрөгөөр биеэ үнэлж байна.⁴

2003 онд Азийн сангийн санхүүжилтээр "Хүний эрх хөгжил төв" төрийн бус байгууллага 141 биеэ үнэлэгчид, баар, шөнийн цэнгээний газар ажилладаг эмэгтэйчүүдийн дунд судалгаа хийсэн.⁵ Уг судалгааг хилийн боомтод ойрхон эсэх, мөн биеэ үнэлэгчдийн тоо зэргийг харгалзан Улаанбаатар, Дархан, Сүхбаатар, Чойбалсан хотууд, Замын-Үүд болон БНХАУ-ын Эрээн хотуудад хийжээ.

Судалгаанд Улаанбаатар хотод Улаанбаатар зочид буудлын өмнөх талбай, Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн ойролцоо биеэ үнэлдэг 49 эмэгтэй, Дархан хотод биеэ үнэлдэг 31 эмэгтэй оролцсон. Дарханд 60 орчим зочид буудал байдгаас 20 орчим нь

³ Нийслэлд 2009 оны 9 сарын байдлаар 132 их, дээд сургууль үйл ажиллагаа явуулж, тэдгээрт 142.000 оюутан суралцдаг. Нийслэлийн хэмжээнд 14.500 дотуур байр байдаг.

⁴ Ч.Буу."Дотоожтой "Дэвхрэг"//Өөр мэдээ.2009.08.29 №43/201/3273/

⁵ Хүний эрх хөгжил төв. Монгол улсад хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэх нь: асуудал ба арга зам. УБ., 2005. 35 дахь тал

биеэ үнэлэгчдийг орогноулж, бусдыг биеэ үнэлэхийг зохион байгуулдаг. Дарханд 16-38 насны 160 орчим биеэ үнэлэгч байдаг бөгөөд 50% орчим нь оюутнууд байдаг.⁶

Мөн энэхүү судалгаанд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотод биеэ үнэлдэг 8 эмэгтэй, Дорнод аймгийн Чойбалсан хотын Хэрлэн, Боржин, Наран, Тулга, То Ван зэрэг зочид буудлуудад, Венера, Космос, Тулга, Восток баарнуудад, ТҮЦ-үүд болон таксины зогсоолын ойролцоо зогсож биеэ үнэлдэг 27 эмэгтэй тус тус оролцсон.

Дорнод аймаг нь БНХАУ-тай гурван сард 1 удаа 20 хоногоор худалдаа, жуулчлалаар хил нэвтрүүлэх зорилгоор нээгддэг Хавирганы хилийн боомттой. Дорнод аймагт 1999 онд БНХАУ-ын иргэн гудамжны тэнүүлч хүүхдийг хууль бусаар хил нэвтрүүлэх гэж оролдсон боловч саатуулагдсан. Мөн Хятад, Монголын иргэд хамтран Хятадын өмнөд нутгаас Орос руу 20 орчим эмэгтэйг Монгол Хятад албан ёсны бус хилийн цэгээр хууль бусаар хил нэвтрүүлэн Дорнодод аваачсан боловч ОХУ руу гаргаж чадалгүй баригдсан байна.⁷

Судалгаанд БНХАУ-ын Эрээн хотод түр оршин суун улаан дэнлүүний гудамж, Монгол бааруудад, Алтанлуу, Канда, Босс, Алтанговь, Түвшин, Лин-Зүү, Хай-Фен, Мин-Жү зэрэг зочид буудлуудад байрлан биеэ үнэлдэг 37 эмэгтэй оролцсон.

Судалгаанд оролцогч 141 биеэ үнэлэгчдийн Хүний эрх хөгжил төвийн ажилтан *"Гадаадад виз болон тээврийн зардлыг даагаад өндөр цалинтай ажилд явуулна гэсэн санал хэн нэгэн тавьбал хүлээн авах уу?"* гэсэн асуултыг тавихад 59% буюу 83 нь "үгүй", 24% буюу 34 нь "тийм", 17% буюу 24 нь "мэдэхгүй" гэж тус тус хариулсан бол Улаанбаатар, Эрээнд биеэ үнэлж буй эмэгтэйчүүдийн 41.6% "тийм" гэж хариулснаас үзэхэд энэ төрлийн саналыг хүлээн авах магадлал хамгийн өндөр байсан.⁸

Судалгаанд оролцсон биеэ үнэлэгчдийн 30 буюу 21% нь гадаадад өндөр цалинтай ажил эрхлэх санал урьд нь хэд хэдэн удаа хүлээн авч байсан. Саналыг ихэвчлэн баар, зочид буудалд монгол иргэд тавьдаг бөгөөд цөөн тохиолдолд гадаадын иргэд байжээ. Судалгаанд оролцогчдын 29 буюу 20% нь гадаадад ажил эрхлэх санал хүлээн авсан хэн нэгнийг мэддэг гэж хариулсан байна.⁹

Энэхүү судалгаа нь даруй 10 орчим жилийн өмнө хийгдсэн тул нөхцөл байдал өөрчлөгдсөн байхыг үгүйсгэх аргагүй боловч биеэ үнэлэгчид нь хүн худалдаалах болон биеэ үнэлэхэд татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэгт өртөх эрсдэл хамгийн өндөр бүлэг гэж дүгнэж болохоор байна.

Монгол эмэгтэйчүүд дотоодод биеэ үнэлэхээс гадна гадаадын зарим орнуудад /БНХАУ-ын Эрээн, Бээжин, Хөх хот, Бугат, Алтан эмээл, Макао зэрэг хотуудад, БНСУ, Япон, Малайз гэх мэт/ олноор биеэ үнэлж байгаа талаар төрийн болон төрийн бус байгууллагууд мэдээлэх болсон.

Иймд бид БНХАУ-ын Эрээн хотод биеэ үнэлж буй Монгол эмэгтэйчүүдийн нөхцөл байдал, шилжилт хөдөлгөөний талаарх судалгааг 2009-2010 онд Швейцарийн хөгжлийн агентлаг, Хүний аюулгүй байдлын судалгааны төв төрийн бус байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр Хүйсийн тэгш эрхийн төв төрийн бус байгууллагатай хамтран хийсэн.

БНХАУ-ын Эрээн хот дахь "Синь тиань" зочид буудалд байрлан судалгаанд оролцсон биеэ үнэлэгч эмэгтэйчүүдтэй урьдчилан бэлтгэсэн асуултуудын дагуу ярилцлага хийж, 8 хоногийн хугацаанд ажиллахад дараах нөхцөл байдал дүгнэгдсэн. Үүнд:

1. БНХАУ-ын Эрээн хот дахь биеэ үнэлэхийг зохион байгуулдаг гудамж, баар, зочид буудлуудын байршлын талаар:

⁶ Дархан хотын эмэгтэйчүүдийн итгэлцлийн холбоо ТББ мэдээлэл. 2004

⁷ Хүний эрх хөгжил төв. Монгол улсад хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэх нь: асуудал ба арга зам. УБ., 2005. 37 дахь тал

⁸ Хүний эрх хөгжил төв. Монгол улсад хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэх нь: асуудал ба арга зам. УБ., 2006. 40 дэх тал

⁹ Хүний эрх хөгжил төв. Монгол улсад хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэх нь: асуудал ба арга зам. УБ., 2006. 42 дахь тал

БНХАУ-ын Эрээн хотод биеэ үнэлэхийг байнга зохион байгуулдаг гудамж 3 байдаг талаар биеэ үнэлэгч монгол эмэгтэйчүүд, хил орчмын бүс нутагт тээвэр хийгчид ярилцлагын явцад хэлсэн. Эдгээр гудамжнуудаас монгол эмэгтэйчүүд ихээр биеэ үнэлдэг “Чин чао” гудамж нь БНХАУ-ын Эрээн хотын төв хэсэгт байрлах бөгөөд Монгол Улсын Консулын газраас 1.2 км зайтай байрладаг болох нь анхаарал татаж байсан.

Дээрх гудамжнуудаас гадна биеэ үнэлэхэд зуучилдаг, тээврийн хэрэгсэл, орон байраар үйлчилдэг баар, зоогийн газар, сауны газрууд байдаг талаар судалгаанд оролцогчид хэлсэн. Тухайлбал, Монгол эмэгтэйчүүд Эрээн хотод дээрх гудамжуудад биеэ үнэлэхээс гадна хажуугаар нь бааранд бүжиглэж, санал тавьсан хүнд биеэ үнэлэх, мөн ширээнд нэг цаг нь 150 юаны ханштайгаар сууж үйлчилдэг талаар ярьж байлаа.

2. БНХАУ-ын Эрээн хотод биеэ үнэлж буй Монгол эмэгтэйчүүдийн тоо, шилжилт хөдөлгөөн, үрсгалын талаар:

БНХАУ-ын Эрээн хотод судалгаа явуулах хугацаанд биеэ үнэлж байгаа 260 орчим Монгол эмэгтэйчүүд байсан. Ярилцлагад хамрагдсан эмэгтэйчүүдийн 82% нь 19-22, 16% нь 23-26, 2% нь 27 ба түүнээс дээш настай байсан. Эдгээр эмэгтэйчүүдийн 86% нь Улаанбаатар хотын харъяат, 14% нь Дархан, Дорноговь зэрэг аймгуудаас ирсэн байсан. Энэ тоо улиралын болон бусад шалтгааны улмаас хэлбэлздэг байна. Тухайлбал, их, дээд болон ерөнхий боловсролын сургуулиудын амралт, Монгол, БНХАУ-ын Цагдаагийн байгууллагаас явуулж буй хамтарсан болон тусгай шалгалт, арга хэмжээний улмаас биеэ үнэлэгч Монгол эмэгтэйчүүдийн тоонд өөрчлөлт орж шилждэг байна. Жишээ нь, Эрээнд шалгалт хийгдвэл биеэ үнэлэгчид Бээжин, Хөх хот, Бугат руу явж биеэ үнэлдэг байна.

Мөн зун болж ажиллагсад ээлжийн амралтаа авах, жуулчлал, амралт, зугаалгаар тус бүс нутаг руу чиглэсэн хөдөлгөөн ихэсснээр биеэ үнэлэгчдийг авах хүмүүсийн тоо нэмэгдэж, улмаар Монголоос болон БНХАУ-ын бусад хотуудаас биеэ үнэлэгч Монгол охид Эрээнд ирж биеэ үнэлдэг болох нь судалгааны явцад ажиглагдсан.

Эрээн хотын энэ гудамж нь 61 “гэр”¹⁰-тэй. Дээрх гэрүүдийн дийлэнхид Монгол эмэгтэйчүүд /Хятад, Орос, Өвөр Монгол эмэгтэйчүүд биеэ үнэлдэг/ биеэ үнэлдэг байна. Нэг гэрт тогтмол 4-6 Монгол эмэгтэй биеэ үнэлдэг ба дээрх хүчин зүйлүүдийн нөлөөллөөр энэхүү тоо, 10-12-т хүрдэг¹¹ бөгөөд зөвхөн энэ гудамжны гэрүүдэд байрлан **244-366** Монгол эмэгтэй тогтмол биеэ үнэлж,¹² биеэ үнэлэгчдын тоо их, дээд болон ерөнхий боловсролын сургуулийн амралтын үеэр **600- 730** хүрдэг байна.

Биеэ үнэлэгчид “гэрийн” 2 давхартаа байрладаг учир ажлын цаг гэж байхгүй болох нь ажиглагдсан. Хоногоор тэднийг гэрийн эзэдтэй тохиролцон худалдан авсан тохиолдолд хэдэн цагт ч авсан байсан маргааш өглөө 08 цагт “гэртээ” ирсэн байхыг гэрийн эзэд шаарддаг байна.

Судалгааны ажлын явцад БНХАУ-ын Эрээн хотод биеэ үнэлж буй Монгол эмэгтэйчүүд болон хил орчмын бүс нутагт тээвэр хийгчид, баар, зоогийн газрын ажиллагсад, хувийн болон албаны шугамаар яваа Монгол улсын иргэдтэй хийсэн ярилцлага, судлаачдын биечлэн хийсэн ажиглалтын үр дүн зэргээс үзэхэд Эрээн хотод биеэ үнэлж буй Монгол эмэгтэйчүүдийн тоо нь Замын-Үүдийн Цагдаагийн хэсгийн ажилтнуудын тоотой ойролцоо байсан.

Судалгааны ажлын явцад гол анхаарал татаж байсан асуудал бол энэ бүс нутагт хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын тоо өсөн нэмэгдэх хандлагатай байна. Учир нь охид, эмэгтэйчүүд эхэндээ хууран мэхлэгдэн хүчинд автан биеэ үнэлж байгаад визний хугацаа дуусмагц гэрийн эзэд эмэгтэйчүүдэд унааны зардал болох цөөн хэдэн юан өгч,

¹⁰ Бусдыг биеийг үнэлүүлэх зорилгоор ашигладаг 2 давхар орон байрыг биеэ үнэлэгчид ингэж хэлдэг

¹¹ БНХАУ-ын Эрээн хотод биеэ үнэлж буй эмэгтэйчүүдтэй хийсэн ярилцлага, судалгааны багийнханы хийсэн ажиглалтаас

¹² БНХАУ-ын Эрээн хотод биеэ үнэлж буй эмэгтэйчүүдтэй хийсэн ярилцлага, судалгааны багийнханы хийсэн ажиглалтаас

явуулдаг боловч эмэгтэйчүүд биеэ үнэлж мөнгө олох хялбар арга гэж үзээд хил гарч штамп даруулаад /биеэ үнэлэгчид шон тойрох гэж ярьдаг/ уг гудамжиндаа ирж биеэ үнэлж эхэлдэг байна.

Элсүүлэлт:

Хохирогчдыг гэмт этгээдүүд найз нөхдөөр нь дамжуулан болон караоке, бааранд биечлэн уулзаж өндөр цалин хөлстэй ажлын байр амлах буюу ажилд зуучлах санал тавих, замын зардал, гадаад паспортыг гаргаж өгөх, санхүүгийн туслалцаа үзүүлэх зэргээр элсүүлж байна.

Мөн эхэн үедээ хууран мэхлэгдэн хүчээр биеэ үнэлж байсан охид Монголд байгаа найз нөхдүүд рүүгээ утсаар ярьж, Эрээнд ирэх замын зардал, гадаад паспорт гаргуулахтай холбогдон гарах болон бусад зардлыг арилжааны банк болон банк бус санхүүгийн байгууллагуудаар шилжүүлэн элсүүлж байна. */Судалгаанд оролцогч биеэ үнэлэгч бидний дэргэд Монголоос 2 охиныг ирж энд ажиллах талаар санал тавьж, бэлэн мөнгө банкаар шилжүүлэх талаар ярилцсан болно/* Элсүүлсэн охин Эрээнд ирсэн үед гэрийн эздээс элсүүлэгч 5000 хүртэл юаны урамшууллыг авдаг байна.

Цаашид энэ төрлийн гэмт хэргийн элсүүлэлт улам нэмэгдэх, илүү зохион байгуулалтанд орох, гэмт бүлэг, бүлэглэлийн гишүүд элсүүлэлтийг зохион байгуулах хандлага ажиглагдсан.

Тээвэрлэлт:

Хохирогчдыг тээвэрлэхдээ гэмт этгээдүүд хамт явах, эсхүл хохирогчдыг өөрсдийг нь ажилд зуучилна гэх мэтээр хууран мэхэлж, галт тэргээр илгээн Эрээнд ирэхэд нь хүлээн авагчаар тосч авахуулж байна.

Замын-Үүдийн боомтоор нэвтрэгсдэд тавих хяналт шалгалт нэмэгдсэн үед гэмт этгээдүүд хохирогчдыг Дорнод болон бусад аймгуудын байнгын болон түр ажиллагаатай боомтуудаар дамжуулан Эрээн болон БНХАУ-ын бусад хотууд руу тээвэрлэдэг талаар биеэ үнэлэгчид хэлсэн.

Цаашид гэмт этгээдүүд өөрсдийн тээврийн хэрэгслээр хохирогчдыг тээвэрлэх хандлагатай.

Хүлээн авалт буюу мөлжлөг:

Эмэгтэйчүүдийн бичиг баримтыг “гэрийн эзэд” барьцаалан элсүүлэгчид өгсөн 5000 юаныг төлүүлдэг ба охид, эмэгтэйчүүд энэ хэмжээний мөнгийг нэг сарын хугацаанд төлсний дараагаар бичиг баримтаа авах эрхтэй болдог байна. Биеэ үнэлэгчидтэй хийсэн ярилцлагаас үзэхэд архи, согтууруулах ундаа уусан, хоногоор биеэ үнэлээд ирэх цагаас хоцорсон тохиолдолд гэрийн эзэд шийтгэдэг талаар ярьж байлаа. Эндээс үзэхэд биеэ үнэлэгчдэд гэрийн эздийн зүгээс дарамт үзүүлэх, хүчирхийлэл, заналхийлэл үзүүлдэг байхыг үгүйсгэх аргагүй.

3.Худалдагдсан, биеэ үнэлэх болсон шалтгаан, нөхцөл байдлын талаар:

БНХАУ-ын Эрээн хотод худалдагдсан болон биеэ үнэлж буй эмэгтэйчүүдийн худалдагдах, биеэ үнэлэх болсон шалтгаан, нөхцлийг тодорхойлох зорилгоор 16 биеэ үнэлэгч эмэгтэйг цагаар худалдан авч,¹³ урьдчилан бэлтгэсэн асуултын дагуу ярилцлага хийсэн.

Ярилцлагаас үзэхэд эдгээр эмэгтэйчүүд нь бүгд хэн нэгнээр зуучлуулан Эрээн хотод ирсэн. Зуучлагчид эмэгтэйчүүдийг *"Караоке, зоогийн газар зөөгчийн ажилд зуучилна. Монголчууд цөөн учраас мөнгө олох боломжтой"* гэж хууран мэхэлж, эмэгтэйчүүдийн

¹³ Цагаар биеэ үнэлэгч эмэгтэйг авахад 150 юан, нэг удаа бэлгийн харьцаанд ороход 100 юан, хоногоор авахад 300 юаны ханштай байдаг.

гадаад паспорт авах, замын зардлыг дааж БНХАУ-ын Эрээн хотод авч ирээд “Лобо”¹⁴ /гэрийн эзэн/-нд зарж 5000 орчим юан урамшуулалд нь авсан, гэрийн эзэд эмэгтэйчүүдээс энэхүү өрийг төлөхийг шаардаж, гадаад паспортуудыг нь барьцаалдаг зэрэг шинжүүдээс нь үзэхэд Монгол Улсын Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд заасан хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжтэй байна.

Мөн эмэгтэйчүүдийг гэрийн эзэд зодох, бие махбодийн болон сэтгэл зүйн дарамт байдаг байхыг үгүйсгэх аргагүй. Тухайлбал, судалгаанд оролцогч биеэ үнэлэгч эмэгтэй хүчинд автан биеэ үнэлж буй эмэгтэйчүүдийн талаар урьд нь сонсож байсан, биеэ үнэлэгчдийг цагдаад мэдэгдэж торгуулна, хар тамга даруулна гэх мэтээр дарамталж, айлган сүрдүүлдэг талаар ярьсан.

БНХАУ-ын Эрээн хотод биеэ үнэлж буй эмэгтэйчүүд нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсноо төдийлөн мэдэхгүй байна. Олон Улсын гэрээ конвенцид зааснаас үзвэл дээрх эмэгтэйчүүд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид юм.

Эмэгтэйчүүд биеэ үнэлээд олсон орлогын тодорхой хувийг өөртөө авдаг,¹⁵ эрх, эрх чөлөө нь бүрэн хязгаарлагдсан шинжгүй байдаг бөгөөд энэ нь биеэ үнэлж буй Монгол эмэгтэйчүүд бүгд Монгол болон БНХАУ-ын үүрэн холбооны операторын дугаартай гар утастай байсан бөгөөд хүссэн үедээ гадагшаа явах, дэлгүүр хэсэх, саунд орох, хүнтэй уулзах боломжтой байдаг зэрэг шинжүүдээс нь авч үзвэл лобо нарын монгол эмэгтэйчүүдийн биеэ үнэлэхийг зохион байгуулж, орон байраар үйлчилж буй үйлдэл нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн 124-р зүйлд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжтэй байна.

Дээрх эмэгтэйчүүд биеэ үнэлэх болсон шалтгаанаа ядуурал, ажилгүйдэлтэй холбон тайлбарлаж байсан. Судалгаанд оролцсон 16 эмэгтэйн 14 нь коллеж, их, дээд сургуулийн оюутнууд байсан бөгөөд зуны амралтаараа сургалтын төлбөрөө олох зорилгоор биеэ үнэлж байгаа талаар ярьж байлаа. “Монголд ажил олддоггүй. Олдсон ч цалин бага, хөдөлмөрлөх нөхцөл муу, олон цагаар ажиллуулаад илүү цагийн мөнгө өгдөггүй” гэж байсан. Мөн судалгаанд оролцогч нэгэн эмэгтэй хойд эцэг нь түүнийг байнга зодож, гэрээсээ хөөдөг учраас найзыгаа дагаж, Эрээнд ирээд биеэ үнэлэх болсон талаараа ярьсан.

Судлаачийн зүгээс дүгнэхэд дээрх эмэгтэйчүүд нь амар хялбар аргаар богино хугацаанд их хэмжээний мөнгө олох хүсэлдээ хөтлөгдөн бусдад мэхлэгдэн Эрээн хотод ирсэн байх бөгөөд тодорхой хугацаанд /20-30 хоног/ биеэ үнэлж гэрийн эздэд “өрөө төлөөд” цаашид энэхүү аргаараа мөнгө олох зорилгоор хил гарч штамп даруулаад дахин 30 хоногийн хугацаанд биеэ үнэлдэг, биеэ үнэлэхийн хажуугаар Монголоос таньдаг охид, эмэгтэйчүүдийг элсүүлэн¹⁶ гэрийн эзнээс урамшуулал болгон мөнгө авдаг болох нь тэдэнтэй хийсэн ярилцлагаас ажиглагдсан.

Судалгааны явцад ихээхэн анхаарал татсан зүйл бол судалгаанд оролцогч биеэ үнэлэгч эмэгтэйчүүдээс эрх, эрх чөлөө хууль ёсны ашиг сонирхол чинь зөрчигдсөн, гэмт халдлагад өртсөн тохиолдолд хаана, хэнд хэрхэн хандах талаар тодруулахад огт мэдлэг, мэдээлэлгүй байсан. Монгол улсын Консулын газрын хаяг, байршил, утасны дугаарыг мэдэх эсэхийг тодруулахад бүгд мэдэхгүй байсан.

¹⁴ Биеэ үнэлж буй эмэгтэйчүүдийг орон байр, тээврийн хэрэгсэл, бусад хэрэслээр үйлчилдэг, биеэ үнэлэхэд зуучилдаг этгээдийг хэлнэ.

¹⁵ Биеэ үнэлэгч эмэгтэйчүүд биеэ үнэлж олсон орлогын 70%-ийг өөртөө авч, 30%-ийг гэрийн эзэндээ өгдөг. Тухайлбал, хоногоор 300 юанаар биеэ үнэлсэн тохиолдолд 200 юаныг өөртөө авч, 100 юаныг гэрийн эзэндээ өгдөг байна.

¹⁶ Судалгаанд оролцогч нэгэн биеэ үнэлэгч эмэгтэй бидний дэргэд Монголоос 2 эмэгтэйг Эрээнд ирэхийг ятгаж, гадаад паспорт гаргуулах болон замын зардлын мөнгийг шилжүүлэхээр гар утсаараа ярьсан.



БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ЖУРМЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ

Б.Наргулан

*ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн
тэнхимийн багш, цагдаагийн хошууч*

Өнөө үед хүн төрөлхтний хүрээлэн буй орчин, экологийн асуудал хурцаар тавигдаж байна. Экологийн асуудал нь хүний өөрийн хүчин зүйлсээс хамаарч байдаг ба хүн байгальтай харилцах харилцааны буруу үйл ажиллагаанаас ихээхэн сүйдэж байна.

Байгаль орчин нь хүмүүсийн амьдрах орчинг хүрээлэн байдаг тул нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийн байгаль орчинд сөрөг буруутай үйлдэл нь нийт хүмүүст нөлөөлдөг учир хор аюулын хэмжээгээр их байдаг.

21-р зуунд аж үйлдвэржилт эрчимжиж, дэвшилтэт шинэ техник, технологийн үсрэнгүй хөгжлийн хэрээр хүний нийгэм хөгжлийнхөө өндөр шатанд гарч, дэлхий ертөнц глобалчлагдаж буй энэ цаг үед байгаль орчноо хайрлан хамгаалж, зүй зохистой ашиглах, нэн ялангуяа түүний эрх зүйн таатай бөгөөд тохиромжтой орчинг бүрдүүлэх явдал манай ард түмэн хийгээд төр, засгийн нэн тэргүүний зорилт мөнөөс мөн гэдгийг өнөөгийн өнгө төрх, бодит байдал бэлхэнээ харуулж байгааг оршил болгон бичих нь зүй ёсны хэрэг юм.¹⁷

Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа хүний зохисгүй, ухамсаргүй, хувиа хичээсэн аминчхан, шунахай үйл ажилагааны улмаас байгаль экологийн эсрэг чиглэсэн гэмт хэрэг, зөрчил, түүний нийгмийн хор аюулын шинж чанар, хэр хэмжээ, шалтгаан нөхцлийг судалсаны үндсэн дээр экологийн доройтлыг хэрхэн даван туулах хийгээд байгаль экологийн эсрэг чиглэсэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга замыг боловсронгуй болгох талаар өөрийн саналыг шийдвэр гаргагчдад, хууль тогтоогч нарт хүргэхэд ач холбогдол нь оршино.

Олон улсын хэмжээнд хүн амыг олноор нь сүйрүүлж, тухайн улсын эдийн засагт ихээхэн хүнд гарз, хор, хохирол учруулж байгаа 20 гаруй гамшиг ослоос манай оронд 1994 оноос хойш гэхэд ган, зуд, гал түймэр, хүн, малын гоц халдварт өвчин, байгалийн хүчтэй үзэгдэл шороон болон цасан шуурга гэх мэт 10 гаруй үзэгдэл гарч эдгээрийн улмаас 458

¹⁷ Ш.Довдон. Экологийн салбарт гарч байгаа шинэ төрлийн гэмт хэрэг, түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох. Онол практикийн бага хурлын илтгэлүүдийн эмхтгэл. УБ., 2007. 32 дахь тал

хүн амь насаа алдаж, 14 сая мал хорогдож, 380 гаруй тэрбум төгрөгийн хохирол учирсан статистик дүн мэдээ бий.¹⁸

Эрүүгийн хуулийн 23 дугаар бүлэгт заасан Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийг шүүхээс хэрхэн шийдвэрлэснийг улсын хэмжээнд судалж үзэхэд 2002 оноос хойш шүүх дээрхи төрлийн 130 хүнд холбогдох 97800.000 төгрөгийн хохиролтой 82 хэргийг хянан шийдвэрлэж, 5 хүнд холбогдох 2 хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцааж, 3 хүнд холбогдох 2 хэргийг хуульд заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, 78 хэргийг таслан шийдвэрлэжээ.¹⁹

Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргүүдээс шүүхийн шатанд Эрүүгийн хуулийн 203 дугаар зүйлд заасан ан агнуурын тухай хууль тогтоомж зөрчсөн, мөн хуулийн 211 дүгээр зүйлд заасан ойн тухай хууль тогтоомж зөрчсөн, 214 дүгээр зүйлд заасан ашигт малтмалын хайгууль хийх, олборлох журам зөрчсөн зэрэг хэргүүд зонхилон шийдвэрлэгдэж байсан.

Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн шалтгаан, нөхцөл

- Манай улс нэг хүнд ногдох үндэсний орлогоороо сүүл мушгиж, эдийн засгийн хүчин чадал сул, ард түмний амьдралын түвшин дорой, ажилгүйдэл ядуурал газар авсан, цалин тэтгэвэр, тэтгэмж бага байгаа зэрэг эдийн засгийн шалтгаан нь хүмүүсийг байгаль түүний баялаг руу хууль бусаар халдах шалтгаан болж байна.
- Хүмүүсийн байгаль орчноо хайрлан хамгаалах ухамсар, сэтгэхүй дорой, байгалиа хайрлан хамгаалж ирсэн өв уламжлал мартагдаж, байгаль орчинд гамгүй хандах сэтгэлгээ газар авсан
- Байгаль орчны холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилт муу, түүнд мэргэжлийн болон хууль хяналтын байгууллагуудын тавих хяналт, судалгаа сул
- Байгаль орчныг хамгалах хууль тогтоомжийн хийдэл / цоорхой / , боловсронгуй бус байдал, энэх төрлийн хуулиудад урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар тодорхой заалт байхгүй
- Байгалийн баялгийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн хэмжээ бага, хөрөнгө байсан ч тэр бүр үр дүнтэй зарцуулагддаггүй
- Олон нийтийг байгал орчныг хамгаалах, гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх ажилд татан оролцуулдаггүй, тэдний ухамсарт оролцоо ч сул байгаа
- Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, зөрчилд холбогдогсдод оногдпуулах эрүүгийн ялын болон захиргааны хариуцлага сул гэх мэт шалтгаан нөхцөлүүд нь энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн гаралт улам ихсэхэд нөлөөлж байна.

Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зам

1) Эдийн засгийн арга хэрэгсэл нь хуулийн дагуу зохих зөвшөөрөлтэйгээр байгалийн баялгийг ашиглаж, татвар хураамжаа цаг тухайд нь төлдөг, экологид аюулгүй техник, технологи хэрэглэдэг, нөхөн сэргээлт байнга хийдэг иргэд, аж ахуйн нэгжийг дэмжин урамшуулах, татварын хөнгөлөлт үзүүлэх, байгаль орчинд хортой хоцрогдсон техник, технологи ашиглахыг хориглох, ашигласан тохиолдолд их хэмжээний хураамж авах, байгалийн баялгийн ашиглалтын төлбөрийг нэмэгдүүлэх, торгууль нөхөн төлбөрийг бүрэн, шуурхай барагдуулах, төвлөрсөн хөрөнгийг эргээд байгаль орчныг нөхөн сэргээх, байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулах хэлбэрээр илэрнэ.

2) Улс төрийн арга хэрэгсэл нь төрөөс байгаль хамгаалх талаар зохистой бодлогыг баримталж бүх нийтийн эрх, тэгш, шударга ёсны, зохистой хэм хэмжээг баримтлах замаар

¹⁸ Ш.Энхтайван. Экологийн гэмт хэрэг, түүний онцлог шинж". Онол практикийн бага хурлын илтгэлүүдийн эмхтгэл. УБ., 2007. 15 дахь тал

¹⁹ ЦЕГ-ын мэдээлэл судалгааны төв. "Гэмт хэргийн нөхцөл байдлын судалгаа". УБ., 2008 оны 10 сарын байдлаар

байгалийн баялгийг ашиглагч иргэд, байгууллагуудад хуулийн дагуу ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, төрийн болон хууль хяналтын байгууллагуудын үйл ажиллагааны талаар нээлттэй мэдээлэх, байгалийн баялаг болон зарим бүс нутгийг олон нийтийн хяналтанд байлгах зэрэг асуудлууд хамаарна.

3) Эрх зүйн арга хэрэгсэл нь урьдчилсан шинжтэй байх бөгөөд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэж байгаа үйл ажиллагаа, системийн гажиг, дутагдлыг илэрүүлэн засах механизмыг бүрдүүлэх, иргэд аж ахуйн нэгжийг хуульд заасан үүргээ биелүүлэх явдлыг хангахад оршино.

4) Зохион байгуулалтын шинжтэй арга хэмжээ нь хууль хяналтын байгууллагууд болон байгаль хамгаалах байгууллагын хоорондын үйл ажиллагааны хэлхээ холбоо муутай, харилцан уялдаагүй байдлыг илэрүүлэн засах, хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлэх, экологийн цагдаагийн байгууллага байгуулж ажиллуулах, шаардлагатай техник хэрэгсэлээр хангах зэрэг ажиллагаанууд хамаарна.

Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгтэй хийх тэмцэл

1) Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажил нь юуны өмнө хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлж, ядуурлыг бууруулах

2) Байгаль хамгаалах гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажил эрх зүйн хүчтэй үндэс суурьтай байх ёстой. Тухайлбал эрүүгийн хуулинд зөвхөн хувь хүн л эрүүгийн хариуцлага хүлээдэг зарчим байгааг өөрчилж хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлагад татаж хүлээх хариуцлагыг нь чангатгаж, тэдгээрийг илэрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлын онцлогийг тусгаж өгөх

3) Хууль хамгаалах байгууллагууд болон байгаль хамгаалах албадууд нь хамтран ажиллаж энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцлийг илэрүүлэн арилгах, гэмт хэрэг, зөрчилд холбогдогсодтой тулж ажиллах шаардлагатай

4) Шашны зан үйлийг ашиглах замаар байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах

5) Байгаль хамгаалах цагдаагийн газрыг байгуулж, байгаль хамгаалах албаны үйл ажиллагааг бие даасан статусыг нь баталгаажуулж, эрх хэмжээг нь нэмэгдүүлэх нь энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэхэд чухал түлхэц болно

6) Байгаль орчныг хамгаалах багц хуулиуд болон эрүүгийн хуулийн зүйл заалтуудыг одоогийнхоос боловсронгуй болгох системтэй арга хэмжээ авах

7) Иргэдийн байгаль орчныг хайрлах, хамгаалах эрх зүйн мэдлэг, экологийн ухамсарыг нь дээшлүүлэхэд сургалт сурталчилгааны ажлыг системтэй, үр өгөөжтэй, эрчимтэй зохион байгуулах

8) Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжуудыг ард, иргэдэд сурталчлах, ойлгуулах ажлыг эрчимжүүлэх

9) Байгаль орчныг хамгаалахад иргэд, олон нийтийн туслалцаа дэмжлэгийг цаг алдалгүй авч, тэдэнтэй нягт хамтран ажиллах ажлыг зохион байгуулах нь чухал байна.

ХҮЧИРХИЙЛЭЛ ГЭМТ ЯВДАЛ БОЛОХ НЬ



*Г.Бямбадорж
ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн, цагдаагийн эрх зүйн
тэнхимийн багш, докторант*

Монголын төр ёсны үзэл хууль цаазны сэтгэлгээ нь хоёр мянга гаруй жилийн түүхтэй бөгөөд энэхүү хууль цааз нь Монгол хүний оюун санаа, ахуйн хэрэгцээнээс үүдэн гарч тэдний аж төрөх ёс, зан заншлын хэм хэмжээ, үзэл бодолтой хослон үйлчилж улмаар тэдний амьдралын ердийн хэвшил зуршил болсоор иржээ.²⁰

Монголын ард түмэн эрт дээр үеэсээ хүнийг зөв нийгэмшүүлэх, төлөвшүүлэх, гэмт хэрэг, алив муу үйлдэлгүйгээр хотлоороо амар амгалан амьдрах нүүдэлчний өвөрмөц соёлтой, өөрөөр хэлбэл криминологийн өндөр соёл, сэтгэлгээ дадалтай байсаар ирсэн бөгөөд гэмт хэрэг, гэмт хэргийн шалтгаан нөхцөл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гэх мэт орчин үеийн эрх зүйн ойлголт, ухагдахуун нэр томъёо байхгүй байсан ч гэсэн худал хэлэлгүй, хулгай хийхгүй, архи уухгүй, хэрүүл зодоон хийхгүй гэсэн социологийн ухагдахууныг сайн эзэмшсэн ийм ч учраас хууль гаргаж, хуулиар нийгмийн амьдралыг зохицуулах шаардлагыг урьдчилан үгүйсгэж чаддаг байжээ.²¹

Хүчирхийлэл хэмээх ойлголт нь гэмт явдал хэмээх нийгмийн сөрөг үзэгдлийг судалдаг криминологийн шинжлэх ухаантай салшгүй холбоотой учир энэхүү хүчирхийлэл хэмээх ойлголтыг криминологийн шинжлэх ухаантай холбон авч үзье.

Криминологийн нийгмийн ухааны болон шинжлэх ухааны бусад салбаруудтай харьцуулбал харьцангуй залуу шинжлэх ухаан гэж ойлгож болно. Өөрөөр хэлбэл, шинжлэх ухаан мөн гэсэн өдий төдий шалгуур тавьдаг үзэл баримтлалд бүрэн нийцэж эхэлсэн үед нь саяхан буюу 18-р зууны сүүл үеэс 19-р зууны эхэн байсан гэсэн үг. Энэ бол классик буюу сонгодог криминологийн үүссэн түүхэн хугацаа.

Криминологи гэдэг нь латин гаралтай “Crimenise” гэмт хэрэгт²² грек гаралтай “Logis”-судлал, сургааль гэсэн агуулгыг нэр томъёоны хувьд илэрхийлдэг. Энэ нь гэмт хэргийг судлахгүйгээр түүнтэй тэмцэж, урьдчилан сэргийлж чадахгүй, хэрвээ зөв судалбал аюулаас хол байж чадна гэсэн хэрэг билээ.

²⁰ М.Мөнхбаяр. Хулгайлах гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэж байсан Монгол улсын хууль тогтоомжийн хөгжилт, УБ 1999. 3 дахь тал

²¹ Ж.Болдбаатар, О.Нямдаваа. Криминологи-1, УБ., 2010. 60 дахь тал

²² Тухайн цаг үед Crimenise гэдэг нэр томъёог одоогийнх шиг гэмт хэрэг гэсэн утгаар бус хууль дүрмээр хориглосон аливаа үйлдэл эс үйлдэхүй гэсэн утгаар хэрэглэж иржээ.

Гэхдээ гэмт хэрэг гэдэг нэр томъёо нь гэмт явдал гэсэн ойлголтоос сүүлд үүссэн. Crime буюу гэмт хэрэг гэдэг нэр томъёо нь Англид шүүх үйл ажиллагаа үүсэж байх үед буюу 1166 онд Генрих-2 хаан Кларидон хотноо Ассизамын эхлэлийг тавьсан үеэс бий болсон гэж үздэг.²³

Олонхи хүмүүс криминологи нь гэмт хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар судалдаг гэж үздэг. Энэ нь ойлгомжтой боловч урьдчилан сэргийлэх гэсэн ойлголт нь криминологийн судлах зүйлийн нэгээхэн хэсэг учир энэхүү зорилгыг хэрэгжүүлэхийн тулд юуны түрүүнд гэмт явдал хэмээх нийгмийн сөрөг үзэгдэл, түүний онцлог мөн чанар, хор уршиг, гэмт явдлын шалтгаан нөхцөл, хохирогч болон гэмт бие хүний онцлог тэдгээрийн төлөвших зүй тогтол, урьд авч хэрэгжүүлж байсан урьдчилан сэргийлэх арга хэмжээ түүний нийгэмд үзүүлэх нөлөө зэргийг судалсны үндсэн дээр урьдчилан сэргийлэх арга замыг хэрхэн зөв хэрэгжүүлэх арга замын боловсруулж хүссэн үр дүндээ хүрдэг.

Нийгэмд ямар нэгэн дэвшил гарах, шинжлэх ухааны технологийн нээлт, ололт амжилт зэрэг хүн төрөлхтөний сайн сайхан үйлсэд нэмэр болох зүйл бий болохын хэрээр түүнийг дагаад элдэв сөрөг үзэгдлүүд байнга бий болж өөрчлөгдөж байдаг.

Аливаа гэмт явдлыг нийгэмд хурдацтай, өргөн хүрээгээр тархсан хойно түүнтэй тэмцэхэд хүндрэл учрахаас гадна их хэмжээний хөрөнгө, хүн, хүч шаардагдах болно. Мөн тухайн гэмт хэрэг нийгэмд тодорхой хэмжээний өөрийн гэсэн байр суурь эзэлж улмаар түүнтэй тэмцэх тодорхой байгууллагыг байгуулахад элдэв саад бэрхшээлийг гэмт бүлэглэл болон хувийн сонирхол бүхий этгээдүүд учруулах боломж бий болно. Тийм учраас практикт шинээр үйлдэгдэж байгаа гэмт явдал, түүний дотор хүчирхийллийн гэмт явдлын шалтгаан, нөхцлийг судлаж, түүнтэй тэмцэх, түүнийг үндэс сууриар нь таслан зогсоох бодлого боловсруулах шаардлагатай байдаг.

Зарим тохиолдолд нийгмийн сөрөг үзэгдэл болох хүчирхийлэл бий болсноороо гэмт явдалтай тэмцэх шинжлэх ухааны төрөл бүрийн салбарууд түүний дотор криминологийн онол сургааль, нэр томъёог бий болгох судалгааны шинэ чиглэлийг бий болгох боломжтой.

Хүн амын аюулгүй байдал, тайван амгалан амьдралыг бий болгоход хүний эрхийг дээдлэн хүндэтгэгч улс орон нэн тэргүүний зорилтоо болгож буй энэ цаг үед дэлхийн криминологийн хөгжлийн чиг хандлага илүү хэрэглээ талруугаа хөгжсөөр байна. Жишээлбэл, криминологийн онолыг төрийн бодлого боловсруулахаас эхлэн барилга архитектур, аялал жуулчлалд хүртэл ашиглах болсон.

Орчин үед криминологийн сэтгэлгээ өөр болж бөгөөд криминологи нь зөвхөн гэмт явдал, түүний шалтгааныг судлаад зогсохгүй "Хүн амын аюулгүй байдал, хүмүүсийн хүнсний хэрэглээ, тээврийн хэрэгслийн аюулгүй байдлын тухай, хүн амын эрүүл мэнд, байгаль орчин, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал" зэрэг өргөн хүрээтэй зүйлүүдийг анхааралдаа авч, заримыг нь шийдвэрлэхсэн байна.

Эрүүл аюулгүй орчинд тайван амьдрах гэсэн ойлголт хүн төрөлхтөний мөнхийн хүсэл мөрөөдөл гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл эрүүл аюулгүй, хүчирхийлэлгүй амьдрах бололцоо нөхцөлийг бүрдүүлэхэд криминологи зайлшгүй байх ёстой.

Бие хүнийг төлөвшүүлэхэд шашны үзэл номлол гол үүрэг гүйцэтгэдэг. Шашин нь нэг талаас хүмүүст дуулгавартай ноомой байдлыг, нөгөө талаас энгийн даруу амьдрахыг номлодог ч энэ нь зарим тохиолдолд хүч хэрэглэх, хүчирхийлэл үйлдэхэд нөлөөлж байна.²⁴ Тухайлбал, бид хэвлэл мэдээллийн хэрэгслээр шашны зарим урсгал чиглэлд

²³ В.Фокс, Введение в криминологию, М.,Прогресс, 1980.,, 36 стр

²⁴ С.М.Иншаков, Зарубежная криминология, М., 1997, стр 5.

итгэгчид амиа золиослон хүчирхийлэл үйлдэж, бусдад онц их хэмжээний хохирол учруулж байгаа тухай бараг өдөр бүр сонсож байна.

Түүхийн сурвалжаас үзэхэд МЭӨ 4-3 мянган жилд эртний Египет, Вавилон, Энэтхэгт шашин нийгмийн амьдаралд хамгийн хүчтэй нөлөө үзүүлж байжээ. Гэмт хэрэгт үзүүлэх шашны нөлөө цусан өшөөтэй төстэй байв. Ялгаатай тал нь гэвэл шашин хүн бурхан болсны дараа ч гэсэн үйлдсэн нүгэлийнхээ төлөө шийтгэл хүлээнэ гэж номлодог байв.

Шашин зөвхөн муу муухай үйлдлийг биш бодол санааг ч гэсэн хамгаалдаг байв. Нийгмийн хамгааллын энэ практикийг улс гүрнүүд өргөн хэрэглэдэг байсан нь нэгэнт нотлогдсон байдаг.

Хүмүүжлийн аргаар гэмт явдлаас урьдчилан сэргийлэх боломжийн талаар Кунфуций, Пифагор, Демокрит, Сократ зэрэг эртний философичид бичжээ. Уг сургаалыг баримтлагч Японы эрдэмтэд Кунфуцын таван тогтвортой ойлголт гэдгийг бий болгожээ. Энэ нь албад нь эзэн хаандаа эхнэр нь нөхөртөө, дүү нь ахдаа, хүү эцэгтээ, захирагдах явдал ёстой гэж үзжээ.

Өнөө үед Японд гэмт хэргийн тоо дэлхийд хамгийн бага байгаа нь үүнтэй холбоотой гэж тайлбарлажээ. Пифагор эртний Грек дэх иргэний хүмүүжлийн үндсийг тавьжээ. Демократ хүмүүжлийн аргаар гэмт хэрэгт нөлөөлөх, хүн болон түүний эд хөрөнгийн хамгаалах үзэл санааг хөгжүүлжээ.

Сократ гэмт хэргийн уг сурвалжийг залуучуудын хүмүүжил, хүмүүсийн гэгээрлийн доголдолтой холбон үзэж байв. Грекэд гэр бүл нь бие бялдар, ёс суртахууны хувьд эрүүл хүүхэд төрүүлэх гол үүрэгтэй гэж үзэж байв. Платон гэмт хэргийн уг сурвалжийг нийгмийн тэгш бус байдал өөрөөр хэлбэл баян ядуугийн түвшинтэй холбон тайлбарлаж байв.

Харин Аристотель өөрийн зохиол бүтээлдээ гэмт хэргийн шалтгааныг ядууралтай холбон өрөөсгөл тайлбар хийсэн байдаг.

Харин бид хүчирхийлэл хэмээх нийгмийн сөрөг үзэгдлийг криминологийн шинжлэх ухаантай холбон авч үзлээ.

Хүчирхийлэл нийгмийн үзэгдэл

Хүчирхийллийг явцуу утгаар нь тодорхойлбол: Хүчирхийлэл гэдэг бол тодорхой цаг хугацаанд үйлдэгддэг нийгэм, эрх зүйн эсрэг чиглэсэн, түүхэн өөрчлөлттэй, түгээмэл сөрөг үзэгдэл юм.

Энэ үзэгдэл нь тодорхой цаг үеийн дотор олон улсын хэмжээнд, улсын хэмжээнд эсхүл аймаг, хотын хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил, ёс суртахууны зэрэг нийгэмд үйлдэгдэж байгаа аливаа хэрэг зөрчлийн нийлбэр цогц юм. Өөрөөр хэлбэр хүчирхийлэл бол гэмт явдлын нэг төрөл юм.

Хүчирхийлэл нь гэмт явдлын энгийн нэгэн нийлбэр биш тэр нь өөрийн зүй тогтолтой, дотоод зөрчилтэй, нийгмийн бусад үзэгдлүүдтэй нягт холбоотой нийгмийн сөрөг үзэгдэл.

Хүчирхийлэл нь хүн төрөлхтөнтэй хамт үүсэж, нийгмийн хөгжлийг даган өөрчлөгдөн хувьссаар ирсэн, зайлшгүй шинжтэй, нийгмийн сөрөг үзэгдэл бөгөөд хүний субъектив үзэл санаатай холбоотой нийгэмд үүссэн гэж бид үзэж байна.

Хүчирхийлэл үйлдэж байгаа этгээдүүд болон хүчирхийллийн улмаас хохирогсод нь нийгмийн гишүүд байдаг, гэмт хэргийн хор уршиг нь нийгмийн гишүүдэд эд материалын болон оюун санааны хохирол учруулаад зогсохгүй нийгмийн хөгжлийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлдөг.

Түүнчлэн нийгмийн амьдралын нийгэмд аюултай үр дагвар нь хүчирхийлэл бөгөөд нийгэмд хор хөнөөлтэй байдаг учраас түүнтэй тэмцэх шаардлагатай болдог. Гэхдээ аль

болох нийгмийн арга хэлбэрээр тэмцдэг ба хүчирхийллийг хянаж, хазаарлаж жолоог нь татахад нийгмийн арга хамгийн үр дүнтэй²⁵.

Хүчирхийллийн шалтгаан нь нийгмийн мөн чанартай бөгөөд нийгэмд бодитойгоор оршин буй ажилгүйдэл, ядуурал, архидалт, өшөө хорсол зэрэг нь хүчирхийлэл үйлдэгдэх үндэс суурь болж байдаг зэргээс үзэхэд хүчирхийлэл нь нийгмийн үзэгдэл гэдэг нь харагдаж байна.

Хүчирхийлэл түүхэн үзэгдэл

Хүн төрөлхтөний түүхэнд нийгмийн янз бүрийн байгуулалд хүчирхийлэл оршин тогтнож, хувьсан өөрчлөгдсөөр өнөөг хүрчээ.

Нийгэм хувьсан өөрчлөгдөхийн хамт гэмт хэрэгт тооцогдож байсан үйлдэл нь гэмт хэрэгт тооцогдохгоо болих (декриминализация), гэмт хэрэгт тооцогдохгүй байсан үйлдлийг шинээр гэмт хэрэгт тооцох (криминализация) үйл явц байнга явагдсаар байдаг.

Гэхдээ ямар ч нийгэмд хүчирхийлэлд тооцддог, гэмт явдлын цөмийг бүрдүүлдэг гэмт хэргүүд гэж байдаг. Тухайлбал, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Гэмт хэргийн тухай хуулийн төслийн 11.8-д заасан нь цаг үеэ олсон (криминализация) юм.

Түүнчлэн сүүлийн жилүүдэд үйлдэгдэх болсон хүн худалдаалах, хүний орон байранд хууль бусаар халдах, хүний цус, эд, эрхтнийг хууль бусаар авах, хорлон сүйтгэх, зандалчилах, терроризмыг санхүүжүүлэх, жагсаал цуглаан хууль бус үйл ажиллагаанд уриалах, түүнийг нийтийн өмнө зөвтгөх зэрэг гэмт хэргүүдийг өнгөрсөн эрт цаг үед хуульчлан хориглох боломжгүй байсан нь тодорхой ба энэ бүхнээс харахад гэмт явдал нь түүхийн явцад хувьсан өөрчлөгдөж байдаг үзэгдэл гэдэг нь харагдана.

Хүчирхийлэл эрх зүйн үзэгдэл

Хүчирхийлэл нь эрх зүйн зөрчлийн нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд эрх зүйн хэмжээгээр хориглосон, зөрчигдөх явдлаас хамгаалагдсан, зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэдэг зэрэг тулгуур шинжийг өөртөө багтаасан байдаг.

Хүчирхийлэлтэй холбоотой ямар үйлдэл эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцож хуульчлах, эсвэл үл тооцох агуулгатай гэмт хэргийн тухай хуулийн өөрчлөлт нь аяндаа гэмт явдлын үзүүлэлтэнд нөлөөлдөг.

Хүчирхийллийн аюултай хэлбэрийг гэмт хэргийн тухай хуульд зааж өгснөөр хэвийн бус зан үйл нь хүчирхийллийн гэмт явдал болж, гэмт явдал нь харьцангуй тодорхой, эрх зүйн үзэгдэл болж хувирдаг.

Энэ шинж нь тухайн орны Эрүүгийн хуульд ямар үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцож байна гэдгээс шалтгаалан гэмт явдлын бүтэц тодорхойлогдоно.

Түүнчлэн тухайн улс орны хууль сахиулах байгууллагуудын гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаагаатай холбоотой байж болох юм.

Гэмт хэрэг нь нийгмийн төдийгүй эрх зүйн үзэгдэл бөгөөд аливаа эрх зүйн хэм хэмжээ нь нийгмийн суурь харилцааг зохицуулж байдаг ба гэмт хэргийн бүрэлдэхүүнийг шинжийг тодорхойлсон заалт нь нэмэлт, харин суурь биш юм. Энэ нь нийтээр хүлээн зөвшөөрсөн хуульд заасан тохиолдолд гэмт хэрэг гэсэн үзэл баримтлалтай хобоотой юм²⁶.

Хүчирхийлэл зүй тогтолт, бодит үзэгдэл

Хүчирхийлэл нь тодорхой шалтгаанаар нөхцөлдсөн эдийн засаг, улс төр, үзэл суртал, нийгмийн сэтгэл зүй, удирдлага зохион байгуулалт зэрэг бусад нийгмийн үзэгдлүүдтэй харилцан холбоотой зүй тогтолт үзэгдэл төдийгүй нийгэм, улс төр, эдийн засгийн бүх

²⁵ Ж.Болдбаатар, О.Нямдаваа. Криминологи-1. УБ., 2010.30 дахь тал

²⁶ Малков В.Д. Криминология: Учебник, 2011 г, 25 страница

хэлбэршлийн үед нийгмийн хөгжлийн зөрчлийн сөрөг үр дагавар болж оршин ирсэн бодит үзэгдэл юм.

Марксистууд, коммунистууд... гэмт явдал бол ангийн шинжтэй, коммунист нийгэмд байхгүй болох түр зуурын үзэгдэл гэж үзэж байсан нь нотлогдсонгүй, харин хүн төрөлхтөнтэй хамт л үүссэн, хүн төрөлхтөнтэй л үгүй болох магадлалтай бодит үзэгдэл учир түүнийг устгах тухай ярих бус гагцхүү багасгах, урьдчилан сэргийлэх, хяналт тавих тухай л ярьж болно гэдгийг өнөөдөр судлаачид нэгэнт тогтоогоод байна.

Иймээс гэмт явдал бол хүний нийгэм оршин байгаа цагт байх л учиртай зүй тогтолт үзэгдэл бөгөөд энэ талаар АНУ-н эрдэмтэн Френк Танненбаум “Хүчирхийлэх явдал бол нийгэмтэй адилхан мөнхийн зүйл” хэмээн гэж томъёолсон байдаг.

Хүч хэрэглэсэн гэмт явдал бол гэмт хэргүүдийн цогц мөн

Хүч хэрэглэсэн гэмт явдал нь тодорхой гэмт хэргүүдийн механик нэгдэл бус өөрийн зүй тогтлоороо нэгдмэл, нэг нь нөгөөтэйгээ харилцан холбоо хамааралд байдаг бодит үзэгдэл юм. Хүчирхийллийн агуулгыг судлахад түүнийг бүрдүүлж буй гэмт хэрэг бүрийг тусад нь салгаж судлах боломжгүй юм.

Хүчирхийлэл нь тодорхой засаг захиргааны нэгж, нутаг дэвсгэрт тодорхой цаг хугацаанд үйлдэгдсэн гэмт хэргүүдээс бүрддэг ба хүчирхийллийг олон гэмт хэргүүдийн нэгдэл, нэг бүхэл системийг агуулсан нийгмийн үзэгдэл гэж ойлгох бөгөөд тэр нь аяндаа бий болдог, зориуд зохион байгуулж болдоггүй үзэгдэл байдаг.

Хүчирхийлэл нь бусад нийгмийн үзэгдлүүдтэй нягт холбоотой нийгмийн сөрөг үзэгдэл юм. Хүчирхийлэл нь хүн төрөлхтөн оршин тогтнож ирсэн бүхий л хугацаанд түүний үр дагавар болж ирсэн нийгмийн сөрөг үзэгдэл юм.

Хүчирхийлэл нь гэмт хэргийн цогц нийлбэрээс бүрдэх нэгдмэл ойлголт бөгөөд нэг төрлийн үзэгдлүүдийн нэгдэл биш бодит байдлаараа маш олон төрлийн бие даасан гэмт зан төлөвийн нэгдэл юм²⁷.

Харин гэмт хэрэгт эдгээр шинж байхгүй бөгөөд гэмт хэрэг нь хүний бие даасан ухамсартай үйл ажиллагаа, тодорхой бие хүний гэмт санаа бодлын үр дагавар юм.

Ямарваа гэмт хэргийн учирч болох хор уршгийг гаргуулахгүй нэмэгдүүлэхгүй байх боломжтой. Өөрөөр хэлбэл ямар ч гэмт хэргийг урьдаас мэдсэний үндсэн дээр урьдчилан сэргийлж таслан зогсоож болно. Харин нийгмийн үзэгдэл болох хүчирхийллийг бүрмөсөн таслан зогсоох, устгах боломжгүй.

Хүчирхийллийн гаралтын байдал, бүтэц, учруулах хор уршгийн хэр хэмжээ, үйлдлийн шинж, чанар нь нийгмийн хөгжлийн явцад өөрчлөгдөж ирснээр нь түүнийг түүхийн үзэгдэл гэж үздэг. Нийгэм эдийн засгийн янз бүрийн нөхцөл байдлын үед хүчирхийллийн гаралтын байдал, бүтэц, хандлага, шалтгаан, нөхцөл нь өөрчлөгдөж байдаг.

Хүчирхийлэл бол “Deviant” гэмт зан үйлийн илрэл юм.

Хүчирхийлэл бол Deviant буюу гэмт зан үйлийн илрэл юм. Гэмт зан үйл нь бодит биш боловч тэрхүү гэмт зан үйлээ хэрэгжүүлсэн тохиолдолд эрх зүйн зөрчил болдог. Өөрөөр хэлбэл гэмт зан үйл нь хүний гэмт санаа бодол бөгөөд тухайн этгээд ямар хэлбэрийн гэмт зан үйлийг хэрэгжүүлнэ тэр нь нийгмийн хор аюулын хэр хэмжээ, учруулсан хохирол, гэмт үйлдлийн шинж чанар зэргээс шалтгаалж хуульд заасан тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчил болж тэрхүү үйлдэлд хуулийн хариуцлага хүлээлгэдэг. Нөгөө талаар хүний гэмт зан үйл нь бодит зүйл биш хийсвэр учир хууль зүйн хариуцлага хүлээлгэж болохгүй²⁸.

²⁷ <http://www.delo-grabovogo.ru/i>

²⁸ <http://www.delo-grabovogo.ru/i>

Хүний гэмт зан үйлд хариуцлага хүлээлгэх нь хууль ёсны зарчим, тэгш байдлын зарим, шударга ёсны зарчим зэрэг хууль зүйн тулгуур гол зарчмуудад халдсан үйлдэл болж хүний гэмт зан үйлийн үндсэн шинж чанар алддаг.

Ийм учраас нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс суртахууны шашны болон бусад хэм хэмжээг ямар ч нийгэм оршиж байгаа гажсан хандлагыг ямар нэг зан гэж үзэж гэмт хэрэгтэй холбогдуулан судлах шаардлагатай²⁹.

Одоогоор хүчирхийллийн шинж, чанарыг цогц байдлаар томъёолсон нэр томъёо, ойлголт одоогоор байхгүй бөгөөд бид хүчирхийллийн тухай ойлголтыг дараах байдлаар тодорхойлж болох юм. Хүчирхийлэл гэдэг нь: улс орон, ард иргэдийн хууль тогтоомжоор хамгаалагдсан эрх, эрх чөлөөг зөрчиж гэм хор учруулсан, эсвэл тэр хор уршигийг учруулахаар заналхийлсэн, хүч түрэмгийлсэн, дарамт шахалт үзүүлсэн, хууль бусаар нэвтэрсэн, халдсан, дайрч довтолсон, эвдэж сүйтгэсэн, устгасан зэрэг нийгэм, эдийн засаг, ёс суртахуунд хохирол учруулсан хууль тогтоомж болон олон улсад үйлчлэх гэрээ конвенц, хууль дүрэм, заншлуудыг ноцтойгоор зөрчсөн үйлдэл эс үйлдэхүй хэмээн тодорхойлж болохоор байна. Мөн түүнчлэн хүчирхийллийн хамгийн түгээмэл төрөл болох гэр бүл дэхь хүчирхийлэлтэй тэмцэх талаар төрөөс нэгдсэн бодлого боловсруулж, нийгэм дэх сөрөг үйлдэл болсон эл үйлдэлтэй тэмцэх, эдийн засаг, улс төр, эрх зүй, зан заншил, соёл, ёс суртахуун болон хүмүүжлийн, нэгдмэл зохион байгууллалтын шинжтэй арга хэмжээг цогцоор нь авч хэрэгжүүлэх шаардлага тулгарч байгааг тэмдэглэх нь зүйтэй.

²⁹ Малков В.Д. Криминология: Учебник, 2011 г, 544 стр.



ТҮҮХ СОЁЛЫН ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙГ ХАМГААЛАХ ЗАРИМ АСУУДАЛ

Д.Бямбахүү

*ХСИС-ын Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн
тэнхимийн багш, цагдаагийн хошууч*

Монгол улс 1990 онд ЮНЕСКО-ийн 1972 оны Дэлхийн өвийн конвенцид, 1991 онд Соёлын эд зүйлсийг хууль бусаар импортлох, экспортлох, өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх тухай 1970 оны конвенцид тус тус нэгдэн орсон. Энэ нь соёлын өвийг хамгаалах үйлс болон түүний эрх зүйн орчныг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой болсон. Үүний өмнө 1964 онд Монгол улс Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах тухай 1954 оны Гаагийн хэлэлцээрт нэгдэн орж түүний үзэл санаа, зорилтыг хүлээн зөвшөөрч тууштай дэмжиж ирсэн юм.

Эцэг өвгөд дээдсийн үеэс бидэнд өвлөгдөн, одоо бидэнд байгаа, ирээдүй хойч үедээ өвлүүлэн үлдээх хойч үе маань түүнийг судалж, суралцаж, түүнийг гайхан биширч, Монгол гэх агуу нэрийг бахархан байх үүднээс бидэнд үлдээсэн аливаа зүйлийг “Өв” гэж хэлнэ. Монгол улсын Соёлын тухай хуулийн 3.2, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 3, 4 дүгээр зүйлд заасан түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлж чадах түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны ач холбогдол бүхий эд зүйлсийг нийтэд нь соёлын өв гэнэ³⁰. Соёлын өвийг биет, биет бус гэж хоёр ангилдаг ба биет өвийг дотор нь хөдлөх, үл хөдлөх гэж 2 хувааж үздэг байна.

Биет өвийн хөдлөх дурсгал гэдэгт музейн үзмэр, сүм хийд, хувь хүнд хадгалагдаж байгаа эд өлгийн зүйлс хамаарна. Биет өвийн үл хөдлөх дурсгал гэдэгт хээр хөдөө оршиж буй эртний булш хиргисүүр, хадны сүг зураг, бичээс хөшөө чулуу, эртний хот, сүм хийдийн туурь зэрэг археологи, палеонтологи, уран барилгын дурсгал хамрагддаг³¹.

Биет бус өвд Монголын ард түмний оюун санаагаар бүтсэн эх хэл, ардын зан заншил, мэдлэг ухаан, дуу хөгжим, наадам, ардын арга ухаан, уламжлалт технологи зэрэг соёлын өвийн олон төрөл багтана.³²

Соёлын өвийг “Түүх, соёлын дурсгалт зүйлийг түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдлоор нь хосгүй үнэт, үнэт, ердийн гэж зэрэглэнэ” гэж зэргэлээд 2004 оны 4 дүгээр сарын 16-ны өдрөөс “Түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэл, үнэлгээг холбогдох музей, эрдэм шинжилгээний байгууллагын саналыг үндэслэн соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх мэргэжлийн зөвлөл тодорхойлдог” болсон байна.

³⁰ Монгол улсын соёлын тухай хууль 1996 он

³¹ Монгол улсын соёлын өвийг хамгаалах тухай хууль 2001 он

³² Монгол улсын соёлын өвийг хамгаалах тухай хууль 2001 он

Манай улс, орон нутгийн музейнүүдэд 205 000 гаруй түүх, соёлын дурсгалт зүйлс хадгалагдаж байгаагийн 289 нь хосгүй үнэт дурсгал байна. Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд 8800 гаруй түүх, соёлын үл хөдлөх дурсгал бүртгэгдсэн байдаг. Монгол Улсын засгийн газрын 2008 оны 175 дугаар тогтоолоор баталсан “Улс, аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-ыг баталсан. /улсын хамгаалалтанд 175, аймгийн хамгаалалтанд 275 дурсгал байна/.

Монгол Улсад албан бус тоогоор 300 гаруй сүм хийд, 60 орчим музей байдгаас нийслэлд 36 нь үйл ажиллагаа явуулдаг. Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас үнэт эдлэл, өв соёлын түүх, дурсгалыг хадгалж буй аймаг, нийслэлийн музейд 2008 онд хийсэн шалгалтаар 3100 үзмэр сох дутаж, 5000 гаруй үзмэрийг актлахаар бичиг баримт бүрдүүлэн, 6000 гаруйг нь гаднын улс орны үзэсгэлэнд орж байгаа гэж мэдүүлж байжээ³³. Гэхдээ гадны аль улсад, ямар нэртэй үзэсгэлэнд тавигдаж байгаа нь тодорхойгүй, гэрчлэх баримтгүй байсан гэдэг. Түүнчлэн Дундговь аймгийн музейгээс гурван гуулин бурхныг шавраар хийж орлуулсан тохиолдол ч уг шалгалтаар илэрсэн гэдэг. Түүнээс хойш хэчнээн нь устаж, гэмт хэргийн замаар орсон нь тодорхойгүй байна. Учир нь Монгол Улс дөрвөн жил тутамд нэг удаа л үнэт, соёлын дурсгалаа тоолдог.

Манай улсад 2008 онд 79, 2009 онд 119, 2010 онд 89, 2011 онд 54, 2012 онд 66, 2013 онд 58 түүх, соёлын хосгүй үнэт бүтээлийг хулгайлж, дээрэмдсэн 465 гэмт хэрэг цагдаагийн байгууллага бүртгэгджээ³⁴. Уг гэмт хэргээс түүх соёлын дурсгалт эд зүйлээр улсын бүртгэлд бүртгэгдсэн эд зүйл алдагдсан гэмт хэрэг сүүлийн 3 жилд 2 гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Бусад 463 гэмт хэргийн алдагдсан эд зүйл нь түүх соёлын дурсгалт зүйлээр улсын бүртгэлд бүртгэгдээгүй нь хулгайлах дээрэмдэх гэмт хэргээр шалгагджээ. Дээрх 465 гэмт хэргийн 212 буюу 45,5 % нь шүүхээр шийдвэрлэгдсэн байна. Үүнээс үзэхэд иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад хадгалагдаж байгаа түүх соёлын дурсгалт зүйл нь улсын бүртгэлд бүртгэгдээгүй байдаг нь харагдаж байна.

Мөн өнгөрсөн дөрвөн жилд улсын хилээр 23 нэр төрлийн 325 ховор эд зүйл гаргах гэж оролдсоны 93 нь шашны, үлдсэн нь түүхийн ховор, дахин давтагдашгүй үнэт, хосгүй үр хийцтэй эдлэл байсан гэдгийг албаныхан тэмдэглэсэн байна. Гэхдээ энэ бол зөвхөн албан ёсны тоо. Дээрх үзмэр, соёлын үнэт зүйлсийг хэн авсан байж болох вэ? Албаны эх сурвалжийн өгүүлснээр ихэвчлэн сүм хийд, музейн харуул, манаач, хариуцсан албан тушаалтан энэ төрлийн хэрэгтэй шууд холбогдсон байна. Тухайлбал, Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын нутагт байрлах хийдээс бурхан, цөгц, судар, шастир зэрэг 15 нэр төрлийн үнэт зүйл алга болжээ. Цагдаагийн байгууллагаас дээрх эд зүйлийг эрэн сурвалжлахад, тус хийдийн манаачаар сүүлийн арав гаруй жил ажилласан гэр бүлийн хоёр хүн Улаанбаатар хотын эртний эдлэл борлуулдаг хүмүүст хямд үнээр зардаг байсан нь тогтоогдсон. Мөн үндэсний түүхийн музейн сан хөмрөгийн эрхлэгч асан Б.Энхбатын 1073 ширхэг үзмэр, дурсгал хулгайлан, заримыг нь бусдад дамласан хэргийг үйлдсэн байдаг. Энэ мэтээр аймаг, сүмдын сүм хийдээс хичнээн бурхан, судар, бусад зүйл алдагдаж байгааг мэдэх аргагүй. Үүнд тавих хяналт, хууль эрх зүйн орчин ч манай улсад хангалтгүй байгааг харуулж байна.

Түүх соёлын дурсгалын наймаа дэлхийд ашиг орлогоороо тэргүүлдэг. Гэхдээ эл наймааг ихэнх тохиолдолд хууль бус аргаар хийдэг. Улс орны оршин тогтнохуйн баталгаа болсон түүхийн хосгүй ховор дурсгал, хэдэн мянганы тэртээ урласан эд өлгийн зүйлийг хулгайн замаар хил гаргаж худалдах явдал манай улсад ч дэлгэрэх хандлагатай байна. Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалахаас илүүтэйгээр хулгайч нарын эрх ашиг дээгүүрт

³³ Түүх соёлын дурсгалт зүйл түүнд тавих хяналт 2010 он

³⁴ Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл судалгааны төвийн мэдээлэл 2014 он

тавигддаг гэж зарим судлаачид үздэг. Товчхондоо ашиг олж л байвал улс орны түүх, тусгаар тогтнол хамаагүй хэмээн сэтгэж гадаадын иргэдтэй үгсэн тохиролцож эд зүйлээ гадагш зөөдөг хэсэг бүлэглэл Монголд байна. Тухайлбал, Монгол Улсын балар эртний чулуужсан ясыг хамгаалах өргөн цар хүрээг хамарсан соёлын өв хөрөнгийн тухай хууль байдаг. АНУ-ын Вайоминг муж улсын Прокурорын газар холбооны нэлээд хэдэн агентлагтай хамтарч мөрдөн шалгасны эцэст Монголоос хэдэн сая ам.доллараар үнэлэгдэх Тираннозавр “Батаар” араг ясыг эх нутагтаа авчирсан нь саяхны хэрэг билээ³⁵. Энэ араг ясыг олборлохоос эхлээд хил гаалиар гаргахад тодорхой албан тушаалтан орлцсон нь дамжиггүй юм. Дундговь аймаг түүх соёлын өв, дурсгал ихтэй газар. Ийм дурсгалт газруудын нэг нь тус аймгийн Баруун Чойрын хийд. Энэ хийдэд хадгалагдаж байдаг Өндөр гэгээн Занабазарын урласан Ногоон дарь эх бурхан таван удаа алдагдсан. Цагдаагийн байгууллага алдагдсан бурхныг дөрвөн удаа олж өгсөн байдаг. Ногоон дарь эх бурханыг хулгайлсан этгээдүүд баригдсаныхаа дараа “Хятадуудын захиалгаар хулгай хийсэн” хэмээн мэдүүлсэн удаатай. Гэтэл энэ бурхныг харуул хамгаалалт муугаас дахин хулгайд алдсан. Хамгийн сүүлд алдагдсанаасаа хойш одоог хүртэл олдоогүй байна.

Үндэсний түүхийн музейгээс Богд хааны хэрэглэж байсан тамганы дууриамал нь алдагдсан. Хэргийн эзнийг өнөөдөр ч олоогүй байна. Жинхэнэ нь алдагдсан бол ингээд л олохгүй өнгөрөх байлаа. Цайны цаг ашиглаж орсон этгээд шилэн хоргыг хагалж тамгыг авч зугтсан байдаг. Манайхан түүх соёлын үнэт өвд хэрхэн ханддаг нь эл хэргүүдээс тодорхой харагдаж байна.

Өндөр хөгжилтэй оронд түүх дурсгалаа телекамер, дохиолол хамгаалалтаар хянаж байдаг. Түүх дурсгалд гар хүрэхийн төдийд дохиолол дуугарч хэрэгтэн баригдана. Харин манайд манаач, сахиул нэртэй хөгшин голдуу хүмүүс түүх дурсгалыг хамгаалдаг. Дохиолол хамгаалалтын системгүй сүм хийдэд захын хулгайч ч нэвтэрч манаач, харуулыг ямар нэгэн байдлаар аргалан ховор дурсгалыг хулгайлах, дээрэмдэх нөхцөл байдалд хадгалж байна. Хамгаалж буй хүнийхээ амь насыг аюулгүй байлгах, түүх өгүүлэх эд өлгийн зүйлээ хамгаалах гээд аль ч талаа бодсон хяналтын камер, дуу чимээ өгөх дохиолол, хамгаалтын систем суулгах нь чухал. Хүнээр хамгаалахаас гадна дэвшилтэд техник, технологи өргөнөөр ашиглан түүх дурсгалыг хамгаалах нь хамгийн найдвартай.

Чехэд түүх дурсгалын зүйл худалдаалдаг тойргийг байнгын хяналтад авдаг. Хэн хэнд хэчнээн төгрөгөөр ямар бурхан зарсан. Тэр дэлгүүрт ямар, ямар хосгүй үнэт зүйл байгаа зэрэг нь бүгд бүртгэлтэй байдаг. Хэрэв бүртгэлгүй бараа зарсан бол тухайн эд өлгийн зүйл улсын орлого болгодог хариуцлагатай системийг тус улс тогтоож чадсан байдаг. Харин манай улсын дэлгүүрүүд хэнээс ямар үнээр юу худалдаж авсан, цааш нь хэрхэн дамласан зэрэг нь бүгд нууц. Хэрэгт холбогдсон хэн нэгэн нь эд өлгийн зүйл худалдаж авсан хүнээ танихгүй хэмээн хариуцлагаас мултардаг. Энэ мэтээр түүх дурсгалын эд зүйлд гадаадын иргэдийн гарт орсоор байна.

Түүх соёлын дурсгалт зүйлийг эрэн сурвалжлах ажиллагааг цагдаагийн байгууллагаас орон нутгийн хэмжээнд эрэн сурвалжлах, бүсийн хэмжээнд эрэн сурвалжлах, улсын хэмжээнд эрэн сурвалжлах, олон улсын хэмжээнд эрэн сурвалжлах гэсэн дөрвөн хэлбэрээр зохион байгуулдаг. Энэ төрлийн гэмт хэрэг нь илэрсэн байдлыг нь харахад маш нарийн зохион байгуулалтайгаар үйлдэгдэг дийлэнх олонх нь иргэдийн болон гүйцэтгэх ажлын мэдээллээр илэрсэн байна. Үүнээс үзэхэд хуульд түүх биет болон биет бус өвийг үнэлэх заалт байдаг ба археологи, палентлогийн олдвор олсон, илэрүүлсэн иргэнд урамшуулалын тогтолцоо байхгүй эдгээрийг гадагшаа өндөр үнээр зарах тохиолдол байсаар байна. Үл хөдлөх соёлын өвд багтдаг булш, бунханд дуртай цагтаа хэн хүссэн нь хууль бус малтлага хийгээд

³⁵ www.unen.mn

явдаг. Үүнийг хаа сайгүй л мэднэ иргэд мэдсэн ч мэдээгүй юм шиг царайлаад л өнгөрдөг. Тэгээд ч булш, бунханд нууцаар малтлага хийчхээд, дотроос нь гарч ирсэн эд өлгийн зүйлсийг авч ирээд ченжид өгөхөд ченж хариуцлага хүлээхгүй. Тиймээс зөвшөөрөлгүйгээр, бүртгэлгүй эд өлгийн зүйлс худалдан авахгүй гээд хуульчилж яагаад болохгүй гэж. Хувь хүн иргэн энэ төрлийн хосгүй үнэт өвийг нээж илрүүлсэн үед тэднээс худалдан авах, урамшуулалын тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай байна.

Малын гарал үүслийн гэрчилгээ гэж байдаг шиг түүх, соёлын хосгүй үнэт дурсгал, соёлын өвд бүртгэж байгаа бүх бүтээлийг хувийн дугаартай болгох зэргээр маш сайн бүртгэлийн механизм яаралтай бүрдүүлэх шаардлагатай байна. Дотооддоо хувь хүмүүсийн гараас гар дамжуулан худалдаалагдаж байгаа бүх бүтээлийг зөвхөн хувийн дугаартай тохиолдолд худалдан авах, худалдах тогтолцоог бий болгох зэргээр маш сайн бүртгэл, судалгаагаар хянавал бид түүх, соёлоо хамгаалж чадна.

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦДЭГ САНХҮҮГИЙН ТАГНУУЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ, ТУРШЛАГА

Ж.Төгс-Очир

Хууль сахиулахын их сургуулийн докторант

“Эгмонт” группын тодорхойлолтоор **санхүүгийн тагнуул гэж гэмт үйл ажиллагаа болон терроризмыг санхүүжүүлсэн гэж сэжиглэж буй орлого эсвэл мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх явдалтай тэмцэхийн тулд үндэстний хууль тогтоомж эсвэл бусад эрх зүйн хэм хэмжээний актаар шаардагддаг мэдээллийг олж авах, дүн шинжилгээ хийх улмаар тэдгээрийн үр дүнг эрх мэдэл бүхий байгууллагад шилжүүлэх үүрэг, хариуцлагыг хүлээсэн санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон төв банкны бүтцийн үндэсний төв байгууллагыг хэлнэ.**

Санхүүгийн мониторингийн холбооны алба санхүүгийн тагнуулын олон улсын байгууллага болох “Эгмонт” группын гишүүн болсон нь тухайн алба энэ байгууллагын үйл ажиллагааны стандартад нийцэж буйг хүлээн зөвшөөрсний илрэл бөгөөд Өмнөд болон Зүүн Европын орнууд болон бие даасан улс орнуудын холбоонд санхүүгийн тагнуулын салбар нэгжүүдийг байгуулахад зөвлөмж өгч туслалцаа үзүүлэх бүрэн эрхийг авах үндэслэл болдог.

ОХУ “Эгмонт” группт элсэн орсноор бүх дэлхийн санхүүгийн тагнуулын салбар нэгжүүд багтдаг хаалттай харилцаа холбооны тусгай системд нэвтрэн орох боломжийг олгосон юм. Гадаад орны салбар нэгжүүдэд санхүүгийн гэмт хэргийг системчлэх, илрүүлэх талаар ихээхэн туршлага хуримтлагдсан бөгөөд мэдээллийн санд нь зөвхөн өөрийн орны төдийгүй ОХУ-ын иргэдийн талаар мэдээлэл хадгалагдаж байдаг.

Эрдэм шинжилгээний зохиол бүтээлд санхүүгийн тагнуулыг хэд хэдэн төрлөөр ангилсан байдаг. В.Н. Мельников, А.Г. Мовсесян нар **Нэгдүгээрт**, төрийн эдийн засаг болон санхүүгийн байгууллагын дэргэд байгуулсан санхүүгийн тагнуул (энэ тагнуулын чиг үүрэг нь сэжигтэй хэлцлийн талаар мэдээлэл цуглуулах дүн шинжилгээ хийх, энэ талаар хууль сахиулах байгууллагад мэдээлэх явдал); **Хоёрдугаарт**, цагдаа болон бусад хүчний байгууллагын дэргэд байгуулсан санхүүгийн тагнуул (энд хүч хэрэглэсэн болон сөргөн шалгах ажиллагаанд гол анхаарлаа хандуулдаг) гэсэн 2 том бүлэгт хуваасан байна.³⁶

В.А. Зубков, С.К. Осипов нар тагнуулыг захиргаа, хууль хамгаалах, шүүх эсвэл прокурорын болон “холимог” гэсэн 4 үндсэн төрөлд³⁷ хуваажээ. Захиргааны төрлийн санхүүгийн тагнуул нь захиргааны байгууллагын бүрэлдэхүүнд ордог эсвэл бие даасан захиргааны байгууллага байдаг. Санхүүгийн тагнуулыг ихэвчлэн тухайн орны Сангийн яам эсвэл Төв банкны бүтцэд эсвэл хяналт дор байгуулдаг. Санхүүгийн ийм тагнуул нь мөнгө угаах гэмт хэрэгтэй холбоотой сэжиг бүхий мэдээллийг өгөх үүрэгтэй санхүүгийн байгууллага болон хууль хамгаалах байгууллагын хооронд зуучлагчийн үүрэг гүйцэтгэдэг нь нууцлалыг бүрэн хангах боломжийг бүрдүүлэг юм. Хууль хамгаалах тогтолцооны бүрэлдэхүүнд багтдаггүй ийм санхүүгийн тагнуул нь мөнгө угаахтай холбоотой байж болзошгүй үйл ажиллагааны талаарх материал дээр ажиллахад хязгаарлагдмал

³⁶ Мельников В.Н., Мовсесян А.Г. Противодействие легализации преступных доходов. М., 2007.С.224

³⁷ Зубков В.А., Осипов С.К. Российская Федерация в международной системе противодействия легализации /отмыванию/ преступных доходов и финансированию терроризма. М., 2006. С. 291

боломжтой байдаг. Үүний жишээ нь АНУ, Австрали, Испани, Бельги, Франц, Украйны санхүүгийн тагнуул юм.

Хууль сахиулах төрлийн санхүүгийн мониторингийн алба нь хууль сахиулах байгууллагын бүтэц, зохион байгуулалтад багтдаг учраас тэдний давуу тал нь шуурхай эрэн сурвалжлах ажил явуулах, дансны активыг битүүмжлэх зэрэг эрх мэдлийг эдэлж, хууль хамгаалах байгууллагуудтай нарийн уялдаа холбоотой ажилладагт оршдог. Гэхдээ шүүхийн процедурыг баримталж заримдаа мөрдөн шалгах ажиллагаа эхэлсний дараа банкны нууцлалаар хамгаалагдсан мэдээллийг авч болох учраас ийм тагнуул санхүүгийн сектортэй явуулах харилцаа холбоонд хүндрэл учирдаг. Хууль хамгаалах байгууллагын бүрэлдэхүүнд багтсан санхүүгийн тагнуулыг Герман, Их Британи, Австри, Унгар, Литва зэрэг улс байгуулсан. Тухайлбал, 1993 оны 10 дугаар сарын 25-ны өдөр батласан ХБНГУ-ын Мөнгө угаахтай тэмцэх тухай хуулийн дагуу банкууд сэжигтэй тохиолдолд үйлчлүүлэгчийг тогтоож, мөрдөн байцаах байгууллагад нэн даруй илгээх үүрэгтэй.

Шүүхийн эсвэл прокурорын төрлийн санхүүгийн тагнуулын байгууллагыг шүүхийн байгууллага гэхдээ ихэвчлэн прокурорын байгууллагын мэдэл доор байгуулдаг. Эдгээр байгууллага нь банкны нууцлалын хатуу дэглэмтэй улс орнуудад илүү үр дүнтэй байдаг, учир нь шаардлагатай мэдээллийг шуурхай авах боломжтой юм. Ийм тагнуул нь сэжигтэй ажиллагааны талаар мэдээлэл авсан даруй мөрдөн байцаах ажиллагааг эхлэх, нэгжлэг хийх, хурааж авах, эд хөрөнгийг битүүмжлэх зэрэг мөрдөн шалгах ажиллагааг үр дүнтэй явуулдаг. Ийм төрлийн тагнуул нь Кипр, Люксембургт ажилладаг.

“Холимог” төрлийн тагнуул нь дээрх хоёр давуу талыг ашиглах эрмэлзэлтэй холбоотой. Зарим тагнуулд хууль хамгаалах байгууллагаас томилогдсон алба хаагчид ажилладаг. Дани, Норвегийн тагнуул үүний жишээ юм. Үүнээс үүдэн санхүүгийн тагнуулын төрлүүд хоорондоо ялгагдах үндсэн шалгуур нь чиг үүргийн онцлог байна гэсэн дүгнэлт хийж болно.

Санхүүгийн тагнуулын зорилт нь ирж буй мэдээлэлд дүн шинжилгээ хийх, сэжигтэй ажиллагаа (гүйлгээ)-г илрүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, хууль хамгаалах байгууллагад мэдээлэл өгөх, мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, олон улсын хамтын ажиллагаа явуулахад оршино. Санхүүгийн тагнуулын удирдлагын бүрэлдэхүүнд тухайн орны нэн чухал санхүүгийн байгууллагын (эдийн засаг, сангийн яам, гол гол банкууд, бирж) төлөөлөгчид, алба хаагчдын бүрэлдэхүүнд эдийн засагч, хуульч, татварын мэргэжилтэн, гаалийн албан хаагч, нягтлан бодогч, аудитор зэрэг хэд хэдэн төрлийн мэргэжлийн хүмүүс багтдаг.

Санхүүгийн тагнуултай улс орнуудын туршлагаас харахад санхүүгийн мэдээллийг цуглуулах, үйлчлүүлэгчийг тогтоох, хууль сахиулах байгууллагад шилжүүлэх ажиллагааг зохицуулсан зохих эрх зүйн орчинтой нөхцөлд үйл ажиллагаа нь илүү үр дүнтэй байна.

Улс орнуудын санхүүгийн тагнуулд мэдээлэл өгөх аргууд нь тэдгээрийн үйл ажиллагааны үр дүнд ихээхэн нөлөөлж байна. Тухайлбал, санхүүгийн болон тэдний үйл ажиллагааг зохицуулдаг байгууллагууд нь сэжигтэй хэлцэл (гүйлгээ)-ийн талаарх мэдээллийг санхүүгийн тагнуулын байгууллагад шууд өгдөг учир гэмт бүлэглэлүүдийг хурдан шуурхай илрүүлж, аюулгүй болгох боломж ихээхэн нэмэгддэг. Гэтэл санхүүгийн байгууллага болон түүний алба хаагч уг мэдээллийг эхлээд үйл ажиллагаанд нь хяналт тавьдаг байгууллагад өгөөд дараа нь тэндээс санхүүгийн тагнуулд өгдөг учраас мэдээлэлд дүн шинжилгээ хийх, мөрдөн шалгах ажиллагаа удааширч, үр дүн нь эрс буурдаг. Санхүүгийн тагнуулаас мэдээллийг санхүүгийн хяналтын байгууллагаар дамжуулахгүй санхүүгийн байгууллагаас шууд авдаг нөхцөлд ажиллагаа илүү үр дүнтэй болно.

АНУ-д мөнгө угаах үйл явцад оролцсон гэж “сэжиглэгдэж” буй улс орнуудын жагсаалтыг гаргадаг “FinCEN” нь санхүүгийн тагнуулын үүргийг гүйцэтгэдэг. Америкийн

банкууд нь FinCEN-ны жагсаалтыг ФАТФ-ын жагсаалттай зэрэгцүүлэн хэрэглэдэг. Мэдээллийн дүн шинжилгээний төв болох FinCEN нь АНУ-ын үндэстний аюулгүй байдалд заналхийлсэн санхүүгийн гэмт хэргийг мөрдөн шалгахад ТЕГ, ХМТ, БХЯ-ны тагнуулын удирдах газартай хамтарч ажилладаг.

FinCEN-ны мэдээллийн санд санхүүгийн мэдээллийн өгөгдлийн сан (Financial Data base - FDB), худалдааны дүн шинжилгээний төв болон тусгай албадын өгөгдлийн сан эх сурвалж нь болдог корпораци, хуулийн этгээдийн тухай худалдааны мэдээллийн сан, мөн АНУ-ын гааль, дотоод орлогын алба, хууль сахиулах байгууллагын шүүхийн хэргийн бүртгэлийн сан болон “бохир” мөнгөний эх сурвалж (Source Data Base), мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгасан (Undercover Money Laundering Investigations data Base), эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлсэн (Criminal Referral Data Base) талаарх мэдээллийн санг багтаасан АНУ-ын холбооны тагнуулын албанаас ирсэн мэдээлэл зэрэг багтдаг. FinCEN нь ТЕГ, ХМТ болон холбооны цахим хэрэгсэл ашиглан мэдээллийг АНУ-ын газар нутаг болон хилийн чанадаас авдаг ЯАБГ-ын мэдээллийн санд нэвтрүүлдэг.

АНУ-ын санхүүгийн байгууллагаас FinCEN-д өгдөг дараах мэдээлэл FDB (Санхүүгийн мэдээллийн төв)-д төвлөрдөг. Үүнд: 5000 доллараас дээш бэлэн мөнгөний гүйлгээ, (Currency Transaction Reports - CTR), 3000 доллараас дээш казиногийн санхүүгийн хэлцэл (Currency Transaction Reports by Casinos), хилийн чанадад байдаг банкны болон санхүүгийн бусад данс (Reports of Foreign Bank and Financial Accounts) зэрэг хамарч байдаг.

FinCEN-нд хэрэглэдэг хиймэл оюун ухааны технологи болох AI/MPP нь америкийн хамгийн том 70 гаруй өгөгдлийн санд мэдээллийг оруулж тухайн бодит цаг хугацаанд хууль бус санхүүгийн ажиллагааг илрүүлж, улмаар мэргэжилтнүүдээр судлуулах зорилгоор америкийн цахим банкны үйл явцад мониторинг хийх боломж олгодог.³⁸

Канадын санхүүгийн тагнуул (Financial Transaction and Report Analysis Center - FinTRAC) нь Сангийн яаманд харьяалагддаг, хууль хамгаалах бус байгууллага юм. FinTRAC нь “мөнгө угаах” гэмт хэрэгтэй тэмцэх хуулийн дагуу эрүүгийн хэргийг мөрдөн шалгахад туслалцаа үзүүлж санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг байгууллага юм. Канадын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй бүх санхүүгийн байгууллага нь сэжигтэй хэлцэл (гүйлгээ), хил дамнуулан 10000-аас дээш доллар шилжүүлсэн, 1000-аас дээш доллар Канадаас гуйвуулсан тухай мэдээллийг FinTRAC-т өгдөг. Үүнээс гадна санхүүгийн байгууллагууд заавал тайлагнадаг тогтолцоо байдаг. Үүний дагуу тэд бүх баримт бичгийг хадгалж, хууль хамгаалах байгууллагаас тавьсан шаардлагын дагуу гаргаж өгөх үүрэг хүлээдэг.

Сар бүр Канадын санхүүгийн тагнуулын мэдээллийн санд 20000 орчим мэдээлэл ирж, нэгтгэгдэн, дүгнэгддэг байна. Тухайн мөнгөний гүйлгээ нь мөнгө угаах гэмт хэрэгтэй холбоотой гэж үзэх үндэслэлтэй сэжиг байгаа нөхцөлд энэ тухай мэдээллийг цагдаагийн байгууллагад шилжүүлдэг. Цагдаагийн байгууллагад туслалцаа үзүүлэхийн тулд Канадын Нийгмийн ажил, төрийн үйлчилгээний яамны бүрэлдэхүүнд “мөнгө угаасан” шинж бүхий үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийдэг шүүхийн нягтлан бодогчийн бүлэг ажилладаг. Эдгээр мэргэжилтнүүдийн гаргасан тайлан дүгнэлт нь шүүхэд нотолгоо болдог. Байрлалын хувьд шүүхийн нябо нар цагдаагийн байгууллагын байранд байрладаг боловч түүнд захирагддаггүй. Мөрдөн шалгах явцад шүүхийн нябо нараас гадна прокурорууд багтсан ажлын хэсгийг байгуулж болдог.

Канад улсын прокурорын алба нь бусад прокурорын албадтай адил мөрдөн шалгах байгууллага биш юм. Тэрээр цагдаагийн байгууллагаас мөрдөн шалгах ажиллагаа явуулж

³⁸ Мельников В.Н., Мовсесян А.Г. Противодействие легализации преступных доходов. М., 2007.С.237

холбооны хууль зөрчсөн тухай ялын дүгнэлт гарсны дараа хэрэг үүсгэдэг. Канад улсын прокурорын алба нь мөрдөн шалгах үе шатанд мөрдөн байцаагч нарт туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх үүрэгтэй бөгөөд терроризм, гэмт бүлэглэлүүд, мөнгө угаах гэмт хэрэгтэй холбоотой хэргээр нягт хамтарч ажилладаг.³⁹

FinTRAC Канадын Сангийн яаманд харьяалагддаг нь хууль хамгаалах байгууллагуудтай хамтарч ажиллахад зарим хүндрэл учруулдгийг тэмдэглэх хэрэгтэй. Уг албанаас сэжигтэй гүйлгээний талаар их хэмжээний материалыг цагдаад шилжүүлдэг боловч цагдаагийн байгууллага ийм их хэмжээний дүн шинжилгээ хийх мэдээллийг боловсруулж амждаггүй байна. FinTRAC-ын бүх материалаар мөрдөн шалгах ажиллагаа явуулах үүрэг Канадад байдаггүй учраас ямар хэргээр мөрдөн шалгалт явуулахыг цагдаагийн байгууллага эрх хэмжээнийхээ хүрээнд өөрөө шийдвэрлэдэг байна.

Өнөө үед мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа нь тагнуулын, дүн шинжилгээний шинжтэй болсон **Их Британы** хууль хамгаалах байгууллагуудад энэ асуудал тулгамдсан асуудал болдоггүй. 1992 онд Их Британид онц ноцтой гэмт хэрэг, түүний дотор “мөнгө угаах” гэмт хэргийн талаар мэдээлэл цуглуулах, хадгалах, дүгнэх, дүн шинжилгээ хийх зорилго бүхий Эрүүгийн тагнуулын үндэсний алба (National Criminal Intelligence Service - NCIS) байгуулагдсан. Энэ алба нь мөнгө болон бусад эд хөрөнгөөр гүйлгээ хийдэг байгууллагууд тайлагнадаг санхүүгийн зах зээлийн гол хянагч болох Санхүүгийн үйлчилгээний удирдах газраас сэжигтэй гүйлгээний талаар мэдээлэл авдаг.

Бүтэц зохион байгуулалтын хувьд NCIS-д Лондон, Бристол, Бирмингем, Манчестер, Уэйкфилдэд байрладаг бүс нутгийн 5 байгууллага, Стратегийн болон тусгай тагнуулын Удирдах газар, Лондон дахь төв байр, тагнуулын мэдээллийн үйл ажиллагааг хөгжүүлэх хэлтэс, олон улсын тасаг багтдаг.

Стратегийн болон тусгай тагнуулын Удирдах газар нь Лондонд байрладаг бөгөөд нэг ёсны онц ноцтой гэмт хэргийг судалдаг дүн шинжилгээний төв юм. Удирдах газар нь эдийн засгийн гэмт хэргийн мэдээлэл цуглуулах, судлах, дүн шинжилгээ хийх ажил эрхэлж, тайлангаа Британий хууль хамгаалах байгууллага болон бусад байгууллагуудад өгдөг. Тайланд гэмт явдал өсөх чиг хандлага, чиглэлийн талаар мэдээлэл тусгадаг. NCIS-ийн салбар нэгж нь хүнд, онц хүнд гэмт хэргүүд болон зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэлийн талаар тактикийн тагнуулын үүрэг гүйцэтгэдэг.

Удирдах газрын бүрэлдэхүүнд мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцдэг санхүүгийн тагнуулын чиг үүргийг гүйцэтгэдэг эдийн засгийн гэмт хэргийг мөрдөн шалгах хэлтэс байдаг. Энэ хэлтсийн зорилго нь өөрсдийн үйл ажиллагааны үр дүнг цаашид хууль хамгаалах байгууллагад шилжүүлэхийн тулд мэдээлэл илрүүлэх, цуглуулах, боловсруулах, хадгалах явдал юм. Уг хэлтэс аль ч төрийн байгууллагаас санхүүгийн гүйлгээтэй холбоотой ямар ч мэдээллийг шаардан гаргуулах бүрэн эрхтэй. Энэ хэлтсийн өөр нэг чиг үүрэг нь эдийн засгийн гэмт хэргийн байдал, хөдөлгөөн, чиг хандлагыг илрүүлэх, урьдчилсан прогноз боловсруулах, мөн мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх арга замын талаар зөвлөмж гаргах, мөнгө угаах болон бусад санхүүгийн ноцтой гэмт хэргийн тухай мэдээлэл илрүүлэн, цуглуулдаг мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх, сургах боловсролын чиглэлийн үйл ажиллагаа явуулахад оршдог.

Их Британий цагдаагийн байгууллагын санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааг явуулдаг удирдах газрууд NCIS-ийн материалыг үндэслэн гэмт аргаар олсон орлоготой эсвэл түүнийг захиран зарцуулж байгаа гэдэгт сэжиглэгдэж буй этгээдүүдийг шуурхай шалгах ажиллагаа явуулдаг. Тухайн этгээдийн дансны талаар мэдээлэл авах шаардлага

³⁹ Мэрфи Д. Действия Канады в связи с Конвенцией ООН против коррупции //Вестник Академии экономической безопасности МВД России. 2009. №8. С.113

гарсан тохиолдолд тухайн цагдаагийн байгууллагын алба хаагчид шүүхээс зөвшөөрөл өгөх үүрэгтэй бөгөөд түүнийг үндэслэн санхүү зээлийн байгууллага тодорхой үйлчлүүлэгчийн гүйлгээний талаар мэдээллийг цагдаагийн байгууллагад өгөх эрхтэй.

Их Британий хууль хамгаалах байгууллагуудын үйл ажиллагаа үргэлж зохих түвшинд байдаггүй, нууцлалыг бүдүүлгээр зөрчих явдал гардаг болохыг тэмдэглэх хэрэгтэй. Жишээ нь, Лондонд "Ватерлоо" буудлаас зүүн урагшаа явж байсан галт тэрэгнээс нэг зорчигч алан хядах "Аль-Каида" байгууллагын тухай нууц бичиг баримтыг олсон байна. Мөн "маш нууц" тэмдэгтэй мөнгө угаах гэмт хэрэг, мансууруулах бодисын наймаа, алан хядах ажиллагааг санхүүжүүлэх талаарх материалтай хавтсыг олж байжээ. Уг материалыг Британий бүх тусгай албадын удирдлага болон гол гол яамдуудын төлөөлөгчид орсон тагнуулын хэргийн нэгдсэн хорооноос бэлтгэсэн байна.

Швейцарт санхүүгийн тагнуулын үүргийг Мөнгө угаах гэмт хэрэгтэй хийх тэмцэлд хяналт тавих Удирдах газар, Мөнгө угаах гэмт хэргийн талаар тайлагнах Удирдах газар, Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх Төв удирдах газар, мансууруулах бодис хууль бусаар борлуулах гэмт хэрэгтэй тэмцэх Төв удирдах газар тус тус гүйцэтгэдэг.

Мөнгө угаах гэмт хэргийг тайлагнах Удирдах газар нь санхүүгийн байгууллагаас ирсэн тайланг шалгаж, мөнгө угаасан гэмт хэргийг мөрдөн шалгадаг.

Швейцарын мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх холбооны хуулийн дагуу санхүүгийн зуучлагч нь сэжигтэй гүйлгээний талаар Мөнгө угаах гэмт хэргийг тайлагнах Удирдах газарт үйлчлүүлэгчид мэдэгдэлгүйгээр мэдэгдэх ёстой. Тус Удирдах газар нь Холбооны цагдаагийн агентлаг болон Шүүн таслах ажиллагаа болон цагдаагийн холбооны департаментын бүрэлдэхүүнд ордог боловч санхүүгийн зуучлагч болон цагдаагийн байгууллагын хооронд холбогч болдог бөгөөд эрүүгийн мөрдөн шалгах чиг үүргийг хэрэгжүүлдэггүй байна.

Холбогдох мэдээллээ өгсний дараа санхүүгийн зуучлагч шаардлагатай мэдээлэл автал 5 хүртэл хоног мөнгөний гүйлгээг хаах ёстой. Сэжигтэй гүйлгээний талаар мэдээлэл өгсөн санхүүгийн зуучлагчийг мэргэжлийн нууцлал болон гэрээний үүргийг зөрчсөн гэж яллаж болохгүй. Гүйлгээний сэжигтэй байдлын түвшинг санхүүгийн зуучлагч өөрөө тогтоох ба 100000 швейцар франкнаас давсан гүйлгээнд онцгой анхаарал хандуулна.

Мэдээллийг хурдан шуурхай дамжуулах зорилгоор интернетэд санхүүгийн зуучлагч нарт зориулсан тусгай маягт байрлуулсан байдаг. Мөнгө угаах гэмт хэргийн талаар тайлагнах Удирдах газар нь ажлын 5 хоногт багтаан шалгадаг. Авсан мэдээллийг Швейцарийн мэдээллийн дөрвөн сангаар дамжуулан шалгана. Энэ нь VOSTRA (криминалистикийн бүртгэлийн **досье**), AUPER (шүүхийн олон улсын харилцан туслалцаа), RIPOI (хуулийн этгээд), JANUS (зохион байгуулалттай гэмт явдал) юм.

Статистикийн мэдээллээс харахад асуулгын 40 орчим хувийг мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгах хариуцлагыг хүлээсэн Төрийн хэргийн яаманд (түүний бүрэлдэхүүнд Холбооны Цагдаагийн агентлаг ордог) шилжүүлдэг. Мөнгө угаах гэмт хэргийн талаар тайлагнах Удирдах газар нь зохих шалгалт хийсний дараа гүйлгээний хаалтыг зогсоох талаар шийдвэр гаргадаг.

Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх хяналтын Удирдах газар нь (Швейцарын мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийн 17-р зүйл) Холбооны Санхүүгийн удирдах газарт харьяалагдаж өөрийгөө удирдах байгууллага болон санхүүгийн зуучлалын үйл ажиллагаанд хяналт тавьдаг.

Хяналтын удирдах газар нь жил бүр өөрийн үйл ажиллагааны талаар тайлан гаргаж, түүндээ баримтлах бодлого, зорилгоо тодорхойлж өгдөг. Уг тайланд санхүүгийн зуучлагч нараас лиценз (зөвшөөрөл)-ийг татан авах болсон шалтгаан, үндэслэлийн талаар мэдэгддэг.

Хяналтын удирдах газар нь хувь хүн, компанид зориулан дүрэм гаргаж, түүндээ Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх хуулийн заалт, Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх тухай Швейцарын банкны үйл ажиллагааны холбооны комиссын тогтоолыг хэрхэн хэрэглэх талаар тайлбар гаргадаг байна. Мөн Хяналтын удирдах газрын сайтад Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх хуулийг хэрэглэх талаар тайлбар, мэдээ сэлтийг нийтэлдэг.

Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх Төв удирдах газар нь (Эрүүгийн цагдаагийн байгууллагын тухай хуулийн 7-р зүйл, 1994.10.7) мөнгө угаах гэмт хэрэг, мансууруулах бодисын хууль бус худалдаа зэрэг зохион байгуулалттай гэмт явдалтай тэмцэхэд чиглэсэн арга хэмжээг зохицуулж, мэдээлэл цуглуулах ажлыг гүйцэтгэдэг.

Литвын Бүгд Найрамдах Улсын 1997 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн VIII-275 дугаар Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийн дагуу санхүүгийн тагнуулын чиг үүргийг татварын цагдаад харьяалалтай бие даасан бүтцийн нэгж салбар гүйцэтгэдэг. Тэрээр үйлчлүүлэгч, түүний мөнгөн гүйлгээний талаар мэдээлэл цуглуулах, бүртгэх, мөнгө угаах гэмт хэрэгт хэрэг бүртгэлт хийх ажлыг хариуцдаг. Татварын цагдаа нь төрийн институт, зээл санхүүгийн байгууллага, бусад хуулийн мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх талаар авсан арга хэмжээний талаар мэдээлэл, баримт бичиг авах, тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт тавих, төрийн институцийн үйл ажиллагааг зохицуулах, хууль зөрчиж болзошгүй байдлыг бий болгосон нөхцөл байдлыг тодорхойлох эрхтэй байдаг.

Зээл санхүүгийн байгууллага нь үйлчлүүлэгчийн мөнгөн гүйлгээ нь мөнгө угаах гэмт хэрэгтэй холбоотой гэсэн сэжиг үүссэн тохиолдолд түүнийг хэн болохыг тогтоох, гүйлгээний тоо хэмжээнээс үл хамааран тухайн мөнгөн гүйлгээний талаар татварын цагдаад мэдээлэл өгөх үүрэгтэй (дээрх хуулийн 8-р зүйл). Хэд хэдэн тохиолдолд мөнгө угаах гэмт хэрэгт хамааралтай гэсэн сэжиг үүссэн эсэхээс үл хамааран заавал мэдээлэл өгөх ёстой байдаг. Энэ нь даатгалын урамшуулал олгох нэг удаа мөнгө солих, тогтоосон хэмжээний босгыг давсан мөнгөн гүйлгээ хийх явдал юм (үг хуулийн 12-р зүйл). Ингэхдээ байгууллага үйлчлүүлэгчийн гүйлгээний талаар бүртгэл хийж, баримт бичгийг үйлчлүүлэгчтэй холбоо тасарснаас хойш 10 жил хадгалах ёстой. Мэдээлэл өгөх тухай шаардлага нь мөн гааль, нотариатын байгууллагад хамааралтай.

“Их наймын” орнуудтай ижил зарчмаар Азийн орнуудын санхүүгийн тагнуул зохион байгуулагдсан байдаг. БНХАУ-ын Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийн¹ (30) 8-р зүйлийн дагуу мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх ажил явуулдаг. Төрийн зөвлөлийн захиргааны байгууллага нь мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг бүх Хятад даяар зохион байгуулах, мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх салбарт мөнгөний урсгалд хяналт тавих, бие даан эсвэл Төрийн зөвлөлийн санхүүгийн удирдлага, хяналтын зохих байгууллагуудтай хамтран санхүүгийн байгууллагын мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх талаар дүрэм журам гаргах, мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх талаар санхүүгийн байгууллага үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт шалгалт хийх, өөрийн эрх мэдлийн хүрээнд эргэлзээтэй гэрээ хэлэлцээрийг байгуулсан ажиллагааг шалгах болон хууль, Төрийн зөвлөлөөс заасан мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх бусад үүргийг гүйцэтгэдэг. БНХАУ-д энэ үүргийг Хятадын Ардын банкны дэргэд байгуулсан Мөнгө угаах гэмт хэрэгтэй хийх тэмцлийн хяналт, дүн шинжилгээний Төв (цаашид Төв) гүйцэтгэдэг. (CALMAC) Төв нь том хэмжээний, эргэлзээтэй хэлцлийн талаар мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийдэг.

Мэдээллийн эх сурвалж нь санхүүгийн болон гаалийн байгууллагууд юм. Санхүүгийн байгууллагууд нь олон удаагийн хэлцэл хийхдээ, мөнгөн дүн нь тогтоосон хэмжээнээс хэтэрсэн эсвэл эргэлзээтэй хэлцэл (сэжигтэй гүйлгээ)-ийг илрүүлсэн тохиолдолд мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх мэдээллийн төвд нэн даруй мэдэгдэх ёстой. (БНХАУ-ын Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийн 20-р зүйл). Гаалийн байгууллага тухайн улсын хилээр оруулахад зөвшөөрсөн хэмжээнээс хэтэрсэн үнэт цаасыг хувь хүнээс илрүүлсэн

тохиолдолд мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцдэг захиргааны байгууллагад цаг алдалгүй мэдэгдэх ёстой. Хилээр оруулах, гаргах мөнгөний хэмжээг Төв ТЕГ-тай зөвшилцөн тогтооно.

Дээрх хуулийн 11-р зүйлийн дагуу Төв нь мөнгө хөрөнгөнд хяналт тавих үүргээ биелүүлэхийн тулд Төрийн зөвлөлийн яамд болон байгууллагуудаас шаардлагатай бүх мэдээллийг шаардан авч болно. Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх талаар хийсэн ажлын талаар тогтмол сэтгүүл гаргаж Төрийн зөвлөлийн зохих яам, байгууллагуудад хүргэдэг. Төв болон Төрийн хяналтын бусад байгууллага нь мөнгө угаах гэмт хэрэгт сэжиглэж болох хэлцэл хийсэн болохыг илрүүлсэн тохиолдолд мөрдөн байцаах байгууллагад цаг алдалгүй мэдэгдэх үүрэгтэй (Мөнгө угаах гэмт хэрэгтэй хийх тэмцлийн тухай хуулийн 13-р зүйл). Санхүүгийн байгууллага нь хуульд заасан хэм хэмжээний дагуу мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаанд хяналт тавих дотоодын тогтолцоог болон мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх тусгай байгууллагуудыг бий болгох ёстой. Санхүүгийн байгууллагын зохих албан тушаалтнууд мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх салбарт дотоодын хяналтын тогтолцоог үр ашигтай хэрэглэх талаар тодорхой үүрэг, хариуцлага хүлээх ёстой.

Санхүүгийн байгууллагууд нь үйлчлүүлэгчтэй ажил хэрэгч холбоо тогтоох эсвэл анх удаа бэлэн мөнгө олгох, мөнгө шилжүүлэх, зээлийн баримт солих зэрэг санхүүгийн үйлчилгээ үзүүлэх явцад мөнгөн дүн нь тогтоосон хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд үйлчлүүлэгч, түүний төлөөлөгчөөс биеийн байцаалтыг нь шаардах, ашиг орлогонд нь тулгалт хийх, бүртгэж авах ёстой. Санхүүгийн байгууллагууд нь үйлчлүүлэгчийн тухай материал, хэлцэл хийсэн тухай мэдээллийг 5 жил хадгалах үүрэгтэй. БНХАУ-ын Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуульд тухайн байгууллага дампуурсан эсвэл татан буугдсан, устан алга болсон тохиолдолд Төрийн Зөвлөлийн яамнаас томилон зохих байгууллагад баримт бичгийг шилжүүлэхээр зохицуулалт хийсэн нь тэмдэглүүштэй юм.

Өмнөд Солонгост тус улсын Сэжиг бүхий санхүүгийн гүйлгээтэй холбогдуулан мэдээ сэлт өгөх, ашиглах тухай хуулийн дагуу (2011 оны 11 дүгээр сарын 28-наас хүчин төгөлдөр болсон) Санхүү, эдийн засгийн яамны бүтцэд Санхүүгийн мэдээллийн удирдах газар (Financial Intelligence Unit)-ыг байгуулсан. Уг Удирдах газрын бүрэлдэхүүнд Санхүү, эдийн засгийн яам, татварын байгууллага, санхүү, зээлийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих комисс, Үндэсний Цагдаагийн Агентлаг, ХЗЯ, Солонгосын Банк, Гаалийн 46 ажилтан багтжээ.

Удирдах газар нь бие даасан байгууллага бөгөөд түүний алба хаагчид нь өөр ажил эрхлэх ёсгүй, өгсөн мэдээллийн нууцлалыг хадгалах үүрэгтэй. Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар орон тоо, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны хараат бус болон улс төрийн төвийг сахисан эрх зүйн байдлыг тогтоож өгдөг.

Санхүүгийн мэдээллийн удирдах газрын удирдлага жил бүр хийсэн ажлаа Парламентад тайлагнадаг. Санхүүгийн байгууллагаас ирсэн мэдээллийн тоо, хууль хамгаалах байгууллагад шилжүүлсэн санхүүгийн сэжигтэй гэрээ хэлэлцээрийн тухай мэдээллийн тоо, ижил төстэй гадаад улсын байгууллагатай мэдээлэл солилцсон, хамтран ажилласан тухай мэдээ сэлт, бусад стратегийн мэдээ сэлт багтсан байдаг.

Санхүүгийн мэдээллийн удирдах газрын чиг үүрэг нь мөнгө угаах гэмт хэрэг эсвэл хилийн чанад руу хууль бусаар шилжүүлсэн эсвэл хил давуулан оруулж ирсэн хэрэг ач холбогдолтой байж болох сэжигтэй санхүүгийн ажиллагааны тухай мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, шалгах, ижил төстэй гадаадын байгууллагуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, өөрийн эрх мэдлийн хүрээнд тухайн орны Ерөнхийлөгчийн зарлигийг биелүүлэх явдал юм.

Дараах тохиолдолд санхүүгийн байгууллага нэн даруй мэдээллийг Санхүүгийн мэдээллийн удирдах газар хүргүүлэх үүрэгтэй. Үүнд: санхүүгийн үйл ажиллагааны явцад

хийж буй мөнгөн гуйвуулга хууль бус гэсэн сэжиг төрөх, тухайлбал гуйвуулж буй мөнгө 50000000 өмнөд солонгосын воноос (10000 доллар) давсан байх, мөнгөн гуйвуулга хийхдээ гэрээ хэлэлцээр хийсэн аль нэг тал тогтоосон хязгаарыг давуулахгүй байх зорилгоор хэд хэдэн хэсэгт хуваасан гэсэн сэжиг төрөх, хууль бус орлогыг нуун дарагдуулах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийн 5-р зүйлийн дагуу мөрдөн байцаах байгууллагад өргөдөл гаргасан тохиолдолд зэрэг хамаарна.

Санхүүгийн байгууллага нь санхүүгийн гүйлгээний мөнгөн дүн тогтоосон хэмжээнээс хэтрээгүй боловч түүнийг гэмт аргаар олсон мөнгийг угаахтай холбоотой хууль бус ажиллагаа гэж үзэх үндэслэл байвал мөн мэдэгдэж болно. Санхүүгийн байгууллага мэдээлэл өгөхдөө юун дээр үндэслэн сэжиглэж байгаа тухайгаа тодорхой зааж өгөх ёстой.

Санхүүгийн байгууллага нь мэдээлэл явуулсан өдрөөс эхлэн 5 жил дараах материалуудыг хадгалах ёстой. Үүнд: санхүүгийн хэлэлцээрт оролцогчдын жинхэнэ нэрийг батласан материал, санхүүгийн байгууллагын хийсэн сэжиглэх үндэслэлтэй ажиллагааны тухай мэдээллийн товч хэлбэр багтдаг. Банкны удирдлага ийм мэдээллийг нуун дарагдуулах эсвэл хугацаа алдаж өгсөн тохиолдолд хуулийн дагуу хатуу хариуцлага оногдуулахаар заасан байдаг. Мэдээлэл бэлтгэсэн санхүүгийн байгууллагын ажилтан зохих санхүүгийн ажиллагаанд оролцогчид эсвэл аль нэгэн сонирхсон этгээдэд мэдээллийг задруулахыг хориглоно.

Сэжигтэй санхүүгийн ажиллагааны тухай өгсөн мэдээлэл нотлогдоогүй нөхцөлд мэдээлэл өгсөн санхүүгийн байгууллага санхүүгийн ажиллагаанд оролцогчид эсвэл бусад сонирхсон этгээдүүдийн өмнө гарч болзошгүй хохирлын төлөө ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

Мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд санхүүгийн байгууллага нь Санхүүгийн мэдээллийн удирдах газарт мэдээлэл өгөх журам тогтоох, хариуцах ажилтныг томилох, энэ асуудлаар зааварчилгаа боловсруулж, хэрэглэх (энэ зааврыг дээр заагдсан алба хаагч ажилдаа удирдамж болгох ёстой), уг ажлыг хийж гүйцэтгэх мэргэшсэн ажилтныг бэлтгэх, сургах үүрэгтэй.

Удирдах газрын дарга сэжигтэй гүйлгээ, гэрээ хэлэлцээрийг илрүүлэх, мэдээлэх тухайн хуулийн заалтыг санхүүгийн байгууллагууд хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж, эдгээр асуудлаар тушаал, зааварчилгаа өгөх, өөрийн албан хаагчид санхүүгийн байгууллагыг дээрх асуудлаар хянах, шалгах үүргийг өгөх эрхтэй.

Санхүүгийн мэдээллийн удирдах газрын дарга сэжигтэй ажиллагаанд татвар, гаалийн эсвэл санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах шаардлагатай гэж үзвэл тэрээр зохих материалыг Ерөнхий Прокурор, Татварын албаны комиссар, Гаалийн албаны комиссар, Санхүүгийн хянан шалгах комиссын даргад хүргүүлнэ. Эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн шалгах шаардлага бий болсон тохиолдолд санхүүгийн ажиллагааны тухай мэдээллийг Үндэсний Цагдаагийн агентлагийн даргад илгээнэ.

Гэхдээ зөвхөн үүгээр санхүүгийн тагнуул болон хууль хамгаалах байгууллагын хамтын ажиллагаа хязгаарлагдахгүй. Эргэх холбооны зарчмын дагуу Ерөнхий прокурор, Үндэсний Цагдаагийн агентлагийн дарга, гааль, татварын албаны комиссар, санхүүгийн хянан шалгах комиссын дарга, ерөнхийлөгчөөс зохих заавар өгсөн нөхцөлд санхүүгийн мэдээллийг удирдах газрын даргаас өгөгдсөн материалтай холбоотой нэмэлт мэдээлэл шаардаж болно. Мэдээлэл авахын тулд шаардлага, асуулга илгээх, мэдээллийг ямар зорилгоор ашиглах, шаардагдаж байгаа мэдээллийн ерөнхий агуулгыг тусгасан байна. Үүнээс гадна Удирдах газрын дарга илгээсэн материалыг шалгуулахаар өөрийн байгууллагын албан хаагчдыг томилно.

Эдгээр эрх мэдлээс гадна санхүүгийн мэдээллийг Удирдах газрын дарга нь тухайн мэдээлэл болон сэжигтэй гэрээ хэлэлцээрт хамааралтай захиргааны болон санхүүгийн байгууллагаас мэдээ сэлт авч болно.

Солонгос улсын санхүүгийн тагнуул нь Бельги, Их Британи, Польш, АНУ, Австралийн зохих байгууллагуудтай хамтран ажиллах тухай хэлэлцээрт гарын үсэг зурсан. Санхүүгийн тагнуулын удирдах газар нь өөрийнхөө цахим хуудас дээр мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэж буй гадаадын улс орнуудын тухай мэдээлэл болон энэ гэмт хэрэгтэй тэмцэх тухай АНУ, Их Британи, Японы хуулиудыг байршуулсан байна.

Санхүүгийн тагнуулын өвөрмөц бүтэц зохион байгуулалтыг **Беларусь улсад** бий болгожээ. 2003 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр Беларусь улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Санхүүгийн мониторингийн газрыг байгуулсан. Уг газрын бүтцэд орсон Улсын хянан шалгах хороо нь санхүүгийн хяналт болон санхүүгийн тагнуул хийх чиг үүргийн зэрэгцээ улсын Ерөнхийлөгчид шууд харьяалагдан, илрүүлсэн санхүүгийн зөрчлүүдэд гүйцэтгэх ажил хийх, урьдчилсан мөрдөн байцаалт явуулдаг байна.

Уг газрын үйл ажиллагаа нь Хууль бус аргаар олсон ашиг орлогыг угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай 2000 оны 7 дугаар сарын 19-ны өдрийн хууль болон Беларусь улсын хянан шалгах хорооны Санхүүгийн мониторингийн газарт мэдээлэл өгөх журмын тухай 2003 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 195 дугаар үндэсний банкны удирдлагын тогтоолоор зохицуулагддаг юм.

Санхүүгийн мониторингийн газар нь мөнгө угаах гэмт хэрэгтэй холбоотой ажиллагааны талаар мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх санхүүгийн байгууллагууд хуурамч, халхавч байгууллагуудтай холбоотой эсэхийг тогтоох чиг үүрэг гүйцэтгэдэг. Санхүүгийн мониторингийн газарт өдөр бүр сэжигтэй гүйлгээний талаар 1,2 мянга орчим мэдээлэл байгууллагуудаас ирдэг байна. 2012 оны банкууд 344.183 мэдээлэл ирүүлжээ.

Беларусь улс дээр дурьдсан хуулийн 7-р зүйлийн дагуу санхүүгийн гүйлгээ хийж байгаа этгээд 1000 суурь нэгжээс их хэмжээний мөнгөн гүйлгээ хийсэн, үйлчлүүлэгч, байгууллагыг шалгах үүрэгтэй. Үүнээс гадна онцгой хяналтад байх ёстой ажиллагааны талаар тусгай бүртгэл хөтөлдөг. Үүнд: Бэлэн мөнгө, үнэт цаас, эд хөрөнгө, банкны дансаар хувь хүн 20000 суурь нэгж болон байгууллага, хувиараа аж ахуй эрхлэгчид 20000-аас дээш суурь нэгжээр гүйлгээ хийсэн үйл ажиллагаа хамаарна.

Санхүүгийн мониторингийн газар нь мөнгө угаахтай холбоотой санхүүгийн ажиллагааг түр зогсоох тухай тогтоол гаргаж, эрүүгийн мөрдөн шалгах газарт зохих материалыг илгээх бүрэн эрхийг эдэлнэ. 2012 онд тус газраас хууль хамгаалах байгууллагад 28000 субъектэд хамааралтай сэжигтэй гүйлгээ ажиллагааны талаар 6000 мэдээлэл хүргүүлж, 96 тэрбум Беларусийн рублийн торгууль оногдуулж, үүнээс 46 тэрбум рублийг улсын орлого болгож, хуурамч халхавч байгууллагын мөнгө хөрөнгө зарцуулалтыг зогсоох тухай 280 тогтоол гаргасан байна.

Зөвхөн 2012 онд Санхүүгийн тагнуулын газар болон Дотоод явдлын яаманд мөнгө угаах гэмт хэргийг илрүүлэхэд хамтран ажиллах тухай хэлэлцээр байгуулжээ. Уг газраас хууль хамгаалах байгууллагад явуулж буй материалууд нь нууцлалын зэрэгтэй байдаг учраас гүйцэтгэх ажлын явцад шалгагддаг юм. Санхүүгийн мониторингийн газар нь санхүүгийн тагнуулын 32 салбар нэгжтэй мэдээлэл солилцох тухай гэрээ хэлэлцээр байгуулсан.

Дэлхийн улс орнуудын санхүүгийн мониторингийн байгууллагуудын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж үзэхэд тэдний үйл ажиллагаа бүтэц зохион байгуулалтын үндсэн зарчмууд ижил төстэй болохыг харуулж байгаа нь мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор олон улсын хамтын ажиллагааг улам өргөжүүлэх бодит шаардлага, боломж байна гэсэн дүгнэлт хийж болохоор байна. Цаашид мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх олон

улсын туршлагыг улс бүрээр дэлгэрэнгүй авч үзэн цувралаар нийтлүүлж, олны хүртээл болгох болно.

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ



1921 ОНЫ ХУВЬСГАЛААС ХОЙШХИ ҮЕИЙН МОНГОЛЫН ХУУЛЬ ЦААЗЫН ТҮҮХЭН ДЭХ АШИГТ МАЛТМАЛЫН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛ, УЛАМЖЛАЛ БА ШИНЭЧЛЭЛИЙН АСУУДАЛ

Ж.Нямдулам

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, доктор /Ph.D/, цагдаагийн ахмад

Аннотация: Судлаач уг өгүүлэлдээ 1921 оны Ардын хувьсгалаас хойшхи үе буюу тодруулбал 1926, 1929, 1934, 1961, 1987, 2002 оны Эрүүгийн хуулиудад ашигт малтмалын эрүүгийн эрх зүйн хамгааллыг хэрхэн хуульчилсан байдал, түүний хууль цаазын уламжлал шинэчлэлд дүн шинжилгээ хийж бичжээ.

Түлхүүр үг: хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох, шүүх цаазын бичиг, ашигт малтмал, байгаль орчин, экологи.

1921 оны ардын хувьсгалын дараахь хэдэн жилүүдэд тэр үеийн эрх баригчид барууны орнуудын эрх зүйн тогтолцоог баримжаалж байжээ. Засгийн газрын 1922 оны 5 дугаар сарын 19-ны өдрийн “Хууль цаазыг зохиох тухай” тогтоолд “Манай улс ардын эрхт хэмжээт цаазат засгийг явуулж бүхий боловч үндсэн хууль зүйлийг тогтоон гүйцэтгээгүй нь аливаа хэргийг шийтгэж явуулахад их л дутагдал газар буй амой. Үүнд одоогоос тусгай комисс томилогч гаргаж, урьд автономит засгийн үед зохион төлөвлөж, хараахан зарлан явуулаагүй хууль зүйлийн бичгүүдэс авах гээхийг ялган салгаж, одоогийн засгийн үндсэн журамд нийцүүлэн басхүү манай улс гадаад улсын хүн иргэний зарга заалхайн хэргийг таслан шийтгэж бүхий учир аливаа шүүн таслах хэрэгт эрх биш Европынолон улсын хууль дүрмийг харгалзан дахин шинэтгэн зохиолгох зэргийг хэлэлцээд тусгай комисс гаргаж шинэтгэн зохиох нь маш зүйтэй...”⁴⁰ гэж заажээ. Энэ тогтоолын агуулгаас үзэхэд үндсэн хууль, түүнчлэн иргэний хуулийн төслийг боловсруулахад дан ганц улсын биш харин Европын олон улс орнуудын эрх зүйг харгалзан үзэхийн чухлыг онцлон тэмдэглэсэн байна.

Манай зарим судлаачид 1924 оны Үндсэн хуулийн монголын нийгэмд үзүүлсэн ач холбогдлыг “Монголын төрийн түүхнээ анх удаа хаант ёсыг халж, үндэсний ардчилсан өөрчлөлт, эрх зүйн чухал зарчмууд, улс төрийн цоо шинэ тогтолцоог хуульчлан

⁴⁰ БНМАУ-ын Үндсэн хууль, түүнд холбогдох зарим актын эмхэтгэл. УБ., 1972, 54 дэхь тал

баталгаажуулж, туурга тусгаар төр улсаа дэлхий дахинд тунхагласан түүхэн ач холбогдолтой баримт бичиг мөн”⁴¹ гэж дүгнэсэн байна.

1924 оны Үндсэн хуулийн дараа гол гол хууль тогтоомжийг боловсруулан батлах нөр их ажил өрнөсөн байна. 1926-1929 онд Иргэний болон Эрүүгийн хууль, 1926 онд аливаа хэргийг байцаан шийтгэх хуулийг батлан дагаж мөрдүүлжээ. Манай зарим судлаачид “Тэдгээр төрөлжүүлсэн хуулийг эх газрын эрх зүйн ойлголт, зарчим, хуулийн бүтцийг тусгаж, мөн тэндэхийн нэр томъёо, арга техникийг ямар нэг хэмжээгээр ашиглан боловсруулсан нь илэрхий байдаг билээ.”⁴² гэж үзсэн байна. Ардын түр засгийн газрын байгаль орчны холбогдолтой анхны акт бол 1921 оны 5 сарын 21-ны өдөр батлагдсан 19 дүгээр хурлын тогтоол бөгөөд түүгээр тус улсын бүх газрыг хувьдаа өмчлөхийг хориглосон юм. Энэ нь удаа дараагийн үндсэн хуульд тусгалаа олж, улам баяжжээ. Газраас гадна ой, ус, тэдгээрийн баялгийг энэ заалтад мөн адил хамааруулсан юм. 1926 оны анхны төрөлжүүлсэн эрүүгийн хуулиар байгаль орчны эсрэг гэмт хэргийг тусгайлан бүлэг болгон хуульчилсан ч ашигт малтмалын баялагтай холбоотой асуудлыг тусгаагүй байна.

Харин байгаль орчныг хамгаалах талаар 1920- 1930-аад оны үед ихэвчлэн дүрмийн шинжтэй актаар зохицуулагдаж байсан бол 1940-д онд хуулийн хэлбэртэйгээр тогтвортой гарах болсон байна. Үүний тодорхой илрэл нь газар эдэлбэр, ой, ус, агнуурын хуулиуд гарсан явдал мөн. 1972 оны 6 дугаар сард БНМАУ-ын АИХ-ын чуулганаар хүрээлэн буй орчныг хамгаалахтай холбогдсон асуудал хэлэлцэж, тогтоол гарснаар энэ чиглэлийн ажил нилээд идэвхжиж, хуулиуд шинэчлэгджээ. Тухайлбал: Газар эдэлбэрийн хууль \1971 он\, Ойн хууль \1974 он\, Усны хууль\1974 он\, Ан агнуурын хууль \1972 он\ зэргийг нэрлэж болно.

1924 оны Үндсэн хуулиар” БНМАУ -ын дээд эрхийг Улсын Их Хуралд хадгалах бөгөөд мөн хурлын чөлөөт цагт улсын Бага хуралд хадгалуулах ба бас мөн хурлын чөлөөт цагт бага хурлын тэргүүлэгчид ба засгийн газарт хадгалуулвал зохино” гэж заасан юм.

Иргэдийн эрх, эрх чөлөөг тунхаглаж баталгаажуулсан нь уг үндсэн хуулийн нэг чухал ололт мөн. Тухайлбал: шашин шүтэх, хэвлэн нийтлэх, жагсах, баяр үйлдэх, эвлэлдэн нэгдэх, үнэ төлбөргүйгээр сурч боловсрох, үндэс угсаа, шашин шүтлэг, нас хүйс ялгаваргүйгээр тэгш эрх эдлэх зэрэг эрх чөлөөг эдлүүлдэг болжээ. Энэ үндсэн хууль батлагдсаны ачаар бараг бүх нийтээрээ бичиг үсэггүй байсан монголчууд соён гэгээрч, эрэгтэй, эмэгтэйчүүд эрх тэгш болох эрх зүйн орчин бүрэлдсэн юм.

1926 оны Шүүх цаазын бичиг бол ардын хувьсгалын жилүүдэд дагаж мөрдөж байсан анхны эрүүгийн хууль мөн. Энэ хуулийн ерөнхий анги нь засгийн газрын 1926 оны I-р сарын 15-ны өдрийн I-р хурлаар, тусгай анги нь 1926 оны 11-р сарын 11-ний өдөр Улсын III их хурлаар тус тус батлагдаж мөрдөгджээ. 1926 оны шүүх цаазны бичиг бол Зөвлөлт Холбоот Улсын эрүүгийн хуулийн үлгэр дууриаллаар зохиогдсон юм. Энэ хуулийн төсөл боловсруулах комиссын баримталсан зарчмын тухай бичигт: *“Хууль цаазны тусгай комисс бол ардын шүүх таслах газруудыг байгуулах ба хэрэг байцаах шийтгэх тухай хууль, жич аливаа иргэний ба эрүүгийн хууль цаазны бичиг зэргийг шинэчлэн зохиохдоо улсын хоёрдугаар их хурлын заавар тогтоолыг баримталж, Баруун Европын ба нийгэм журамт Зөвлөлийн засагт холбоот Оросын зэрэг үнэхээрийн боловсорсон хэмээх улсуудын одоогийн хэрэглэж буй хууль, үзэл суртлаас аль болох зохихыг ямагт үндэс үлгэр болгон хэрэглэсэн болно. Холбоот Орос улсын одоогийн зохион зарласан хууль зүйлүүд гагцхүү нийгэм журмын байдалд тохируулсны тулд Европын ба Америкийн*

⁴¹ Болдбаатар. Ж, Лүндээжанцан. Д. дурьдсан ном. 228-229 дэх тал

⁴² Б.Чимэд. Зохистой тогтолцоог баримжаалах нь эрх зүйн шинэтгэлийг үр нөлөөтэй хийх үндэс болох нь (Эрх зүйн шинэтгэл ба үндэсний эрх зүйн тогтолцоо. Олон улсын симпозиумын баримт материал. Ханс- Зайделийн сангийн монгол улс дахь төлөөлөгчийн газар УБ., 2000. 23 дахь тал)

*зэрэг онц боловсронгуй хэмээх улсуудын хэрэглэж буй аливаа хууль дүрмүүдтэй чанга |харшилна| зөрчинө*⁴³ гэжээ.

Шүүх цаазны бичгийн 1-р зүйлд: "Энэхүү шүүх цаазны бичгийг зарласан өдрөөс хойш гарсан аливаа гэмт явдал үйлдсэн хэрэгт журамлан дагаж шийтгүүлбэл зохино ... Хуульд заасан эл явдлыг гэмт хэрэгт тооцвол зохино" гэж заажээ. Үүнээс үзэхэд тодорхой гэмт хэргийн бүрэлдэхүүн нь гагцхүү шүүх цаазны бичгийн тусгай ангид заасан эрх зүйн хэм хэмжээгээр тогтоогдож байв. Харин гэмт хэргийн субъектийн насыг 11 наснаас эхлэхээр тогтоожээ. Ийнхүү анхны шүүх цаазын бичиг нь гэмт хэргийг журамлан тогтоож, манай улсад барууны буюу роме германы эрх зүйн системийг баримтлах эхлэлийг тавьсан хууль байсан юм. Харин уг хуульд байгаль орчны эсрэг гэмт үйлдлийг гэмт хэрэгт тооцох талаар ямар нэг зохицуулалт хийгээгүй бөгөөд уг үйлдлийг гэмт хэрэгт тооцдоггүй байжээ.

1929 оны Шүүх цаазны бичиг нь 1926 оны дараах Эрүүгийн хууль юм. Энэ хуулиар 1926 оны шүүх цаазны бичигт үндсэн өөрчлөлт оруулаагүй боловч хуулийг дахин боловсруулахдаа түүний хэм хэмжээг ойлгож хэрэглэхэд хялбар дөхөм болгож сайжруулсан нь хуулийг бүхэлд нь шинээр батлах шалтгаан болсон байна, 1929 оны шүүх цаазны бичиг бол шинэчлэн зохиосон хууль биш болох нь 1926 оны шүүх цаазны бичгийн тогтолцоо, бүтэц, олонхи хэм хэмжээ энэхүү хуульд хэвээр үлдсэнээр тайлбарлагдана.

1934 оны Шүүх цаазны бичиг нь эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгоход чухал үүрэг гүйцэтгэсэн. Энэхүү хуульд ангийн тэмцлийн зарчмыг тууштай бататгасан, Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэх боломжтой болгосон, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зарчмаас татгалзсан зэрэг ардчиллын эсрэг чиглэсэн хэм хэмжээ цөөнгүй байсныг дурьдах ёстой. Түүнчлэн 1930-аад оны үеэс хувьсгалын эсэргүү гэмт хэрэгтэй тэмцэх нэрийн дор залхаан цээрлүүлэх аргыг их өргөжүүлсэн байна. Иргэдийг мөрдөн мөшгөх, ял шийтгэх шүүхийн бус байгууллагыг буй болгожээ.⁴⁴

Эрүүгийн хариуцлагыг зөвхөн гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай этгээдэд хүлээлгэх зарчмыг бүдүүлгээр зөрчиж, гэмт хэрэг үйлдээгүй, гэм буруугүй бусад хүмүүст (гэр бүлийн гишүүдэд) халдаан хэрэглэсэн. Эрүүгийн хуульд туйлын тодорхой санкци тогтоож, энэрэнгүй байх зарчимд харшилсан хэд хэдэн заалтыг оруулжээ. Албан ёсны мэдээнээс үзэхэд 1937- 1939 онд явагдаж байсан баривчилгаа, залхаан цээрлүүлэлтийн явцад ул төрийн хилс хэрэгт 20 474 (хорин мянга дөрвөн зуун далан дөрвөн) хүн буудан алах ялаар шийтгүүлж, 5000 (таван мянга) гаруй хүн хорих ялаар шийтгүүлжээ.⁴⁵ Аймшигт хэлмэгдүүлэлт энэ олон хүнд амьд явах эрх, эрх чөлөөтэй, халдашгүй байх эрхийг хамгаалж чадаагүй гашуун сургамж монголын төр, эрх зүйн түүхэнд байсан юм.

1942 оны Эрүүгийн хууль нь Монгол улсад социализмын үндэс суурийг тавих үед дагаж мөрдөж байсан эрүүгийн эрх зүйн тулгуур эх сурвалж мөн. Энэ хууль нь ерөнхий ба тусгай ангиас бүрдэх бөгөөд ерөнхий анги нь 6 бүлэг, 54 зүйлд, тусгай анги 10 бүлэг, 165 зүйлд системчлэгджээ.

Социалист хөгжлийн явцад цаг үеийн шаардлагаас үндэслэн 1942 оны эрүүгийн хуульд дараа нь нэлээд өөрчлөлт, нэмэлт оруулсан байна. 1942 оны Эрүүгийн хууль нь 1934 оны Шүүх цаазны бичигтэй харьцуулахад нэлээд боловсронгуй болсон боловч эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэх боломжийг олгож байснаараа хүний эрхийг зөрчихөд хүргэж байсан юм. Зарим судлаачид "1934 онд Коминтерний шууд тулгалтаар Оросын 1926

⁴³ БНМАУ-ын Шүүх явдлын яам ба Дээд шүүх таслах газрын сэтгүүл. №1, 1928 оны хэвлэл, 58- 59 дэх тал

⁴⁴ С.Нарангэрэл. Монгол улсын эрүүгийн эрх зүй. Тусгай анги. УБ., 1998 он. 10 дахь тал.

⁴⁵ Ринчин. М. Улс төрийн хэлмэгдүүлэлт ба цагаатгал. УБ., 2000. 40 дэх тал

оны Эрүүгийн хуулийг нэлээд хэмжээгээр хуулбарласан байна. Эл хууль 1930- аад онд хууль бус явдал газар аван Монгол улсад Сталинч дэглэм тогтож, нийтээр нь хоморголон харгислах эрүүгийн эрх зүйн хэрэглүүр болсон юм. 1942 оны эрүүгийн хууль энэ байдлыг ихээхэн зөөлрүүлжээ⁴⁶ гэж дүгнэжээ.

Эндээс дүгнэхэд 1926, 1929, 1934 оны шүүх цаазын бичгүүд, 1942 оны эрүүгийн хуульд байгаль орчны эсрэг зан үйлийг гэмт хэрэгт тооцох талаар заалт огт тусгаагүй ирсэн нь тэр үеийн монголын нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшин, хууль тогтоомжийн хөгжилт болон бусад хүчин зүйлтэй холбоотойгоор уг асуудлыг авч хэлэлцээгүй, нөгөөтэйгүүр байгаль дэлхийтэйгээ зөв харьцах, түүний хамгаалах эртний уламжлал нь ард иргэдийн дунд хэвээр байсантай холбоотой байж болох юм.

1961 оны Эрүүгийн хууль бол олон жилийн турш дагаж мөрдсөн бөгөөд гэмт явдалтай тэмцэх эрүүгийн эрх зүйн үндсийг бүрдүүлж байсан хууль юм. Энэ хуулийн өмнөх эрүүгийн хуулиас ялгагдах онцлог шинж нь Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэх явдлыг хориглосон явдал юм. Энэ хуулийн 2 дугаар зүйлд: "Зөвхөн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд, өөрөөр хэлбэл Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Эрүүгийн хуульд заасан, нийгэмд аюултай хэргийг санаатай буюу болгоомжгүй үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж шийтгэнэ"⁴⁷ гэж заажээ. Тэгэхдээ энэ хуулийг боловсруулж батлахдаа удирдлага болгосон гол үзэл баримтлал нь эхлээд төрийн, дараа нь нийгмийн, хамгийн сүүлд нь хүний эрх ашгийг гэмт халдлагаас хамгаалахад оршиж байв.

Эл хууль нь социалист байгууллын үндсийг гэмт халдлагаас хамгаалах зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэгдэж байсан юм. Тийм учраас социалист өмчийг хамгаалах явдлыг хүний амь нас, эрүүл мэндээс илүүд үзэж, иргэдийн амины өмчид халдсанаас хатуу шийтгэж, социалист аж ахуйн тогтолцоог гэмт халдлагаас онцгойлон хамгаалж байв.

1961 оны Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулж 1987 оны 7 дугаар сарын 1-нээс эхэлж дагаж мөрджээ. Энэ л шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль нь эрүүгийн хуулийг боловсронгуй болгоход нэн чухал алхам болжээ. Энэ шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн тусгай ангид оруулсан өөрчлөлтийн гол онцлог нь хүний амь бие, эрүүл мэнд, эрх чөлөө, нэр алдрын эсрэг гэмт хэргийг социалист өмчийн эсрэг гэмт хэргийн өмнө оруулан системчилж, байгаль орчин, түүний баялгийг хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг гэсэн шинэ бүлэг оруулж өгсөнд оршино.⁴⁸ Чухам үүгээрээ манай улсын Эрүүгийн хууль тэр үеийн ЗХУ -ын Эрүүгийн хуулиас ялгагдах онцлогтой болж байлаа. Уг шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйлд **"... недрийг ашиглах, алт, үнэт металл, үнэт чулууг улсад тушаах журам зөрчсөн бол"** гэж хуульчилж байсан бөгөөд энэ нь байгаль орчныг хамгаалсан гэхээсээ илүү аж ахуйн үйл ажиллагааны эсрэг чиглэсэн объекттой байсан.

1992 оны Монгол Улсын Үндсэн хууль нь монголын нийгэм, улс төр, эдийн засгийн байгууллын хөгжлийн чиг баримжаа, үндэс тулгуурыг бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрөх, төрийн байгуулал, байгууллагуудын тогтолцоог тодорхойлох, төрийн байгууламж буюу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарь, түүний удирдлагыг бэхжүүлэхэд зорьсон үзэл баримтлалтай хууль болсон юм.⁴⁹ Монгол улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал, зарчим, агуулгад нийцүүлэн дагаж мөрдөж буй хуучин хууль тогтоомжид цогцолбор өөрчлөлтийг шаргуу, иж бүрэн хийх шаардлагатай болов. Энэ шаардлагын үүднээс Монгол Улсын Их Хурал 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдөр

⁴⁶ С.Нарангэрэл. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги. УБ., 1996 он. 36 дахь тал.

⁴⁷ БНМАУ-ын Эрүүгийн хууль. УБ., 1961 он, 3 дахь тал.

⁴⁸ С.Нарангэрэл. Проблемы совершенствование Уголовного законодательства МНР. М., 1988. С., 102- 105.

⁴⁹ Б.Чимид. Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн үзэл баримтлал. УБ., 2007. 19 дэхь тал.

зарчмын шинжтэй томоохон нэмэлт, өөрчлөлт оруулсан юм.

Үүнээс хойш Эрүүгийн хуульд хэд хэдэн удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан юм. Эдгээр нэмэлт, өөрчлөлт нь олон хэвшилт эдийн засагтай зах зээлийн харилцаа, олон ишт үзэл бодлыг хамгаалж, олон улсын эрх зүйн хэм хэмжээг хүлээн зөвшөөрч, хүнийг дээдэлж, түүний эрх чөлөөт байдлыг эрхэмлэн хамгаалах чиглэлээр хийгдсэн чухал алхам болов. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь бодит нөхцөл байдалтай уялдсаныг дараахь байдлаар тодорхойлж болох юм. **Нэгдүгээрт**, нийт хүн төрөлхтний хүлээн зөвшөөрсөн олон улсын эрх зүйн хэм хэмжээ болон Монгол улсын Үндсэн хуулийн зарчмыг Эрүүгийн эрх зүйд тусган хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагаас үүдсэн юм. **Хоёрдугаарт**, хэргийг гэмт хэрэгт тооцох \оросоор криминализаци, англиар criminalize\ буюу ял, санкци тогтоох \оросоор пенализации, англиар penalize\, ялын хүнд хөнгөнийг нийгмийн эдүгээгийн эрх зүйн ухамсар, гэмт явдлын бүтэц, байдалд нийцүүлэн зарим талын дахин үнэлэлт өгөх шаардлагаас нөхцөлдсөн. **Гуравдугаарт**, гэмт явдлын эсрэг эрүүгийн эрх зүйн арга хэрэглүүрийн үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэгдсэн. Эрүүгийн хуульд анх удаа эрүүгийн эрх зүйн зарчмыг хуульчлан бэхжүүлэв. Гэмт явдлын байдлын өнөөгийн болон ирээдүйн хандлагыг судлан үзсэний үндсэн дээр хэргийг шинээр гэмт хэрэгт тооцох, ял тогтоох асуудлыг шийдвэрлэсэн юм.

Одоогийн энэхүү үндсэн хуулиар байгаль орчны хууль тогтоомжийг үндсээр нь шинэчлэх эхлэлийг тавьсан юм. Үндсэн хуульд хүний экологийн эрхийн хүрээнд тус улсын иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг төрийн гол хуулийн хэмжээнд анх удаа бататган бэхжүүлж, газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал, тэдгээрийн баялаг ард түмний мэдэлд, төрийн хамгаалалтанд байна, эдгээр нь төрийн өмч болно гэж заасан юм.

Мөн Монголын түүхэнд анх удаа тус улсын иргэдэд газар өмчлүүлж болно гэж Үндсэн хуульд заажээ. Үндсэн хуулийн дагуу Газрын хууль \1994 он\, Тусгай хамгаалалттай газар нутгийн хууль \1994 он\, Байгаль орчныг хамгаалах хууль \1995 он\, Ойн хууль \1995 он\, Усны хууль \1995 он\, Байгалийн ургамлын хууль \1995 он\, Агаарын хууль \1995 он\, Хиймийн хорт бодисоос хамгаалах хууль \1995 он\, Ургамал хамгааллын хууль \1995 он\, Ой, хээрийн түймэртэй тэмцэх хууль \1996 он\, Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль \1997 он\, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний хууль \1997 он\, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль \1998 он\, Кадастрын зураглал, газрын кадастрын хууль \1999 он\, Ан агнуурын хууль \2000 он\, гэх мэт батлагджээ.

Ийнхүү Үндсэн хуулийн дагуу байгаль орчны нийтлэг болон төрөлжсөн хуулиуд байгалийн объект бүрээрээ гарсан нь байгалийн баялгийг ашиглах, хамгаалах төдийгүй харин тэнцвэрт байдлыг нь олон улсын жишгийн дагуу хангахад чиглэгдсэн байна.

Үндсэн хуулийн 16 дугаар зүйлий 2 дахь хэсэгт **"эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй"**, **"байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн үүрэг"** гэж 17 дугаар зүйлд заасан нь байгаль орчноо хамгаалах асуудал нь мөн эрүүгийн хуулийн нэг зорилт болсны гол нөхцөл юм.

2002 оны Эрүүгийн хуульд \2008 онд орсон нэмэлт өөрчлөлтөөр\ хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэргийг үндсэн бүрэлдэхүүн нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй байхаар хуульчилж, онц хүндрүүлэх бүрэлдэхүүнд бие даасан гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хуульчилсан байна.

Энэ гэмт хэргийн объект нь ашигт малтмалын хайгуул хийх, олборлох журам байна. Халдлагын зүйл болох ашигт малтмал гэж геологийн хувьсал өөрчлөлтийн үр дүнд

газрын гадаргуу, түүний хэвлийд үүсэн бий болсон аливаа хэрэгцээнд ашиглаж болох байгалийн байдлаараа байгаа эрдэс бодисын хуримтлалыг хэлнэ.

Ашигт малтмалд алт, үнэт металл, үнэт чулууг хамааруулан ойлгох ба тэдгээр нь унаган төрхөөрөө байсныг ашигласан нь энд хамаарах бөгөөд үүгээрээ өмч ашиглах гэмт хэргээс ялгагдана. Үнэт чулуунд доржпалам, маргад, индраанил, бадмаараг, сувд орох ба үнэт металлд платина болон түүний бүлгийн металл /родий, рутений, пладий, осмий, иридий/ алт, мөнгө хамаарна.⁵⁰ Ашигт малтмалын хайгуул, олборлолтын лиценз, мөн ашиглалтын лиценз гэж 2 төрөлд хуваагдах ба манай улсад гарч байгаа нийтлэг дутагдал нь хайгуулын лицензээр ашигт малтмалыг ашиглаж байгаа боловч хариуцлагын тогтолцоо хэт сул байгаагаас хууль зөрчигчид хэтэрхий ихсэх байдалд хүрчээ.

Объектив тал нь тусгай зөвшөөрөлгүй этгээд ашигт малтмалын хайгуул хийсэн, олборлосон үйлдээр илэрнэ. Ашигт малтмалын хайгуул хийх гэж ашигт малтмалын хуримтлал байгаа эсэхийг тодорхойлох, байршил, тоо хэмжээг нь тогтоох зорилгоор газрын гадаргуу, түүний хэвлийд үйл ажиллагаа явуулах, түүнчлэн ашигт малтмалыг ашиглах боломжийг судалж, техник, эдийн засгийн үнэлгээ хийх, мөн малталт хийх, нэвтрэх, сорьц авах, туршилт, тандалт хийхийг хамааруулна.

Ашигт малтмалыг олборлох гэж тусгай зөвшөөрөлгүй этгээд газрын хэвлийд нэвтрэн малталт хийж ашигт малтмалын төрөл зүйлийг өөрийн эзэмшилд авахыг хэлнэ. Байгаль орчны талаар явуулж байгаа бодлого, арга хэмжээ, ашигт малтмал олборлох явцад эвдрэл, элэгдэлд орсон газрын гадаргуу, хөрсийг нөхөн сэргээх, гарч болзошгүй хорт нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг ашиглагчаар гүйцэтгүүлж, түүнд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай.

Орд газрын нөөцийг өөрчлөн ашиглахыг зогсоох, үндсэн ба дагалдах баялгийг иж бүрэн хаягдалгүй ашиглах, алтны уурхайнууд болон аж ахуйн нэгжүүдэд ашигт малтмалын тухай хуулийг болон байгаль орчныг хамгаалах тухай хууль, холбогдох эрх зүйн актуудыг мөрдүүлэхэд чиглэгдэж байна.

Энэ гэмт хэргийн субъектив тал нь санаатай, шунахай сэдэлтээр илэрдэг бол **субъект** нь ашигт малтмалын хайгуул хийх, олборлох зөвшөөрөлгүй этгээд байна. Ихэнхи тохиолдолд аж ахуйн нэгж, байгууллагын эзэн, захирал энэ төрлийн гэмт хэргийн субъект байдаг. Хэрэв тусгай зөвшөөрөлгүй этгээд ашигт малтмалыг онц их хэмжээгээр олборлосон бол ялын хүндрүүлэх нөхцөл байдал болно.

Судлаачийн зүгээс дараахь **дүгнэлтэд** хүрээд байна. Үүнд:

1. Эрүүгийн хуулийн 214 дүгээр зүйл буюу тусгай зөвшөөрөлгүй этгээд ашигт малтмалын хайгуул хийсэн, олборлосон бол гэсэн объектив талын заалт нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй, хор уршиг шаардаагүй байгаа нь уг гэмт хэргийг нотлох болон зүйлчлэлд хүндрэл учруулж байна. Иймд 214 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн бүрэлдэхүүнийг материаллаг бүрэлдэхүүнтэй болгох, өөрөөр хэлбэл, энэ хэргийн улмаас үлэмж хэмжээний хор уршиг учирсан бол, түүнчлэн зөвшөөрөлтэй боловч хайгуул хийх, олборлох журмыг ноцтой зөрчсөн, нөхөн сэргээлт хийгээгүйн улмаас байгаль орчинд үлэмж хэмжээний хор уршиг учруулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр өөрчлөн найруулах шаардлагатай.
2. Эрүүгийн хариуцлага хүлээх субъект нь зөвхөн хувь хүн байгаа одоогийн үзэл баримтлалыг өөрчилж, аж ахуйн нэгж, байгууллагыг гэмт хэргийн бүрэлдэхүүний субъект байхаар ерөнхий ангид тусгаж байгууллагад хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээг хуульчилж өгөх шаардлагатай. Олон улсын жишгээр бол /ихэнхдээ Англо-Саксоны эрх зүйн тогтолцоотой орнуудад\ аж ахуйн нэгж,

⁵⁰ Монгол Улсын Дээд шүүхийн тогтоолын эмхэтгэл. УБ., 2004 он. 260 дахь тал.

байгууллагад 3 төрлийн эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг ба энэ нь торгууль, тодорхой хугацаанд үйл ажиллагаа явуулахыг нь хориглох \1-5 жил\, байгууллагын эд хөрөнгийг хурааж, татан буулгах зэрэг болно. Байгаль орчинд ноцтой хохирол учруулж байгаа субъект нь аж ахуйн нэгж, байгууллагууд бөгөөд одоогийн Эрүүгийн хуулиар хариуцлага тооцох гэхээр тухайн байгууллагын удирдлага буюу гүйцэтгэх захирлыг л хариуцлагад татах болдог, тэр нь өмчийн эзэн бус хөлсний менежер төдий байдаг. Гүйцэтгэх захирлыг хариуцлагад татлаа гэхэд байгууллагын хууль зөрчсөн үйл ажиллагаа үргэлжилж, байгаль орчинд хор хөнөөл учруулсаар өөр гүйцэтгэх захирлыг томилоод л асуудал шийдэгддэг. Нэг жишээ дурдахад, Өвөрхангай аймгийн Өлзийтийн алтны уурхай \Эрэл компаний\ нутгийн байгаль орчинд ноцтой хор уршиг учруулсан тул Эрүүгийн хуулийн 204 дүгээр зүйлд зааснаар гүйцэтгэх захирал Б-д эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан ба хэрэг прокурор дээр хянагдаж байхад Б-н оронд өөр гүйцэтгэх захирлыг томилон ажиллуулсан тул Б-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн, харин хохирлыг хэн ч барагдуулаагүй. Уг алтны үйлдвэр дур зоргоороо үйл ажиллагаагаа явуулсаар л байна.

3. Торгох ялыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулах нь амьдралтай нийцэхгүй, хүний эрхийг ноцтой зөрчих байдалд хүргэж байна. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг Засгийн газраас тогтоодог. Түүний байнга өсөн нэмэгдэж байгаа нь хохирлын хэмжээ, гэмт хэрэгт тооцох шалгуурыг өсгөсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд улам хүндрэлтэй болж байна. Түүнчлэн ялын бодлого хууль тогтоогчийн хүсэл зоригоос үл хамаарч улам бүр хүндэрч байгаа зэрэг нь энэ ялын агуулгыг өөрчлөх шаардлагатай болсныг харуулж байна. Торгуулийн ялыг Монгол Улсад үндсэн ялын чанартай хэрэглэж байгаа нь дэлхий нийтийн жишигт нийцэхгүй байгаа тул үндсэн болон нэмэгдэл ялын \холимог\ чанартай хэрэглэдэг болох нь зүйтэй.

ГЭМТ ХЭРГИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ СУБЪЕКТЫН НАСЫГ ХУУЛЬЧИЛЖ ИРСЭН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ

*Б.Мөнхзул
ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүйн
тэнхимийн багш, магистр*



Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектын тухай ухагдахуун нь анхаарал татсан чухал асуудлын нэг бөгөөд үүний дотор гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектын үндсэн шинжийн нэг болох насыг хэрхэн зөв тодорхойлох нь эрүүгийн хуулийн хөгжилт болон төрийн эрүүгийн бодлоготой нягт холбоотой байдаг.

Хүний нас бол хувь хүнийг тодорхойлох нэг гол шинж бөгөөд өөртөө биологи, сэтгэл зүй, нийгмийн, эрх зүйн зэрэг олон хүчин зүйлийг багтаасан өргөн хүрээтэй ойлголт юм.⁵¹ Үе үеийн Монгол улсын Эрүүгийн хууль тогтоомжийг судлахад гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектын насыг ялгавартайгаар янз бүрээр хуульчилж ирсэн байна. Гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектийн насыг Эрүүгийн хуульд хэрхэн тодорхойлох нь зөвхөн хууль тогтоогчийн ашиг сонирхол, хувийн үзэмжээр шийдэх асуудал биш бөгөөд энэ нь анагаах ухаан болон нийгмийн шинжлэх ухааны онолын үндэс дээр тулгуурлан тодорхойлох асуудал юм.

Гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектын насыг Эртний хууль тогтоомжид хуульчилж ирсэн уламжлалыг авч үзвэл:

Алтан хааны цаазын бичигт:

Уг цааз бичгийн хулгайн цаазад "... 10 наснаас доош бол хулгайчид үл тооц, 10 наснаас дээш бол хулгайчид тооц"⁵² гэсэн нь гэмт хэргийн бүрэлдэхүүний насыг шууд зааж өгсөн анхны хууль цааз юм. Мөн 1640 оны Монгол- Ойрадын их цаазад гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектын насыг 10 насаар тогтоосон байдаг байна⁵³.

Монгол цаазын бичигт:

Гэмт хэргийн субъектын нас 10 байсан ба 10-15 насны хүүхэд хэрэг үйлдвэл золио авч төлүүлдэг, 16 наснаас дээш бол ялыг нь эдлүүлдэг байжээ⁵⁴. Энэ нь субъектын насыг 10 гэж тогтоосон боловч 16 нас хүрээгүй бол ялыг биеэр эдлүүлдэггүй байжээ.

Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичигт:

Хулгайн хэргийн субъектын насыг 10 наснаас дээш байхаар тогтоож 10-15 насны хулгай хийсэн хүнийг шүүх яаманд мэдүүлж хууль ёсоор золио авах, торгох ял

⁵¹ Г.Гантөмөр. Гэмт хэргийн бүрэлдэхүүний онол. УБ.,2003.131 дэх тал

⁵² Т.Алтангэрэл. 16-17-р зууны Монгол цаазын бичгүүд. УБ.1999.,37 дахь тал

⁵³ Т.Алтангэрэл. Монгол- Ойрадын их цааз, түүний судалгаа. УБ.1998.,40дахь тал

⁵⁴ Б.Баярсайхан. Монгол цаазын бичиг. УБ.2001.337 дахь тал

оногдуулахаар заасан⁵⁵ байна. Эдгээр хууль тогтоомжид заасныг дүгнэж үзвэл гэмт хэргийн бүрэлдэхүүний нас 10-аас эхэлж байсан ба ихэнхдээ хулгайн гэмт хэргийн хувьд нас заасан, насанд хүрээгүй хүний үйлдсэн хэргийг гэмт хэрэгт тооцож байгаа боловч ял нь хөнгөн байгаа явдал ажиглагдаж байгааг анхаарч нийгмийн өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан явагдаж буй эрх зүйн шинэчлэлийн асуудалд тусгах талаар тодорхой саналыг дэвшүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Монгол улсын шинэ үеийн хуулиуд буюу төрөлжсөн Эрүүгийн хууль тогтоомжид хэрхэн хуульчилж ирснийг авч үзвэл:

1926 он БНМАУ-ын Шүүх цаазын бичигт:

Уг хуулийн 17-р зүйлд "...11 наснаас 14 нас хүртэлх багачууд хөнгөн ял халдваас тэднийг эцэг, эх буюу итгэмж бүхий хүмүүс нь хүлээн авсугай, хэмээвээс даруй тушаан өгч сурган хүмүүжүүлж болох ба хэрэв хүнд ял халдваас засан сайжруулах газар тушаан өгч сурган хүмүүжүүлвээс зохихоос гадна 15,16,17 насны залуус хэрэгт халдваас бусад ялтнаас тусад нь хорьж цээрлүүлэн шийтгэвээс зохино⁵⁶ хэмээн тусгажээ. Энэхүү заалт нь тухай үеийн нийгмийн мөн чанартай холбоотой бөгөөд 11-14 насны этгээд хөнгөн гэмт хэрэг үйлдвэл эцэг эх буюу асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлтээр хараа хяналтанд өгөх, хүнд гэмт хэрэг үйлдвэл одоогийн хуульд хуульчилсантай төстэй буюу хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авч хэрэгжүүлэх, харин 15-17 насны этгээд гэмт хэрэг үйлдвэл оногдуулсан хорих ялыг насанд хүрсэн этгээдээс тусад нь эдлүүлэх тухай заажээ. Энэ нь Монгол улсад насанд хүрээгүй хүүхдийн хорих анги тусдаа байх үндэс суурь нь байж болох юм.

1929 он БНМАУ-ын Шүүх цаазын бичигт:

19-р зүйл. 14 нас хүртэлх багачууд гэмт хэрэг үйлдвээс нийтийн хуулийг баримталж байцаах буюу шийтгэж үл болох бөгөөд даруй Ардыг Гэгээрүүлэх Яамны харъяат зохих газрууд дор шилжүүлэн өгч байдлыг хянуулан гүйцэтгээд тэдний эцэг эх буюу итгэмж бүхий хүмүүсээс засан сайжруулахыг хүсэх аваас тушаан өгч болмой. Хэрэв тийм этгээд үл байх ахул яамны засан сайжруулах сургууль дор шилжүүлбээс зохино⁵⁷ хэмээн өмнөх хуультай мөн адил насны хэм хэмжээг маш нарийн тусгаж өгсөн байна. Энэ нь 14 нас хүртэлх хүүхдүүдийн үйлдсэн гэмт хэргийг гэмт хэрэгт үл тооцох өөрөөр хэлбэл гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж ойлгож болно.

1934 он БНМАУ-ын Шүүх цаазын бичигт:

7-р зүйлийн 2-т "... 16 нас хүрээгүй багачуудын тухай дор ял үл хэлэлцмөй..." гэж гэмт хэргийн бүрэлдэхүүний насыг 16 байхаар хуульчилсан байх ба энэ тухай Хууль зүйн шинжлэх ухааны доктор /Sh.D/, профессор Г.Совд: бага насны хүүхдийн сэтгэхүйн онцлог, ерөнхий ухамсар зэргийг харгалзсан ач холбогдолтой зохицуулалт гэж дүгнэсэн байна.

1942 оны БНМАУ-ын Эрүүгийн хууль:

11-р зүйл. 14-16 хүртлэх насны хүмүүсээс хулгай хийх, хүч хэрэглэх, бусдын бие махбодид хор хүргэж гэмтэл учруулах, бусдын амийг хорлох буюу амийг хорлохоор оролдох явдлуудыг гаргавал эрүүгийн хариуцлагад татна⁵⁸ хэмээсэн нь тодорхой төрлийн зарим гэмт хэрэгт субъектын нас өөр байх шинэлэг зохицуулалт болсон байна.

1961 оны БНМАУ-ын Эрүүгийн хууль:

⁵⁵ Г.Гантөмөр. Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол. УБ. 2003., 136 дахь тал

⁵⁶ Д.Адъяабазар. Монгол улсын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. УБ., 1998. 11 дэх тал

⁵⁷ Д.Адъяабазар. Монгол улсын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. УБ., 1998. 40 дэх тал

⁵⁸ Д.Адъяабазар. Монгол улсын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. УБ.1998.110 дахь тал

6-р зүйлийн А-д. Гэмт хэрэг үйлдсэн этгээд уг гэмт хэргийг үйлдэх үедээ 16 нас хүрсэн бол түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. 6-р зүйлийн Б-д. 14-16 хүртэлх насны хүмүүс хүн алах, бусдын бие махбодыг санаатайгаар гэмтээх буюу эрүүл мэндийг сарниулах, хүчиндэх, хулгай дээрэм хийх, хүндрүүлэх шалтгаантайгаар танхайрах, улс олон нийт иргэдийн эд хөрөнгийг устгах буюу эвдэж ноцтой хор хохирол учруулах түүнчлэн галт тэрэг, автомашин онхолдуулах гэмт хэргийг санаатай үйлдсэн бол эрүүгийн хариуцлага хүлээнэ хэмээн өмнөх хуульд зааснаас харьцангуй олон гэмт хэрэгт субъектын нас 14 байхаар тусгасан байна.

1986 оны БНМАУ-ын Эрүүгийн хууль:

Уг хуулийн 9-р зүйлийн 9.1-д зааснаар: Гэмт хэрэг үйлдэхийн өмнө арван зургаан насанд хүрсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. 9-р зүйлийн 9.2-д зааснаар арван дөрвөөс арван зургаа хүртэл насны этгээд бусдыг алах, бусдын бие махбодид хүнд буюу хүндэвтэр гэмтэл санаатай учруулах, хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдыг зодох, хүчиндэх, улс хоршоолол, олон нийтийн болон иргэдийн амины эд хөрөнгийг дээрэмдэх гэх мэт 22 төрлийн гэмт хэргийг үйлдсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь өмнөх хуультай төстэй зохицуулалт болжээ.

2002 оны Монгол улсын Эрүүгийн хууль:

21-р зүйлийн 1-д: гэмт хэрэг үйлдэх үедээ 16 насанд хүрсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. 21-р зүйлийн 2-т: Арван дөрвөөс арван зургаа хүртэл насны этгээд энэ хуулийн тусгай ангийн 91 /Хүнийг санаатай алах/ 96 /Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах/, 126 /Хүчиндэх/, 145 /Бусдын эд хөрөнгийг хулгайлах/, 146 /Бусдын эд хөрөнгийг булаах/, 147 /Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх/, 153 /Бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгах гэмтээх/, 181.3 /Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар танхайрах/-т заасан нийгмийн хор аюулаар их, гэмт хэргийн ангилалтаар хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн бол түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заажээ⁵⁹.

Дээрх гэмт хэргүүдийг үйлдсэн 14-16 насны этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх болсныг С.Нарангэрэл гэмт хэргийн нийгмийн хор аюулыг ойлгох оюун сэтгэл зүйн хөгжилтийн хэмжээтэй холбон тайлбарласан харин Г.Гантөмөр нийгмийн хор аюул нь насанд хүрээгүй этгээдэд урьдаас илэрхий байдаг, насанд хүрээгүй этгээдүүдээс түгээмэл үйлддэг мөн эдгээр гэмт хэргүүдтэй тэмцэх өөр арга байхгүйтэй холбоотой хэмээн үзсэнтэй судлаач миний бие санал нэг байна.

Шинэчилсэн Засгийн газрын бодлогын нэг болох эрхзүйн шинэчлэл хийгдэж байгаатай холбогдуулан Эрүүгийн хуулийг шинэчлэх ажил өрнөж байгаа бөгөөд бидний хөндөж буй гэмт хэргийн субъектын насны талаар шинээр боловсруулагдаж байгаа хуулийн төсөлд хэрхэн тусгасныг авч үзвэл:

“Гэмт хэргийн тухай хуулийн төсөл”⁶⁰-ийн 5.2 дугаар зүйлд ял эдлэх хүний насыг заасан байна.

1. Гэмт хэрэг үйлдэх үедээ 14 насанд хүрсэн хүнд ял оногдуулна.
2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан насанд хүрсэн боловч сэтгэцийн хөгжлийн хоцрогдлын улмаас гэмт хэрэг үйлдэх үедээ өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн хууль бус шинж, түүний улмаас учрах хор уршгийг бүрэн хэмжээгээр ухамсарлах чадваргүй байсан болох нь тогтоогдсон хүнд ял оногдуулахгүй.
3. Гэмт хэрэг үйлдэх үедээ энэ хуульд заасан ял оногдуулах насанд хүрсэн боловч 18 насанд хүрээгүй хүнд ял оногдуулахгүйгээр энэ хуульд заасан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно гэсэн нь одоогийн мөрдөгдөж

⁵⁹ Монгол Улсын Эрүүгийн хууль.21-р зүйлийн 2 дахь хэсэг. Төрийн мэдээлэл. 2002.,№2

⁶⁰ Хууль зүйн яам. Гэмт хэргийн тухай хуулийн төслөөс

байгаа хуультай харьцуулахад субъектын насыг 14 болгон багасгасан боловч насанд хүрээгүй этгээд хөнгөн, хүндэвтэр гэмт хэргийг анх удаа үйлдсэн этгээдэд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болох тухай зохицуулалтыг гэмт хэргийн ангилал, анх удаа үйлдсэн эсэхийг нь харгалзахгүй хэрэглэж болохоор заасан байна. Мөн 14 насанд хүрсэн боловч сэтгэцийн хөгжлийн хоцрогдлын улмаас үйлдлийн шинж, хор уршгийг бүрэн ухамсарлах чадваргүй гэдэг нь тогтоогдвол эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй тухай шинэлэг зохицуулалт орсон байна.

Эцэст нь дүгнэж үзэхэд субъектын насыг Монгол улсын Эрүүгийн хууль тогтоомжид ялгамжтайгаар тогтоож ирсэн ба Эртний хууль тогтоомжууд болон 1926 оны Шүүх цаазын бичигт субъектын насыг 10, 11 байхаар тогтоож байсан ба 1929 оны Шүүх цаазын бичигт насыг 16 байхаар хуульчилж эхэлсэн бөгөөд 1942 оны БНМАУ-ын Эрүүгийн хууль тогтоомжоос тодорхой гэмт хэрэгт субъектын нас 14 байхаар тогтоож өгчээ. Сүүлийн үед 14 насанд хүрээгүй этгээд онц жигшүүртэй гэмт хэрэг үйлдэх болсон нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн буруу нөлөөлөл, РС тоглоом, тухайн үеийн нийгмийн хүүхдийн хөгжил, насны онцлог зэргээс хамааралтайг анхааран субъектын насыг зөв тогтоож гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял завшуулахгүй тохирсон ял оногдуулах нь зүйтэй юм. Мөн гэмт хэргийн субъектын нас хүрээгүй этгээдээр гэмт хэрэг үйлдүүлэн амьдарч буй этгээдүүд байгааг анхаарах нь чухал юм.

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ЦАХИМ ГАВНЫ ТУХАЙ



Төрсөн газар: 1965 онд Улаанбаатар хотод төрсөн.

Мэргэжил: Хуульч, эрх зүйч

Боловсрол: Дээд, Хууль зүйн ухааны доктор (Ph.D), ОХУ-ын Дотоод явдлын Яамны Академи, АНУ Лос-Анжеласын Цагдаагийн Академид Цагдаагийн байгууллагын Удирдахуйн ухааны менежер, Монгол Улс Удирдлагын хөгжлийн Академид Удирдахуйн ухааны менежер.

Эрхэлж байсан ажил: 1989-1990 онд СБДЦХ-т төлөөлөгч, 1990-1994 онд Эрүүгийн Цагдаагийн Газрын дарга, 1994-1998 онд Эрүүгийн Цагдаагийн газарт чиглэлийн ахлах төлөөлөгч, 1998-1999 онд БГДЦХ-ийн дэд дарга, 1999-2001 онд Эрүүгийн Цагдаагийн Газрын дэд дарга, 2001-2011 онд Цагдаагийн

АС: Танд энэ өдрийн мэндийг хүргэе!

ХР: Баярлалаа. Танд ч бас энэ өдрийн мэндийг хүргэе!

АС: Таны тухай, түүн дотроо эрхэлж байсан ажлын тань талаар цухас сонирхвол ямар вэ?

ХР: Би 29 жил Цагдаагийн байгууллагад тэр тусмаа Эрүүгийн цагдаагийн албанд илүү ажилласан. 2009 онд "Хүнийг санаатай алах гэмт хэрэгтэй тэмцэх" чиглэлээр МУИС-д хууль зүйн ухааны доктор цолыг хамгаалсан.

АС: Та гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэхэд зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудын талаар ярьж байсан. Тэр сэдвээр тантай өнөөдөр ярилцъя гэж бодлоо?

ХР: Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил нь манай улсад хэлбэрийн төдий л яригдаж, явагдаж байгаа, Тухайлбал: Хичнээн гэмт хэрэг үйлдэгдэхээс, ямар хохирол учрахаас урьдчилан сэргийлж байна вэ гэдэг нь ч тодорхой байх шаардлагатай бөгөөд урьдчилан сэргийлэх болон урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг үнэлэх асуудал дээр ч анхаарах цаг болсон.

Сүүлийн үед гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэх нь өсөн нэмэгдэж, нийгэм, улс оронд болон ард иргэдэд ихээхэн хэмжээний хор хохирлыг учруулах, айдсыг бий болгох явдал өсөх хандлагатай байгаа бөгөөд үүний эсрэг арга хэмжээнд ашиглаж болох хамгийн оновчтой олон аргуудын нэг нь гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдийг байнгын хяналтанд байлгаж, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нэгэнт үйлдэгдсэн тохиолдолд илрүүлэх, эрэн сурвалжлах зорилгоор ашиглах зориулалт бүхий **Цахим гав**-ыг хэрэглэх явдал юм. Өнөөдөр дэлхийг тойрон ажиллаж буй 27 ширхэг хиймэл дагуулаас 24 хиймэл дагуул нь идэвхитэй горимд ажиллаж GPS төхөөрөмжийг дэлхийн хаана байгааг хянаж байдаг. Цахим гав гэдэг нь GPS системд суурилсан хяналтанд авах шаардлагатай хүний гарт болон хөлд зүүх зориулалт бүхий бугуйвч хэлбэрийн төхөөрөмж бөгөөд хяналт тавих шаардлагатай хүмүүст зүүлгэснээр уг этгээдийг байнгын хяналтанд байлгах зориулалт бүхий төхөөрөмж гэж ойлгож болно. Цахим гав нь байршлыг тодорхойлох, аюулын буюу тусламж хүссэн дуудлага хийх, бодит байдалд хяналт тавих, явахыг хориглосон газрыг

тэмдэглэх, зай дууссан, хэрэглэгч хөдөлгөөнгүй болсон үед нэмэлт дохиог төврүү илгээх ба Google map хэрэглэж болно. Мөн нууцлалын программтай, өнгө үзэмж сайтай, бусад хүмүүст ил харагдахгүй байх боломжтой, гэмт этгээд уг төхөөрөмжийг тайлах болон тайлахыг оролдох үед түгшүүрийн дохиог хяналтын болон цагдаагийн байгууллагад мэдээлэх зэрэг маш олон төрлийн үзүүлэлтүүдтэй төхөөрөмж юм.

АС: Одоогийн байдлаар хууль хяналтын байгууллагаас явуулж буй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг та юу гэж бодож байна вэ?

ХР: Яах вэ одоо бол гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил гэж яриад л байгаа бодитой үр дүнтэй ажил харагдахгүй байна. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад өөрт учирах эрсдлүүдийг урьдчилан тооцож, төлөвлөгөөтэй тодорхой арга хэмжээнүүдийг авах нь чухал байдаг. Өнөөдрийн байдлаар өдөрт дунджаар 5 хүний амь нас ямар нэг байдлаас хамаарч хохирч байна. Энэ нь жилээр тооцохоор их олон тоо гарч байгаа нь харамсалтай санагддаг. Монгол Улсын ҮАБ-ийн үзэл баримтлалаар хүний аюулгүй байдлыг хангах талаар нэн тэргүүнд тавьсан боловч энэ нь хэлбэрийн төдий л цаасан дээр тэмдэглэгдэж, урьдчилан сэргийлэх ажил бодитой үр дүнд хүрэхгүй өдийг хүрлээ. Мөн өнөөдөр байгалийн үзэгдэл, гамшигаас шалтгаалан олон тооны мал сүрэг үхэж, үрэгдэж өвчин тусч байгалийн гамшигт нэрвэгдэж байгаа нь хэзээ ч нөхөгдөшгүй юугаарч сольшгүй тийм харамсалтай зүйл гэдгийг бодитой ухаарч төр засаг, хууль хяналтын байгууллагаас хүн, мал, ан амьтаны амь нас хохирсны дараа бус өмнө нь урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлж эхлэх цаг нь болсон гэж үзэж байна.

АС: Урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг хэрхэн тооцох ёстой вэ?

ХР: Харин тийм. Урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг тооцох хэмжүүр, үзүүлэлт, урамшуулалын тогтолцоо зайлшгүй үгүйлэгдэж байна. Жишээ нь: Хүнийг санаатай алах гэмт хэргийг илрүүлсэн ажилтанг урамшуулан, төрийн одон медалиар шагнадаг. Гэтэл хүнийг санаатай алахаас, амь насыг нь хохирхоос нь өмнө урьдчилан сэргийлбэл ямар үзүүлэлтээр шагнаж урамшуулах нь ойлгомжгүй мэт санагдаад байгаа юм.

АС: Сүүлийн үед Цагдаагийн байгууллагууд дээр шинэчлэлт өөрчлөлтийн талаар их ярьж байна. Энэ талаар та юу гэж бодож байна?

ХР: Цагдаагийн байгууллагад сүүлийн жилүүдэд шинэчлэлт өөрчлөлттэй холбогдолтой бүтэц зохион байгуулалтын болон хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлийн олон өөрчлөлт хийгдэж байна. Гэхдээ 1990 оноос хойш цагдаагийн дүрэмт хувцасны өнгө, загвар, үзэмжийн тал дээр л хэтэрхий анхаарснаас биш яг гэмт хэрэгтэй тэмцэх арга тактик, шинжлэх ухааны ололт амжилтыг нэвтрүүлэх, гадаад орны туршлагаас судлах, боловсон хүчний сургалт бэлдэх ажил дээр анхаарч төдийлөн сайн шинэчлэлт, өөрчлөлт хийсэн гэж миний хувьд бодохгүй байна.

Харин сүүлийн жилд хийсэн ажлын нэг ололттой тал нь боловсон хүчинтэй холбоотой шинэчлэлт өөрчлөлт байсан юм боловуу!



АС: 1990-д оноос хойш Монгол улсад үйлдэгдэж буй гэмт хэргийн тоо ихэсч, гэмт хэргийн төрөл нэмэгдсэн төдийгүй үйлдлийн арга нарийсч, улам харгис хэрцгий болж байгаа нь хуулийн байгууллагуудын судалгаанаас харагдаж байгаа. Үүнээс үүдэн дээрхи төхөөрөмжийг манай улсад хэрэглэх нийтийн хэрэгцээ шаардлага зүй ёсоор урган гарч байгаа гэж ойлгож болох уу?

ХР: Судалгаанаас харахад МУ-ын хэмжээнд зөвхөн 2012 онд 19734 хүн гэмт хэрэгт холбогдсоноос 71 хүн захиргааны хяналтанд байхдаа, 161 хүн хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын шатанд батлан даалтанд байхдаа гэмт хэрэг дахин үйлдсэн байна.

-Одоо хоригдож байгаа 6911 ялтаны 3414 нь давтан гэмт хэрэг үйлдэж дахин ял шийтгүүлсэн байх ба хэрэв эдгээр давтан гэмт хэрэг үйлдсэн 3414 хүн, дээр дурьдсан 161 хүнд цахим гавыг хэрэглэж хяналт тогтоосон бол 70%-80% нь, түүнээс ч илүүгээр гэмт хэрэгт холбогдохгүй байх, цаашлаад иргэд, байгууллагад тэр хэмжээгээр хохирол учрахгүй байх бололцоотой байжээ гэж үзэж болохоор байгаа.

-2012 онд 2794 ялтан ерөнхийлөгчийн зарлиг болон өршөөлөөр, хугацаа дуусч суллагдсан байх ба захиргааны хяналтанд нийт 2573 хүн, 382 хүүхэд хорих ял шийтгүүлж хойшлогдсон гэсэн шалтгаанаар Цагдаагийн байгууллагын хяналтанд байна. Эдгээр тоо баримтуудаас нэгтгэн дүгнэж нийт эрүүгийн гэмт хэрэгт холбогдогчдын болон давтан гэмт хэрэг үйлдэгчдийн тоо, захиргааны хяналтанд авагдах этгээдүүдийн тоог гаргасны үндсэн дээр цахим гавыг байнгын хэрэглэх субъектуудын тоог тодорхойлж болохоор байгааг харж болно. Одоо ч УИХ-аар Өршөөлийн хууль хэлэлцэгдэж байгааг та бүхэн мэднэ.

Өнөөдөр гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдаж байгаа, гэмт хэрэг үйлдээд суллагдсан, гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдүүдэд тавих хуулийн хяналт нь хэлбэрийн төдий байгаагаас дээрх этгээдүүдээс гэмт хэрэг дахин үйлдэх, нийгэмд түгшүүртэй аюултай байдлыг бий болгох, хүний амар тайван аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хязгаарлаж байна.

АС: Тэгвэл цахим гавыг эн тэргүүнд хэрэглэх шаардлагатай ямар хүмүүс байна вэ?

ХР: 1-рт: Хорихоос суллагдсан этгээдүүдийг давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хуульд заасан журмын дагуу захиргааны хяналт тогтоох үүргийг цагдаагийн байгууллага хэрэгжүүлдэг. Захиргааны хяналтанд авагдах ёстой этгээд хэсгийн байцаагчид анх бүртгүүлснээс хойш сард нэгээс доошгүй удаа биеэр очиж бүртгүүлэх үүрэгтэй гэж Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд заасан байдаг нь тэднийг бусад бүхий л хугацаанд хяналтгүйгээр, сул чөлөөтэй байх, цаашлаад гэмт хэрэг үйлдэх боломжийг олгож байна гэхэд хилсдэхгүй. Захиргааны хяналтыг үр дүнтэй авч хэрэгжүүлж, хяналтанд байх ёстой хүн нэг бүрт цахим гавыг хэрэглэж байнгын хяналтанд байлгах шаардлагатай. Ингэснээр хяналтанд бүрэн аваад зогсохгүй уг этгээдийн зүгээс гэмт хэрэг үйлдэх гэсэн санаа сэдлийг бууруулах ач холбогдолтой.

/2012 онд улсын хэмжээнд 2004 ялтан суллагдаж,захиргааны хяналтанд 2573 хүн бүртгэгдсэн байх ба шүүхээс 1597 хүн ял тэнсэгджээ. Мөн онд 8324 хүн ял шийтгүүлснээс 1544 нь урьд ял шийтгүүлсэн этгээдүүд байгаа бөгөөд үүнээс онц аюултай гэмт хэрэгтэн 98 нь байгааг судалгаанаас харж болно./

2-рт:Гэмт хэрэг үйлдсэний улмаас хуулийн байгууллагад шалгагдаж байгаа этгээдүүдээс гэмт хэрэг үйлдэх,хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурор, шүүхийн шатнаас оргон зайлах явдал их байгааг судалгаанаас харж болно.Иймд уг хүмүүст хэрэглэснээр оргон зайлах, дахин гэмт хэрэг үйлдэх явдлыг ихээхэн хэмжээгээр бууруулах хөшүүрэг болж чадна.Бараг бүрмөсөн буурна гэхэд хилсдэхгүй болов уу.

/2012 онд нийт 19734 хүн гэмт хэрэг үйлдсэнээс хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын шатанд

болон эрх хязгаарлах арга хэмжээ авагдсан үедээ 161 хүн дахин гэмт хэрэгт холбогдсон гэх

тоо баримтаас харахад энэ шатанд дээрхи төхөөрөмжийг хэрэглэх хэрэгцээ шаардлага нэгэнт үүссэн гэдэг нь харагдаж байна/

3-рт: Ял эдэлж буй иргэнийг чөлөөгөөр гадуур гарах, гадуур хөдөлмөр эрхлүүлэх, хуяглан хүргэх, мөн гэрийн хорионд байгаа болон тодорхой эрхийг нь хязгаарласан хүнд цахим гавыг хэрэглэх. Энэ тохиолдолд ял эдэлж буй иргэнийг оргон зайлахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ болох бөгөөд оргон зайлсан тохиолдолд уг төхөөрөмжөөр байршил, замыг шууд тогтоон баривчлах боломжтой ба ингэснээр эрэн сурвалжлах ажиллагааны зардлыг хэмнэх, хамгийн чухал үр дүн нь дахин гэмт хэрэг үйлдэх явдлаас урьдчилан сэргийлнэ.ШШГБ-ын хувьд хоригдол оргосон гэх нийгэмд төрүүлсэн айдсыг хурдан хугацаанд арилгах зэрэг ач холбогдолтой юм.

Дэлхийн улс орнуудад зөвхөн гэмт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх,нийгмийн хэв журам хамгаалах тусгай зориулалтаас гадна ахуйн хэрэглээнд өндөр настан, сэтгэцийн өвчтөн, тээврийн хэрэгсэл, үнэт эд зүйл, тэжээвэр амьтан, мал зэргийн байршил, хөдөлгөөн хянахад ашигладаг туршлага бий. Өнөөдөр манай улсад дархан цаазат амьтан, тул загас,тээврийн хэрэгсэлд байршуулж ашиглаж байгаа бөгөөд цаашид ашиглагдах бүрэн боломжтой гэж үзэж байгаа юм билээ.



АС:Дээрхи төхөөрөмжийг манай улсад шууд хуулбарлан хэрэгжүүлэх боломжыг та хэрхэн үнэлж байна вэ?

ХР: Манай улсад уг төхөөрөмжийг нэвтрүүлэхэд доорхи боломжууд бүрэн байгаа юм.

1. Уг төхөөрөмжийг хэрэгжүүлэх, хяналт тавихад манай улсынзасаг захиргааны нэгжийн зохион байгуулалт, нутаг дэвсгэрийн хуваарилалт бүрэн зохицоно. Жишээ нь нийслэлд дүүрэг хорооны, аймагт аймаг, сумын хууль сахиулах байгууллагын ажилтан шууд хяналтыг тавьж хэрэгжүүлэх боломжтой юм.Түүнчлэн шаардлагатай холбоо харилцаа, техник хэрэгсэл,дэд бүтцийн салбарт нь ажиллах мэргэжлийн боловсон хүчний хувьд бүрэн боломжтой байгаа гэж үзэж болно.

2.Хууль сахиулах байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтын хувьд мөн бусад орны адил зохицоно.Жишээ нь хяналтыг Цагдаагийн Байгууллагын захиргааны хяналт тавих үүрэг бүхий ажилтнууд тавьж, давхар хяналтыг шууд удирдлага болон хэрэг зөрчлийн шалгалтад хяналт тавихтай адилаар Прокурорын байгууллагаас хариуцаж болно.

3. Энэтхэг, Америк, Мексик зэрэг манай улстай адил нутаг дэвсгэр томтой, зохих этгээдүүдэд шууд хяналт тавих боломж муутай орнуудад шинжлэх ухаан, техникийн ололтыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх ажиллагаанд ашиглаж, уг төхөөрөмжийг амжилттай хэрэглэж өндөр үр дүнд хүрч буй түршлагаас харахад манай улсад ашиглах бүрэн боломжтой юм.

Гэхдээ Монгол Улсын нутаг дэвсгэрт, газар зүйн байрлал, зан заншил, хүний эрх, эрх чөлөөг хангах зэрэг онцлогоос шалтгаалан тухайн техникийг хэрэглэхдээ анхаарч үзэх зүйлс байгааг үгүйсгэхгүй.

АС:Уг төхөөрөмжийг нэвтрүүлж үр бүтээлтэй ашиглахын тулд эн тэргүүнд ямар ажлуудыг хийх шаардлагатай вэ?

ХР: -Шаардлагатай мэргэжлийн ажилтнуудыг багтаасан судалгааны багийг бүрдүүлж төсөл боловсруулан хэрэгжүүлэх.

-Санхүүгийн асуудлыг шийдвэрлэхийн тулд тендер зарлан сонгон шалгаруулах замаар дотоод, гадаадын хувийн хэвшлийн байгууллагуудыг оролцуулан шийдвэрлэх боломжтой юм.Гэмт хэрэгтнийг хуяглан хүргэх, гадуур хөдөлмөр эрхлэх,онцгой дэглэмд болон гянданд хоригдож байгаа ялтнуудад хэрэглэх г.м зарим тохиолдолд гарах зардлыг төрийн зүгээс хариуцдаг, бусад тохиолдолд хяналтанд авагдах хүмүүсээс өөрсдөөс нь зардлыг гаргуулдаг байх зэрэг нөхцлүүд байж болно.

АС: Цахим гавыг Монгол улсад нэвтрүүлсэнээр ямар чухал ач холбогдолтой болох талаар та дурьдана уу?

ХР: Дээрхи баримтуудаас дүгнэж үзэхэд цахим гавыг гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдүүдэд зүүлгэн байршуулж, байнгын хяналтанд байлгаж чадсанаар:

1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулахад нөлөөлж, үүний үр дүнд үйлдэгдэх гэмт хэргийн тоо буурч, иргэдийн амар тайван амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой.

2.Хууль сахиулах байгууллагуудын шинэчлэлт өөрчлөлтийн зорилго нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх тогтолцоог боловсронгуй болгоход чиглэн хийгдэж байгаа тул уг төхөөрөөмжийг ашиглах, түүнээс гарах эерэг үр дүн нь уг зорилготой нийцнэ.

3.Гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх ажиллагаанд шинжлэх ухаан техникийн ололтыг ашигласнаар өмнөх хяналт тавьж үйл ажиллагаа хөнгөвчлөгдөн чанаржиж, бусад ажилд зарцуулах зав, боломж нэмэгдэнэ.

4.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, эрэн сурвалжлах ажиллагаанд төрөөс төсөвлөж зөрцуулах их хэмжээний зардлыг багасгах чухал ач холбогдолтой. Мөн CCTV хяналтын дэвшилтэт системийг хослуулан нэвтрүүлж камерын хяналтыг сайжруулсан тохиолдолд гэмт хэргийн илрүүлэлт эрс нэмэгдэх ач холбогдолтой г.м олон давуу талтай юм.

5.Мөн гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдүүд байнгын хяналтанд байгаа болохоо мэдэж байгаа учраас гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд илчлэгдэнэ гэдгээ ойлгосноор гэмт хэрэг үйлдэх санаа сэдэл нь багасна.

6.Нэгэнт үйлдсэн тохиолдолд төхөөрөмжөөс ирэх мэдээллийн дагуу гэмт хэрэгтнийг хурдан шуурхай баривчилсанаар байгууллага, иргэдэдэд материаллаг болон материаллаг бус хохирол, аюул занал учрахаас сэргийлэх чухал ач холбогдолтой юм.

АС: Өнөөдрийг хүртэл энэ техник хэрэгслийг монголд нэвтрүүлж ашиглах боломж байгаагүй юмуу?

ХР: Мэдээж боломж байсан боловч ихээхэн хугацаа алдсан. Гэхдээ энэ нь бас учир шалтгаантай боловчуу. Тус цахим гавыг Монгол улсад нэвтрүүлж ашиглахын тулд хууль тогтоомжуудыг боловсронгуй болгох, санхүүгийн асуудлыг шийдвэрлэх, мэргэжлийн баг, хамт олны үйл ажиллагаанаас ихээхэн шаардлагатай талаар дээр дурьдсан. Энд хуулийн мэргэжилтэн дан ганцаараа энэ асуудлыг хэрэгжүүлэх биш, өөрөөр хэлбэл сайн мэдээлэл технологийн инженер/GPS/,цахимын талаарх мэргэжлийн хуулийн ажилтан, программист, радио долгионы инженер, санхүүгийн шинжээч, мэдээж менежер зэрэг олон мэргэжил албадын хүмүүсийн хамтын ажиллагаа, мэдээж төрийн туслалцаа дэмжлэг, оролцоо, гадаад, дотоод хөрөнгө оруулалтгүйгээр шийдвэрлэхэд хүндрэлтэй. Өнөөдрийн байдлаар Монгол улсад цахилгаан гавыг нэвтрүүлэн хэрэгжүүлэхэд нөхцөл бололцоо, тохироо нь бүрдсэн гэж үзэж байна. Зайлшгүй хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага нь ч тулгамдсан асуудал болсон байна.

АС: Цахим гавыг хэрэглснээр хүний эрх, эрх чөлөөнд халдаж, хязгаарлаж байгаа асуудал биш үү?

ХР: Цахим гавыг гагцхүү хүний эрхийг зөрчиж болзошгүй, хүний эрх, эрх чөлөө, эд хөрөнгөнд халдаж гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдэд хуульд заасан үндсэн журмын дагуу хэрэглэхээр тусгана.Ингэж тэдгээр этгээдүүдийн эрхийг хуулийн дагуу хязгаарласанаар бусад иргэдийнхээ Үндсэн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөг хамгаалж байгаа явдал юм.

АС: Бодит амьдрал дээр цахим гавыг хэрхэн ашиглаж болох вэ? Жишээ дурьдана уу ?

ХР: Гэмт хэрэг үйлдээд суллагдсан этгээдүүдийн өмнө үйлдсэн гэмт хэргийн байдал, ,зан авир,хувийн байдал зэргийг харгалзан үзэж зорчих маршрут, орох газруудад хязгаарлалт хийж болно. Өмнө нь хамтран амьдрагч эмэгтэйгээ байнга дарамтлан зодож гэмтээн ял эдлээд суллагдсан этгээдэд шүүхээс уулзахыг хориглосон тохиодолд хяналтанд авсанаар зүүлгэсэн хяналтын цахим гаванд өмнөх хамтран амьдрагчийн гэр, ажил, зорчих чиглэлийн дагуу явахыг хориглосон программ суулгасан болох, зөрчиж болохгүй талаар өөрт нь мэдэгдэж, уг этгээд шаардлагыг зөрчин маршрутаас гарч өмнөх хамтран амьдрагчтайгаа уулзахыг завдсан үед дохио, мэдээлэл тухайн хяналтын газар буюу цагдаагийн ажилтанд ирнэ. Ингэснээр хууль хяналтын байгууллагын ажилтнууд газар дээр нь түргэн шуурхай очиж хохирогч эмэгтэйн эрхийг хамгаалж хяналтанд авагдсан этгээдийг саатуулах болно.Мөнөмнө нь бизнесийн хүрээнийхнийг дарамталж мөнгө эд зүйл авдаг байсан этгээдэд бизнесийн хүрээний олон нийтийн арга хэмжээ зохиогдох газар, үзвэр үйлчилгээ, ресторан, цэнгээний газар зэргүүдэд очихыг хязгаарлаж, уг газруудаад цахим гавтай хүнд үйлчилдэггүй байх зохицуулалтыг хийж өгөх зэрэг олон хэлбэрээр ашиглаж болно.Энэ тохиолдолд иргэд дээрхи газруудаар айх аюулгүй, амар тайван үйлчлүүлэх, үйл ажиллагаанд оролцох боломжоор хангагдаж байгаа юм.

АС: Сүүлийн асуултыг танд үлдээе!

ХР: Хууль сахиулах байгууллагуудын, тэр тусмаа Цагдаагийн байгууллагын шинэчлэлт өөрчлөлтөөр хууль тогтоомжид нэмэлт заалт оруулах, цагдаагийн байгууллагын бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх өөрчлөлтүүд хийгдэж байгаатай зэрэгцэн шинжлэх ухаан,

техникийн ололт амжилтуудыг гадаад орнуудыг туршлагыг судалсны үндсэн дээр нэвтрүүлж гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, илрүүлэх ажилд ашиглаж хэрэгжүүлэх нь чухал .Гэмт хэрэг,зөрчил үйлдэгдэж иргэдийн эрх зөрчигдсөнийх нь дараа биш үйлдэгдэхээс нь урьдчилан сэргийлж, таслан зогсоож сайн ажиллах ёстой юм.

Цаг зав гаргаж бидэнтэй ярилцсан танд баярлалаа. Таны ажилд амжилт хүсье!
Ярилцсан: Р.Баярмагнай

ЦАГДААГИЙН ХЭСГИЙН БАЙЦААГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГА

*Б.Баянмөнх
ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн
Цагдаагийн эрх зүйн тэнхимийн ахлах багш,
докторант, цагдаагийн ахмад*



Анх 1975 онд хэсгийн байцаагч хэмээх албан тушаалыг бий болгосон үеэс өнөөг хүртэл хэсгийн байцаагчид нь хариуцсан нутаг дэвсгэртээ гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах ажлыг хэрэгжүүлж, оршин суугчид, иргэдийн амгалан тайван байдлыг хангаж, амьдрах таатай орчныг бүрдүүлэх үүргийн хэрэгжүүлсээр иржээ.

Цагдаагийн байгууллагын зорилт, чиг үүргийн хэрэгжилт нь газар, хэлтэс, тасгийн бие бүрэлдэхүүний хамтын үйл ажиллагаагаар тодорхойлогддог бол тодорхой нутаг дэвсгэрийн нэгжийг хариуцан ажиллаж, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах ажлыг өдөр тутам ард иргэдийн дунд зохион байгуулж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг ард иргэдтэй холбож өгч байдгаараа хэсгийн байцаагчийн ажлын үр дүн тодорхойлогддог.

Цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх, гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулахад Монгол Улсын засаг захиргааны хамгийн бага нэгж хариуцсан цагдаагийн алба хаагч буюу хэсгийн байцаагч /төлөөлөгч/ онцгой чухал үүрэгтэй оролцдог.

Өнөөдөр цагдаагийн байгууллага 2013 онд шинэчлэгдэн батлагдсан "Цагдаагийн албаны тухай хууль"⁶¹-иар гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд хэсгийн байцаагчийн гүйцэтгэх үүргийг шинэчлэн нарийвчлан тодорхойлох, ажлын удирдлага, зохион байгуулалтын оновчтой арга, хэлбэрийг эрэлхийлэх, өнөөгийн ажлын арга барилд дүн шинжилгээ хийж, сайжруулах арга замыг судлан тодорхойлох шаардлага бий болсон байна.

Гэтэл өнөөдөр хэсгийн байцаагч гэсэн албан тушаалтаны нэршлийг хэв журмын ажилтан хэмээн нэрлэсэн ч тэдний ажил үүргийн хуваарь, хийж гүйцэтгэх ажил нь төдийлөн өөрчлөгдөөгүй хэвээрээ байна.

Нэршил өөрчлөгдсөн ч тэдний гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам сахиулах ажлын арга барил шинэчлэгдэхгүй, удирдлага, зохион байгуулалтын оновчгүй хэлбэрт баригдан алдаа дутагдал гарч, ажлын үр нөлөө төдийлөн дээшлэхгүй байна.

Цагдаагийн хэсгийн байцаагч нь цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах үйл ажиллагаанд онцгой байр суурь эзэлдэг бөгөөд хүн ам,

⁶¹ Төрийн мэдээлэл. 2013. №29

олон түмэнтэй хамгийн ойр дөт байж, дүүрэг, баг, хороо зэрэг засаг захиргааны нэгж, тодорхой объект хариуцан ажилладаг онцлогтой албан тушаал юм.

Тэд гэмт хэрэг илрүүлэх, хэрэг бүртгэлт хийх, хүний өргөдөл гомдлыг цаг тухайд нь шийдвэрлэх, эрх зүйн зөрчилтөй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулж цагдаагийн бусад албан тушаалтнуудтай харьцуулбал хууль хамгаалах бүх хүрээг хамарч цагдаагийн байгууллагыг төлөөлөн ажилладаг өргөн эрх хэмжээтэй нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын үндсэн нэгж мөн.

Хэсгийн байцаагч нь хариуцсан нутаг дэвсгэртээ цагдаагийн өвөрмөц олон талын үйл ажиллагааг бие даан явуулахдаа төвөөсөө алслагдмал, холбоо мэдээллээр дутмаг, хүч хэрэгслийн хувьд дутагдалтай, ажлын хүнд нөхцөлд үүрэг гүйцэтгэдэг.

Хэсгийн байцаагч нь хариуцсан нутаг дэвсгэртээ гэмт хэрэг, захиргааны зөрчилтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах ажлыг бие даан зохион байгуулагч гол хүч юм.

Хамгийн энгийн жишээ хэлэхэд хэсгийн байцаагч нь хариуцсан хэсгийнхээ нутаг дэвсгэрийн хэмжээ, хил зааг, гудамж талбай, цэцэрлэг, цэнгэлдэх хүрээлэн, үзвэр үйлчилгээний болон олон нийтийн бусад газар, гэр байшин, хашааны эзэмшигч, орох, гарах үүд хаалга, албан газар, байгууллага, дэлгүүр, ресторан, банкны салбар, касс, үнэт материалын агуулахын байрлал, тэдгээрийн ажиллах цаг, хамгаалалтын байдал, түүнчлэн төр, захиргаа, олон нийтийн байгууллагын хаяг, харилцаа, холбоо барих арга, гудамж замын нэвтрэх хэсэг, нийтийн тээврийн зорчих хэсэг, зогсоол буудал, тээврийн хэрэгсэл, явган зорчигчдын нягтрал зэргийг урьдчилан судалж нарийн мэдсэн байвал зохино.⁶²

Мөн хэсгийн байцаагч /хэв журмын ажилтан/ нарын ажлын ачаалал нийслэл болон хөдөө орон нутагт маш их ялгаатай байгаа нь судалгаанаас харагдаж байна. Тухайлбал нийслэлийн хамгийн их ачаалалтай, хэв журмын нөхцөл байдал хүнд БЗД-ийн 14-р хорооны хэсгийн байцаагч 2012 онд нийт 132 өргөдөл гомдол хүлээн авч шалгаж шийдвэрлэснээс захиргааны зөрчлийн шинжтэй өргөдөл 81-г, гэмт хэргийн шинжтэй 51 өргөдөл хүлээн авч арга хэмжээ авч 2 өргөдөлд эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж хуулийн хугацаанд нь прокурорын хяналтанд шилжүүлсэн, 41 өргөдөл эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзан, 5 эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгож 3 өргөдөл гомдлыг захиргааны бүртгэлд шилжүүлж арга хэмжээ авсан бол Сүхбаатар аймгийн цагдаагийн хэлтсийн нэг хэсгийн байцаагч иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас 50 өргөдөл, гомдол хүлээн авч шалгаснаас 35 өргөдөл, гомдолд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж, 1 өргөдлийг харъяалалын дагуу шилжүүлж, 14 өргөдөл, гомдолд эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж, прокурорт шилжүүлсэн байна.

Эндээс харахад нутаг дэвсгэрийн байршил, хүн амын нягтрал, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлаас хамааран харилцан адилгүй ачаалалтай ажилладаг нь харагдаж байна.

Гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн арга бол гэмт хэрэг, захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг чанартай зохион байгуулах явдал юм гэдгийг бид сайтар ухамсарлаж, энэ чиглэл рүү анхаарлаа хандуулах шаардлагатай болжээ.

Гэмт хэргийг гарсан хойно нь хөрөнгө мөнгө, хүч хэрэгсэл, цаг хугацаа зарцуулан байж түүнийг илрүүлэх, шийдвэрлэхдээ биш, харин гарахаас нь өмнө аль болох урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, эрх зүйн зөрчил гарч болох нөхцөл байдлуудыг арилгахад

⁶² Ж. Долгорсүрэн. Монгол Улсын цагдаагийн эрх зүй. УБ. 2004. 114 дэх тал

чиглэгдсэн арга хэмжээг иж бүрэн цогцолбороор нь явуулах нь өнөөгийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны шинэчлэлийн үндсэн тулгуур чиглэл нь байх болно.⁶³

Өнөөдөр цагдаагийн байгууллага үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлээ нарийвчлан шинэчлэн тодорхойлох, хууль сахиулах ажлынхаа арга барил, хэлбэр, удирдлага, зохион байгуулалтаа нийгмийн бодлого, өөрчлөлттэй уялдуулан шинэлэг, үр дүнтэй арга механизмаар солих шаардлага тулгарч байгаа бөгөөд үүнийг хийх шинэ арга барилыг эрэлхийлсээр л байна.

Гэхдээ аливаа зүйлийн өөрчлөлт, шинэчлэлтийг хийхдээ өөрчлөлт хийх гэж байгаа зүйлийнхээ өнөөгийн төлөв байдал, чиг хандлага, эрх зүйн орчинд нарийвчилсан судалгааг сайтар хийхийн зэрэгцээ гадаад орнуудын ижил төстэй хэлбэрээр явуулдаг байгууллагын үйл ажиллагааны талаар харьцуулсан судалгаа хийж, тэндээс гаргаж ирсэн дэвшилтэд арга туршлагыг өөрийн хөрсөнд буулгах арга замаар шинэчлэлийг хийх нь чухал юм.

Цагдаагийн хэсгийн байцаагчийн ажлын амжилтанд хүрэх нөхцөл нь хариуцсан хэсгийнхээ өөрчлөгдөж буй нөхцөл байдлаа өдөр тутам мэдэж үнэлэх, ажлаа ухаалгаар төлөвлөх замаар албаны цагаа ашигтай зарцуулах, үйл ажиллагаандаа илүү тохиромжтой тактикийн арга барилыг сонгож хэрэглэх, нийтийн хэв журам хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх ажлын туршлага, шинжлэх ухаан, техникийн ололтыг өргөнөөр нэвтрүүлэх, хамтран ажиллах зүй зохистой орчныг бүрдүүлэхэд оршино.⁶⁴

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны үндсэн тэргүүлэх чиглэл нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил байх бөгөөд энэ чиг үүргийг хэрэгжүүлэхэд цагдаагийн анхан шатны нэгж болсон хэсэг, тэр дундаа хэсгийн байцаагч онцгой чухал үүрэг гүйцэтгэх болно гэдгийг анхааралдаа авах нь зүйтэй.

Хэсгийн байцаагч бүр хариуцсан хороо, нутаг дэвсгэртээ гэмт хэрэг, захиргааны зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хэв журам сахиулах чиглэлээр хийж буй ажил нь бодит байдал дээр удирдлага, зохион байгуулалт муутай, нэг хэвийн байдлаар явагддаг учраас өнөөгийн нийгэм тэднээс шинэлэг олон санаа сэдэж, олон зүйл хийж ажиллахыг шаардаж буйг үндэслэн, практик үйл ажиллагааны ололт, дутагдалд дүн шинжилгээ хийж, тавьсан зорилтыг ханган биелүүлж, ирээдүй хэтийн зорилгодоо хүрэх зарим арга замыг судлан тодорхойлоход дэмжлэг үзүүлэх нь чухал байна.

Бид өнөөдөр нийгмийн өөрчлөлтийг соргоогоор мэдэрч, цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийг нийгмийн хөгжлийн зүй тогтолтой уялдуулан байнга шинэчилж байх, түүнийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын оновчтой арга, тактикийг боловсронгуй болгох арга замыг бий болгоход анхаарлаа хандуулах шаардлага бий болж байна.

Тийм боловч эхний ээлжинд нутаг дэвсгэрийн анхан шатны нэгжийг хариуцан ажиллаж байгаа цагдаагийн хэсгийн байцаагчийн ажлын байрны тодорхойлолтыг нарийвчлан тодорхой болгох, удирдлага, зохион байгуулалтын шинэлэг хэлбэрийг бий болгож чадвал гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөө тодорхой хэмжээгээр дээшлэх юм.

Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх үндсэн нөхцөл нь цагдаагийн хэсгийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтын зөв оновчтой арга, хэлбэрээр зохион байгуулж, хэрэгжилтэнд нь хяналт тавих явдал юм.

⁶³ Цагдаагийн алба хаагчийн ёс зүй, үйл ажиллагааны орчин, түүний шинэтгэл. УБ. 2013.142 дэх тал

⁶⁴ Ж. Долгорсүрэн. Монгол Улсын цагдаагийн эрх зүй. УБ. 2004. 112 дахь тал

Хэсгийн байцаагч нь Монгол улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай хууль⁶⁵, Эрүүгийн байцаан шийтгэх хууль⁶⁶, Эрүүгийн хууль⁶⁷, Захиргааны хариуцлагын тухай хууль⁶⁸, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль⁶⁹, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль⁷⁰, Галт зэвсгийн тухай хууль⁷¹, Тамхины хяналтын тухай хууль⁷², Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль⁷³, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль⁷⁴, Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль⁷⁵ зэрэг 12 гол хууль, бусад эрхийн акт, түүнчлэн нутгийн өөрийн удирдах байгууллага, Засаг даргаас тогтоосон нийтээр дагаж мөрдөх журмын хэрэгжилтэнд хяналт тавьж, зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх үүргийг гүйцэтгэж байна.

Үүний зэрэгцээ ЦЕГ-ын даргын 2010 онд батлан мөрдүүлж буй “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”, “Цагдаагийн байгууллагын үйлчилгээний стандарт”-ыг баримтлан, “Хэсгийн байцаагчийн ажлын заавар”-ын дагуу үйл ажиллагаа нь зохицуулагдаж байна.

Дээрхи хууль тогтоомжууд, эрх зүйн актуудыг хэрэгжүүлж ажиллахдаа Монгол улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, хуулийн хүрээнд ажил үйлчилгээгээ явуулж байгаа боловч хэсгийн байцаагчийн ажлын ачааллыг хөнгөвчлөх, хэсгийн байцаагчийн ажлын зааварт заасан “энгийн ажлын өдрийн үргэлжлэх хугацаа 8 цаг байна, хэрэв ажлын цагийг шаардлагатай тохиолдолд сунгаж ажилласан бол дараагийн боломжтой өдөр нөхөн амраах, бямба, ням гаригт амрах ба амралтын өдөр ажилласан бол мөн дараагийн боломжтой гаригт амраана” гэсэн заалт хөдөө орон нутагт ч тэр, нийслэлийн хэмжээнд ч тэр хэрэгждэггүй байна.

Мөн шаардлагатай тоног төхөөрөмж, тусгай хэрэгслээр хангагдах, ажиллах нөхцөл бололцоог сайжруулах асуудал хангалтгүй байдаг.

Цагдаагийн байгууллагын тухайн үеийн удирдлага гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлын бүтээмжийг дээшлүүлэх, цагдаагийн хэсгийн байцаагчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, зохион байгууллалтын бүтэц, орон тоог бий болгох зайлшгүй шаардлагатай байгааг харгалзан ЦЕГ-ын 2008.12.30-ны өдрийн 652 дугаар тушаалаар хэсгийн байцаагч нарын орон тоог дунджаар 4000 иргэнд 1 хэсгийн байцаагч байхаар тооцож, Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээ ихсэж, хүн амын хот рүү чиглэсэн их нүүдэл, түүнчлэн аж ахуйн нэгж ихээр байгуулагдаж байгаагаар холбогдуулан хүн ам, аж ахуйн нэгжийн нягтаршил ихтэй зарим хороодод 3, бусад хороодод 2, аймгийн төвүүдэд хүн ам, аж ахуйн төвлөрөл, гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалтай харгалзан зохион байгуулалтыг хийсэн байна.

Өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотын хэмжээнд 271, хөдөө, орон нутагт 121, нийт улсын хэмжээнд **393** хэсгийн байцаагч гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам

⁶⁵ Төрийн мэдээлэл. 2013. №29

⁶⁶ Төрийн мэдээлэл. 2002. №6

⁶⁷ Төрийн мэдээлэл. 2002. №5

⁶⁸ Төрийн мэдээлэл. 1992. № 4-5

⁶⁹ Төрийн мэдээлэл. 1998. №1

⁷⁰ 1998 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн УИХ-ын чуулганаар хэлэлцэн баталсан.

⁷¹ 2001 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн УИХ-ын чуулганаар хэлэлцэн баталсан

⁷² Төрийн мэдээлэл. 2005. №27

⁷³ 2000 оны 01-р сарын 20-ны өдрийн УИХ-ын чуулганаар хэлэлцэн баталсан.

⁷⁴ Төрийн мэдээлэл. 2004. №23

⁷⁵ Төрийн мэдээлэл. 1998. №3

сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил үүргээ гүйцэтгэж байна. Цагдаагийн нийт 7000 гаруй алба хаагчдын 5-6 хувийг л хэсгийн байцаагч эзэлж байна.⁷⁶

Хэсгийн байцаагч өөрийн хариуцсан нутаг дэвсгэрт гарсан тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тогтоож арилгахын тулд тухайн нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, тухайн нутаг дэвсгэрийн объект болон субъектын судалгаа, гэмт хэргийн өсөлт бууралт, гэмт хэрэг, зөрчил гарч буй цаг хугацаа зэргийг нарийн тогтоож, түүний эсрэг нарийн бодож төлөвлөсөн иж бүрэн арга хэмжээг боловсруулж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхитэй татан оролцуулснаар нэг талаар олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа сайжрах, нөгөө талаар энэ ажил **цагдаа иргэдийг хооронд нь ойртуулах гүүр** болох юм.

“Цагдаагийн албаны тухай хууль”⁷⁷ шинэчлэгдэн батлагдаж гарахаас өмнө Засгийн газар болон ЦЕГ-аас хэсгийн байцаагчийн үйл ажиллагаатай холбоотой тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж иржээ. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын 1992, 2000 оны “Цагдаагийн байгууллагын сум, хорооны хэсгийн төлөөлөгч, байцаагч нарыг албан ажлаа явуулахад нь шаардагдах ажлын байр, тээврийн хэрэгсэл, холбоогоор хангах, цахилгаан, дулааны зардлыг төсвөөс санхүүжүүлэх, хойшлуулшгүй ажилд хэрэглэх шатахууны лимит тогтоох, хариуцсан нутаг дэвсгэрт нь байр орон сууцаар хангах, сум хорооны цагдаагийн алба хаагчийн эхнэр, нөхрийг ажлын шаардлагаар цагдаагийн туслах ажилтнаар хуульд нийцүүлэн томилж, 50 хувиар цалинжуулах арга хэмжээг жил бүрийн төсөвд тусгаж хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нарт даалгасан 43, 94 тоот тогтоол, 1999 онд Цагдаагийн ерөнхий газраас хэсгийн байцаагч, төлөөлөгч нарын тогтвортой ажиллах нөхцлийг хангах, тэднээс үүргээ биелүүлэх боломж, баталгааг бүрэн хангах, тэдний үйл ажиллагааг иргэдэд ойртуулах, мэдлэг боловсролыг нь дээшлүүлэх зорилтын хүрээнд “Цагдаагийн байгууллагын хэсгийн төлөөлөгч болон цагдаа нарын тогтвортой үйл ажиллагааг хангах дэд хөтөлбөр”-ийг 5 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр баталж ажиллаж байжээ.

Мөн гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах, урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулахад хэсгийн байцаагчийн үүрэг хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор 2003 оны Цагдаагийн Ерөнхий Газрын даргын 229 тоот тушаалаар “Хэсгийн байцаагчийн ажлын заавар”-ыг баталж, Цагдаагийн байгууллагын хэсгийн байцаагчийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах эрх зүйн боломж бүрдсэн байна.

Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг гардан хэрэгжүүлэх үндсэн нэгж болох цагдаагийн хэсгийн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын **оновчтой хэлбэрийг бий болгох, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохоос эхлэх шаардлагатай гэж үзэж** байна.

Хэсгийн байцаагч өөрийн хариуцдаг нутаг дэвсгэрт байнга оршин суудаг иргэдтэйгээ ойр дөт байж, тэдэнд тус нэмэр болохоос гадна тэдэнд үйлчилж, үйлчилсэнийхээ хэрээр ард иргэдээсээ итгэл хүлээж, тэднээр туслалцуулж, хамтран ажиллах нь чухал асуудал болоод байна. Хариуцсан нутаг дэвсгэрийнхээ иргэдийн итгэлийг хүлээж чадсан хэсгийн байцаагч нь ард иргэдээсээ байнгын мэдээллээр хангагдахын зэрэгцээ нутаг орноо сайн мэдэрснээр ажил үйлчилгээ явуулах таатай орчныг бүрдүүлж чадна.

Өнөөдөр хэсгийн байцаагч засаг захиргааны тодорхой нэгж хариуцан хэв журам сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа

⁷⁶ Цагдаагийн алба хаагчийн ёс зүй, үйл ажиллагааны орчин, түүний шинэтгэл. УБ. 2013. 146 дахь тал

⁷⁷ Төрийн мэдээлэл. 2013. №29

боловч хөнгөн гэмт хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулах, захиргааны хяналтын олон талт үйл ажиллагааг биечлэн гүйцэтгэхээс гадна цаг үеийн болон өөр бусад ажилд оролцдогоос хариуцсан хорооныхоо нутаг дэвсгэр дээрээ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тасралтгүй явуулах иргэд, оршин суугчдын гүнд нь орж ажиллах, судалгаа бүртгэл хийх, объектын судалгаандаа баяжилт хийх, мэдээлэл цуглуулах боломж хязгаарлагдмал байна.

Хэсгийн байцаагчдын хариуцсан нутаг дэвсгэр дээрээ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн тодорхой арга хэмжээнүүдийг түлхүү зохион байгуулах, аж ахуйн нэгж, байгууллагуудад камер, дохиолол хамгаалалтын систем суурилуулах ажлыг зохион байгуулах, тэднийг байнгын харуул хамгаалалттай болгох, сонор сэрэмжийг нь дээшлүүлэх, заавар, зөвлөлгөө өгөх, хяналт шалгалт хийх ажил нь тогтмолжоогүйгээс гэмт хэрэг, зөрчлийн тоо буурахгүй байна.

Дээрхи бүхнээс үүдэн баг, хороо бүр дээр нэг хэсгийн байцаагч, нэг эрүүгийн төлөөлөгч, нэг цагдаа, нэг хэрэг бүртгэгчийг хамтад нь баг болгон ажиллуулах шаардлага байгаа юм.

Ингэж ажилласан тохиолдолд тухайн баг, хорооны өргөдөл гомдлыг хэрэг бүртгэгч нь шалгаж, хүн, мал, эд зүйл эрэн сурвалжлах ажлыг эрүүгийн төлөөлөгч нь гүйцэтгэж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг хамгаалах ажлыг хэсгийн байцаагч, цагдаа нар хариуцан ажиллах боломжтой болох ба үүний үр дүнд цагдаагийн байгууллага иргэддээ хүрч ажиллах, бусад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн илрүүлэлт, иргэдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэх үйл ажиллагаанд чанарын өөрчлөлт гарах, хуульд заасан хугацаанд шалгаж шийдвэрлэх ажиллагаа илүү дүнтэй ахицтай гэж үзэж байна.

Хэсгийн байцаагчийн ажил үүргийн хуваарь зарим талаараа тодорхой бус байгаагаас ойлгомжгүй, хариуцлагагүй байдал үүсдэг бөгөөд хэсгийн байцаагчийн үйл ажиллагаа, эрх зүйн орчинг судалж, бүлгийн ярилцлагын агуулга, байцаагч нараас гаргасан санал, бодол, хүсэлтийг нэгтгэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүргийг хэрэгжүүлэх гол үндсэн нэгж бол цагдаагийн хэсэг, түүнийг хэрэгжүүлэгч нь хэсгийн байцаагч нар байна гэдгийг ухамсарлаж, удирдлага, зохион байгуулалтын шинэлэг хэлбэрт шилжүүлэх, үйл ажиллагааг нь дэмжих;
2. Хэсгийн байцаагчийн ажил үүргийн хуваарийг нарийвчлан тодорхой болгох; *Тухайлбал хэсгийн байцаагчийн ажил үүрэгт үүргийн давхардал их байна. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, эрүүгийн алба маань тодорхой хэмжээний ажилтай эргээд үзүүлэх юмтай байхад хэсгийн байцаагч салбар болгон руу орж ажилладаг боловч эргээд ажил нь үнэлэгдэхгүй, үнэлэмж муутай, ажил үүргийг нарийн сайн зааглаж өгөхгүй бол маш олон салбарын ажил руу давхардаж орж байна.*
3. Хэсгийн байцаагч урьдчилан сэргийлэх үндсэн үүргээ хэрэгжүүлэх нөхцөл боломжоор хангаж өгөх; *Ажлын ихэнхи цагаа өргөдөл гомдол шалгах, хэрэг бүртгэх үйл ажиллагаанд зарцуулж байна.*
4. Хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны эрх зүйн орчинг сайжруулах шаардлага бий болсон; Тухайлбал "Хэсгийн байцаагчийн ажлын заавар"-ыг шинэчлэх шаардлага бий болсон байна. Заавар батлагдаж хэрэгжээд 10 гаран жил өнгөрсөн бөгөөд зарим заалт нь шаардлага хангахгүй болсон. Өөрөөр хэлбэл, хэсгийн байцаагчийн ажил үүргийн хуваариар сард харъяа хорооныхоо нэг сард 220-оос доошгүй айл өрхөөр орж санал хүсэлтийг авна гэж заасан боловч энэ нь практик дээр хэрэгжих ямар ч боломжгүй юм.

5. Хэсгийн байцаагч нарт олон шат дамжлагын дарга нараас өгч буй үүрэг, даалгаварын давхардлыг арилгах, нэгдсэн нэг удирдлагаар хангаж өгөх; Тухайлбал, газар, хэлтэс, тасаг, нутаг дэвсгэрийн тасгийн дарга гэх мэтчилэн маш олон шат дамжлагын дарга нь өөрсдийнхөө чиглэлээр олон үүрэг даалгавар өгдөг, тэр нь хоорондоо давхарддаг, маш олон судалгаа, ажил үүргийг нэхдэг байдал ажиглагдсан.

Судалгаанаас дүгнэхэд хэсгийн байцаагчийг нэг хороонд тогтвор суурьшилтай ажиллуулдаггүй, 1-3 жил тутамд өөрчлөн томилдогоос тухайн алба хаагчид хариуцсан хорооныхоо эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг бүрэн мэдэрч чаддаггүй, хийвэл зохих бүртгэл судалгааг эхлэлийн төдий хийж, дараагийн алба хаагчид шилжүүлдэг нь тэдний ажлын үр дүнд муугаар нөлөөлдөг нь ажиглагдаж байна.

Санал

- Хэсгийн байцаагчийн ажлын байрны тодорхойлолт, гүйцэтгэх үүргийг нарийвчлан тодорхой болгож, хэсгийн ахлах байцаагч гэсэн шинэ албан тушаалыг бий болгох;
- Хэсгийн ахлах байцаагчийн үндсэн чиг үүргээс хэрэг бүртгэлтийн ажлыг нь салгах, урьдчилан сэргийлэх, хэв журам сахиулах ажил үүрэг руу голлон чиглүүлэх;
- Цагдаагийн хэсгийн бүтцэд шинээр тухайн хороог хариуцсан эрүүгийн төлөөлөгч, мөрдөн байцаагч болон цагдааг оруулж, нэг баг болгон удирдлага, зохион байгуулалтаар хангах, түүний эрх зүйн орчинг бүрдүүлж өгөх зэрэг болно.

ЦАГДААГИЙН АЛБАН ХААГЧИЙН АГСАМЖ, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

*Ш.Чулуун
ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн
Цагдаагийн эрх зүйн тэнхимийн ахлах багш,
докторант, цагдаагийн хошууч*



Цагдаагийн байгууллага нь түүхэн хөгжлийнхөө явцад өөрийн хүнд бэрх зорилт, чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шаардлагатай тохиолдолд зэвсэг, тусгай хэрэгслийг хэрэглэн ирсэн бөгөөд тухайн цаг үеийнхээ нийгмийн нөхцөл байдалтай уялдан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, эрх зүйн актууд шинэчлэгдэн улам боловсронгуй болж ирсэн байна.

Үүнийгээ дагаад цагдаагийн байгууллага, алба хаагчаас зэвсэг, тусгай хэрэгслийг хэрэглэх эрх зүйн зохицуулалт, үндэслэл журам өөрчлөгдөн шинэчлэгдэж олон улсын жишигт нийцсэн зэвсэг, тусгай хэрэгслийг цагдаагийн байгууллага албандаа ашиглаж байна. Тухайлбал, 1992 онд Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдаж түүнд нийцүүлэн Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хууль⁷⁸ шинээр батлагдсан нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр болоод зогсохгүй эрх зүйн шинэчлэлтийн анхны жишээ болсон юм.

Энэ хууль нь орчин үеийн цагдаагийн байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн зарчим, зорилго, зорилт, үндсэн үүрэг, бүрэн эрх, үйл ажиллагааны эрх зүйн арга хэлбэрийг тодорхойлсон анхны төрөлжсөн хууль болсон бөгөөд цагдаагийн байгууллагын зэвсэг, тусгай хэрэгслийн талаар урьд өмнөх хууль тогтоомжуудад байгаагүй тусгай бүлэг, зүйлүүд тусгагдсан нь цагдаагийн байгууллага, алба хаагчаас зэвсэг, тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх талаархи анхны шинэлэг эрх зүйн акт болсон юм.

Тус хуулийн 5-р бүлэгт цагдаагийн байгууллага, алба хаагчийн зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх эрх, тусгай хэрэгслийн төрөл, хэрэглэх үндэслэл журам, ашиглах аргачлал, анхаарах болон хориглох тохиолдлуудыг тодорхой тусгаж өгсөн.

Академич С.Нарангэрэл “Агсамж гэж цэрэг, цагдаагийн албан хаагч бүрийн нэг бүрийн иж бүрэн хувцас, хэрэглэл, зэвсэглэл”-ийг хэлнэ⁷⁹ гэжээ.

Шинэчлэлийн Засгийн газраас хэрэгжүүлж байгаа хууль сахиулах салбарын эрх зүйн шинэчлэлийн ажлын хүрээнд “Цагдаагийн байгууллагын тухай хууль”-ийг шинэчлэн найруулж “Цагдаагийн албаны тухай хууль”-ийг УИХ-аас 2014 оны 07-р сарын 05-ны өдөр

⁷⁸Цагдаагийн байгууллагын тухай хууль 1993 оны 12-р сарын 02-нд батлагдсан 8 бүлэг, 53 зүйлтэй хууль юм. Энэ хууль 1994 оны 01-р сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдсөн.

⁷⁹ С.Нарангэрэл “Эрх зүйн толь бичиг” 2008 он

баталж, улмаар 2014 оны 01-р сарын 01-нээс эхлэн даган мөрдсөнөөр цагдаагийн байгууллага нь алба, үйл ажиллагаагаа тус хуулинд нийцүүлэн ажиллаж байна.

Тус хуулинд зааснаар цагдаагийн алба хаагч нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх албан үүргээ гүйцэтгэхдээ албаны тусгай хэрэгсэл буюу хуулийн нэр томъёогоор агсамжийг хэрэглэхээр заасан байна. Тодруулбал, Цагдаагийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлд: "Алба хаагч үүрэг гүйцэтгэх үедээ гав, бороохой, цахилгаан гүйдлээр цохигч, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч, холбооны хэрэгсэл, гар чийдэн, дүрс, дуу бичлэгийн хэрэгсэл зэрэг иж бүрдэл бүхий агсамжаар хангагдах бөгөөд хууль тогтоомжид заасны дагуу хэрэглэнэ."⁸⁰ гэжээ.

Мөн "Алба хаагч гүйцэтгэх үүрэг болон улирлын байдалд тохирсон дүрэмт хувцас, хутга, сум үл нэвтрэх болон гэрэлтүүлэгчтэй хантааз зэрэг хамгаалах хэрэгслээр хангагдсан байх бөгөөд гүйцэтгэх үүргийн онцлогоос хамаарч агсамжид багтах зүйлийг нэмж олгоно"⁸¹ гэсэн нь алба хаагч нь ямар ажиллагаанд оролцож байгаагаас хамаарч агсамжийг ялгамжтай байдлаар хэрэглэхийг тусгайлан заасан байна.

"Алба хаагч нь амралтын цагаар, эсхүл энгийн хувцастай үүрэг гүйцэтгэх тохиолдолд хамгаалах тусгай хэрэгсэл, цахилгаан гүйдлээр цохигч, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч биедээ авч явж, өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндийг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор хэрэглэж болно."⁸² гэж цагдаагийн албаны тухай хуульд шинээр хэсэг болгон оруулсан нь алба хаагчийн албан үүргээ биелүүлэх, өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндийг гэмт халдлагаас хамгаалахад чухал ач холбогдолтой заалт болсон байна.

Цагдаагийн алба хаагчийг албан үүргээ гүйцэтгэж явах үедээ эрсдэлд оруулах магадлалыг албаны тусгай хэрэгсэл буюу агсамж "байхгүй"-тэй адил байдаг нь эрсдлийг улам нэмэгдүүлэх шалтгаан болдог байна.

"Цагдаагийн байгууллагын **зэвсэг, техник, тусгай хэрэгсэл**, хувцас бусад хангамжийн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх"⁸³, мөн зүйлийн 20.1.9 дэх хэсэгт: "Цагдаагийн байгууллага, алба хаагч, ажилтны аюулгүй байдал, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах"⁸⁴ гэсэн нь цагдаагийн төв байгууллагын дарга нь алба хаагч, ажилтны аюулгүй байдлыг хангах үүргийг шинээр хуулинд тусгаж өгсөн нь шинэлэг болсон ба алба хаагчийн аюулгүй байдлыг хангах, эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалахад чухал ач холбогдолтой заалт болсон байна.

Мөн цагдаагийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйл "Цагдаагийн байгууллагын төсөв"-ийн 30.2 дах хэсэгт "Энэ хуулийн 30.1-д заасан шаардлагын хүрээнд цагдаагийн алба хаагчийн хүнс, эдийн хангалт, сургалтын байр, сургалт, бэлтгэл, холбоо, мэдээлэл технологийн үйл ажиллагаа, судалгаа шинжилгээ, **хамгаалах болон тусгай хэрэгсэл**, хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцас, техник хэрэгслийн зардлыг улсын төсөвт тусгаж санхүүжүүлнэ" гэсэн нь цагдаагийн байгууллагын болон алба хаагчийн хүнс, эдийн засгийн, хөдөлмөрийн, хувцас, техник хэрэгслийн аюулгүй байдлын хангахад чиглэсэн чухал ач холбогдолтой заалт болсон байна.

Өөрөөр хэлбэл зардлыг төсөвт суулгаж өгснөөр алба хаагчид хуулинд заасан агсамжаар цаг тухай бүр бүрэн хангагдаж ингэснээр албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндийг гэмт халдлагаас хамгаалах нөгөө талаас хуулинд

⁸⁰Төрийн мэдээлэл., 2013 оны ., №29/794/

⁸¹Төрийн мэдээлэл., 2013 оны ., №29/794/

⁸²Төрийн мэдээлэл., 2013 оны ., №29/794/

⁸³ Төрийн мэдээлэл., 2013 оны ., №29/794/

⁸⁴ Төрийн мэдээлэл., 2013 оны ., №29/794/

заасан үндэслэл журмын дагуу гэмт хэрэг болон зөрчил гаргасан этгээдийг хууль бус үйлдлийг таслан зогсоохдоо агсамжийг хэрэглэх нь үр дүнтэй, шуурхай арга хэмжээ болох юм.

Цагдаагийн албаны тухай хуулинд заасан агсамжийг цагдаагийн байгууллага, алба хаагч нь алба, үйл ажиллагаандаа хэрэглэхдээ 2014 оны 01-р сарын 16-ны өдөр УИХ-аас батлагдан гарсан "Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөж журмын тухай хууль"-ийн холбогдох заалтыг баримталж мөрдүүлэхээр тусгасан байна. Тухайлбал, Хууль сахиулагч албаны үүргээ гүйцэтгэх үедээ биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх харилцааг зохицуулах холбогдох хууль батлагдаж, хүчин төгөлдөр болох хүртэл хугацаанд цагдаагийн байгууллага, алба хаагч Цагдаагийн албаны тухай хуулийн 33.6 дахь хэсэгт заасан биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэхдээ энэ хуулийн 17-21 дүгээр зүйлд заасныг баримтална.⁸⁵ гэжээ.

Тус хуулийн заалтанд биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх үндэслэл журам, тусгай хэрэгслийн төрөл, тусгай хэрэгслийг хэрэглэх шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан, түүний үүрэг, анхаарах зүйл, бусад тусгай зориулалтын техник хэрэгсэлийг хэрхэн ашиглах талаар тусгасан байна.

Мөн тус хуулийн 2 дугаар зүйлд: Цагдаагийн албаны тухай хуулийн 19.5-д заасан жишиг стандарт, 20.1.3-т заасан эрх зүйн актыг баталж, мөрдүүлэх хүртэл хугацаанд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг дагаж мөрдөнө.⁸⁶ гэжээ.

Өөрөөр хэлбэл шинэчлэн батлагдсан "Цагдаагийн албаны тухай хууль"-ийн галт зэвсэг, тусгай хэрэгсэл, тусгай мэх хэрэглэх заалтын үзэл баримтлалд нийцүүлсэн эрх бүхий албан тушаалтны эрх зүйн акт батлагдан гартал ЦЕГ-ын дарга УЕП-той зөвшилцөн баталсан 2010.04.02-ны өдрийн 173-р тоот тушаалын 1-р хавсралтанд тусгагдсан ЦБҮАЖ-ын код-233-239-ыг баримталж ажиллахаар зохицуулалт хийгдсэн байна.

Дээр дурдсан ЦБҮАЖ-ын кодуудыг задалж төрөлжүүлэн ангилж тодорхойлбол дор дурдсан агуулгыг илэрхийлсэн байна. Үүнд:

- Галт зэвсэг, тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх заавар /код- 233/
- Галт зэвсэг хэрэглэх заавар /код- 234/
- Нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх заавар /код- 235/
- Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх заавар /код- 236/
- Тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл хэрэглэх заавар /код- 237/
- Зэвсэггүйгээр тулалдах мэх хэрэглэх заавар /код- 238/
- Албаны нохой хэрэглэх заавар /код -239/

Цагдаагийн байгууллагад ашиглах галт зэвсэг, тусгай хэрэгслийн жагсаалт, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх зааврыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн батална.⁸⁷ гэжээ.

Өөрөөр хэлбэл нь тус зааврыг батлах эрх бүхий албан тушаалтан өмнө ЦЕГ-ын дарга УЕП-той зөвшилцөн баталдаг байсан бол одоогийн хууль тогтоомжоор Хууль зүйн сайд Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн батлахаар шинэчлэн хуульчилсан байна. Цагдаагийн байгууллага, алба хаагч нь хуулинд заасан үндсэн чиг үүргээ биелүүлэхдээ шаардлагатай тохиолдолд хуулинд заасан үндэслэл журмын дагуу цагдаагийн төв байгууллагын даргын шийдвэрээр албан хэрэгцээнд хүлээн авч бүртгэсэн тусгай хэрэгслийг /агсамж/ хэрэглэж байна.

⁸⁵ Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль 2014 оны 01-р сарын 16

⁸⁶ Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль 2014 оны 01-р сарын 16

⁸⁷ Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 17-р зүйлийн 17.2 дахь хэсэг

Албанд хэрэглэж байгаа тусгай хэрэгслийг ОХУ, БНХАУ болон бусад гуравдагч орнуудын тусгай хэрэгсэл үйлдвэрлэдэг газраас захиалан хийлгүүлж улмаар төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэст хувиарлан олгож байна.

Эдгээр тусгай хэрэгслүүдийг Монголын нөхцөлд тохирох эсэх, чанар стандартыг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлж дүгнэлт гаргуулах, үүний тулд туршилт, судалгаа явуулах зайлшгүй шаардлагатай байна.

Энэхүү үндэслэл бүхий нөхцлийг шинэчлэн баталсан цагдаагийн албаны тухай хуулийн 5-р зүйлийн 5.5 хэсэгт: Цагдаагийн төв байгууллагын харъяанд судалгаа, сургалт дадлагын болон **албаны зэвсэг, тусгай хэрэгсэл, тусгай зориулалтын техник хэрэгслийн** чанар стандартыг судлан тогтоох лаборатори, энэ хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд туслах инженер техник, засвар үйлчилгээ, үйлдвэрлэл, санхүү, хангалт хариуцсан нэгж байж болно.⁸⁸ гэж хуульчлан тусгасан нь шинэлэг зүйл болсон бөгөөд энэхүү асуудлын эрх зүйн зохицуулалт болж өгснөөрөө онцлог ач холбогдолтой юм.

Тусгай хэрэгслийн үзүүлэлт, чанар, стандартыг эрх бүхий байгууллагаар гаргуулан баталж улмаар мөрдлөг болгон ажилласнаар албаны үйл ажиллагаанд эерэг үр дагаврыг бий болгох юм. Учир нь цагдаагийн алба хаагчийн хууль ёсны тавьсан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд хуулинд заасан үндэслэл журмын дагуу албанд ашиглаж байгаа тусгай хэрэгслийг гэмт хэрэг болон зөрчил гаргасан этгээдийн үйлдэл, үйл ажиллагаанаас хамаарч ялгамжтай байдлаар хэрэглэдэг.

Гэтэл тухайн этгээд эрх бүхий байгууллага болон дээд шатны захирах албан тушаалтанд цагдаагийн алба хаагчийн тусгай хэрэглэсэн талаар гомдол гаргаж шалгуулдаг. Алба хаагч нь хэдийгээр албанаас тавьж олгосон тусгай хэрэгслийг хэрэглэсэн боловч тухайн тусгай хэрэгслийн үзүүлэлт, чанар, стандартыг тодорхойлсон албан ёсны мэргэжлийн байгууллагын дүгнэлт байхгүйгээс улбаалж өөрөө буруутан болох эрсдэл өндөр байна.

Мөн цагдаагийн байгууллага нь гадаадын тусгай хэрэгслийн үйлдвэрээс өөрийн орны байгаль цаг уурын онцлог, эрүү болон хэв журмын нөхцөл байдалд тулгуурлан хууль тогтоомжинд заасан эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр албандаа зарим нэр төрлийн шинэ тусгай хэрэгслийг албаны зэвсэглэмжинд хүлээн авч бүртгэн хуулинд заасан үндэслэл журмын дагуу хэрэглэж байна.

Иймд цагдаагийн төв байгууллагаас шинээр оруулж ирсэн албанд хэрэглэдэг тусгай хэрэгслийн бүтэц зохион байгуулалт, онцлог, ажиллах зарчим, аюулгүй ажиллагааны талаархи сургалтыг тухай бүр төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн алба хаагчдад зохион байгуулж онолын зохих мэдлэг олгох, мөн тухайн тусгай хэрэгслийг хэрэглэх дадал чадварыг эзэмшүүлэх шаардлагатай байна.

Дээр дурдсан нөхцөл байдалд тулгуурлан дараах саналыг дэвшүүлж байна.

- Шинэчлэн баталсан “Цагдаагийн албаны тухай хууль”-ийн 8-р бүлгийн 33-р зүйлийн 33.6 дахь хэсэгт заасан биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх ажиллагаатай холбоотой эрх бүхий албан тушаалтны “Цагдаагийн байгууллагад ашиглах галт зэвсэг, тусгай хэрэгслийн жагсаалт, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх заавар”-ыг шинэчлэн батлан гаргаж албанд мөрдлөг болгон ашиглах
- Цагдаагийн төв байгууллагын харъяанд судалгаа, сургалт дадлагын болон албаны зэвсэг, тусгай хэрэгсэл, тусгай зориулалтын техник хэрэгслийн чанар стандартыг судлан тогтоох лабораторыг нэн даруй байгуулах

⁸⁸ Төрийн мэдээлэл., 2013 оны ., №29/794/

- Цагдаагийн байгууллагад ашиглаж байгаа тусгай хэрэгслийн үзүүлэлт, чанар, стандартыг тодорхойлсон албан ёсны мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулах
- Төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс нь галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүчийг хэрэглэхтэй холбогдуулан тусгайлсан сургалт дадлагын кабинетыг дотооддоо байгуулах. Ингэснээр алба хаагч нь энэ чиглэлээр онолын мэдлэгээ бататгах, галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх талаар мэргэжлийн ур чадвар сайжрах үндсэн нөхцөл бүрдэх юм.

ГАЛТ ЗЭВСГИЙН ТАЛААРХИ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

Д.Булган

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн
тэнхимийн багш, цагдаагийн ахмад



Иргэдийн хууль ёсны ашиг сонирхол, мөн цагдаагийн байгууллагын захиргааны хяналт, зөвшөөрлийн тогтолцоог сайжруулах үүднээс одоогийн практикийн зарим доголдолтой асуудлыг ил болгон, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр нөлөөг дээшлүүлэх шаардлага зүй ёсны тавигдаж байна.

Энэ асуудал нь зөвхөн Монгол Улсын төдийгүй, бусад орны анхаарал татсан сэдэв болж байгаа бөгөөд олон улсын хэмжээнд галт зэвсэг хяналтаа аль хэдийн алдаж, галт зэвсгийн улмаас жилд дунджаар хагас сая хүн, түүний дотор хүүхдүүд амиа алдаж, мянга мянган хүн эрэмдэг зэрэгмдэг болж, эрүү шүүлтэд тарчилж, гэр орноосоо хөөгдөж байна.

Иргэдийн галт зэвсэг ашиглах, эзэмших, өмчлөх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгосноор цагдаагийн байгууллагаас иргэдэд үзүүлэх бэрхшээл, хүнд суртлыг арилгаж, нөгөө талд галт зэвсгээр үйлдэгдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлж, гарсан гэмт хэргийг түүргэн шуурхай илэрүүлж, хүний эрхийг дээдлэн, хуулийг зөв хэрэгжүүлэх боломж бүрдэх юм.

Галт зэвсэг гэдгийг хэл зүйн үүднээс нь *"Галаар тэсрүүлэх зэвсэг; галт бөмбөг; галт буу"*⁸⁹ гэж эрдэмтэд тайлбарласан бол судлаач Б.Цэрэнбат "Цагдаагийн зэвсэг" гэж гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, харуул хамгаалалтын тодорхой үүрэг гүйцэтгэх үед шаардагдах цагдаагийн байгууллагаас олгогдсон, цагдаагийн алба хаагч биедээ авч явах эрх бүхий, Цагдаагийн байгууллагын тухай хуульд заасан тохиолдлуудад хэрэглэж болох галт болон бусад зэвсэг⁹⁰ гэжээ.

Мөн "Галт зэвсгийн тухай хууль"-д дараах нэр томъёог дор дурдсан утгаар тодорхойлжээ. Үүнд:

"Галт зэвсэг" гэж гол төмөр доторх дарьны шаталтын хийн даралтаар хурд авдаг сумны хошуу буюу үрлээр амьд болон бусад биетийг гэмтээх буюу хөнөөх чадвар бүхий буудлагын зэвсгийг;⁹¹

"Байлдааны зориулалттай галт зэвсэг" гэж зэвсэгт хүчин, бусад цэрэг, цагдаа, тагнуул, хорих байгууллага хуулиар олгогдсон чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор ашиглаж, хэрэглэж байгаа галт зэвсгийг;

"Гар буу" гэж 100 метр хүртэлх зайд хөнөөх чадалтай, 20 сантиметр хүртэлх урт гол төмөртэй галт зэвсгийг" хэлжээ.

⁸⁹Цэвэл.Я., Монгол хэлний товч тайлбар толь., УБ хот., 1966., 135 дахь тал

⁹⁰ Цэрэнбат.Б, "Цагдаагийн зэвсэг, тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх тактик" 2006, УБ хот, 8 дахь тал

⁹¹ Галт зэвсгийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ www.legalinfo.mn

“Сум” гэж хонгио, бялт, дарин цэнэг, хошууг нэг цогц болгож буудахад зориулагдсан хийцийг гэсэн байна.

Дээрхи тодорхойлолтуудаас авч үзвэл “галт зэвсэг” нь хүний амь насанд аюултай буюу аминд хүрэх аюултай зүйл гэж ерөнхийд нь ойлгож болох бөгөөд галт зэвсэг нь онцгой төрлийн өмч болох нь харагдаж байна. Тиймээс ч галт зэвсгийг ашиглах, өмчлөх, эзэмших эрхийн талаархи зохицуулалтыг нарийвчлан судалж, иргэний эрх зүй дэхь эд хөрөнгийг өмчлөх, эзэмших, ашиглах тухай ойлголттой харьцуулан авч үзэн, эрх зүйн зохицуулалтанд анхаарах нь зүйтэй юм.

Нэг. Иргэдээс галт зэвсэг ашиглах, эзэмших, өмчлөх эрхийн талаарх эрх зүйн зохицуулалт. Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйл: “1. Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ” гээд 16.3-т “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө;” гэж заажээ.

Хууль зүйн ухааны доктор Т.Мөнхжаргалын тодорхойлсноор өмчлөгч бүр өмчтэй болох үндсэн зарчим адил ойлгогдох боловч олж авах аргын хувьд зарим ялгаа бий. Өмчлөх эрх нь эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах үйл ажиллагаагаар хэрэгжиж байдаг.

Хууль буюу гэрээний үндсэнд эд хөрөнгө, эрхийг мэдэлдээ авч тогтоосон журмын дагуу харж хамгаалах, ашиглах түүнтэй холбоотой эрх, үүргийг хэрэгжүүлж буй субъект /иргэн, хуулийн этгээд/-ийн үйл ажиллагааг эзэмших эрх гэнэ.

“Галт зэвсгийн тухай хууль”-ийн 9 дүгээр зүйлд “Харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд нь 18 нас хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай, Монгол Улсын иргэн цагдаагийн байгууллагаас олгосон зөвшөөрлийн үндсэн дээр галт зэвсэг өмчлөх эрхтэй гэсэн шаардлагыг хангасан харуул хамгаалалтын ажилтанд гэрээний үндсэн дээр зөвхөн албаны үүрэг гүйцэтгэх хугацаанд нь галт зэвсэг эзэмшүүлж болно” гэж заажээ. Харин энэхүү галт зэвсэг эзэмшүүлэх гэрээг сум, дүүргийн цагдаагийн байгууллагад бүртгүүлнэ.

Ашиглах эрх гэдэг нь эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг хууль буюу гэрээнд заасан нөхцөл болзлын дагуу үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж буй субьектийн үйл ажиллагааг хэлнэ. Галт зэвсгийн ашиглах эрхийн заалт нь “Галт зэвсгийн тухай хууль”-ийн 10 дугаар зүйлд заасан бөгөөд “галт зэвсгийг ан агнуурын зориулалтаар хот, суурин газраас бусад газарт ашиглах бөгөөд нутгийн захиргааны байгууллагын шийдвэрээр золбин нохой, муур зэрэг амьтныг хот, суурин газарт галт зэвсэг ашиглан устгаж болно гэжээ.

Өмчлөгчийн үзэмж зориг санааны дагуу эд хөрөнгийн эдийн засаг, хууль зүйн хувь заяаг шийдвэрлэх үйл ажиллагааг захиран зарцуулах эрх гэнэ.

“Иргэний хууль”-д өмчлөх эрх гэдэг⁹² нь өмчлөгч нь бусад этгээдэд хууль буюу гэрээгээр олгогдсон эрхийг зөрчихгүйгээр, хуулиар тогтоосон хэмжээ, хязгаарын дотор өмчлөлийн зүйлээ өөрийн үзэмжээр чөлөөтэй эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах бөгөөд аливаа халдлагаас хамгаалах эрхтэй.

Аливаа этгээд нь хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлаагүй эдийн баялаг болох эд юмс болон эдийн бус баялаг болох оюуны үнэт зүйлсийн эрхийг олж авах бөгөөд энэ тохиолдолд дээрх баялаг нь хөрөнгө болно гэж өмчтэй болох үндсэн асуудлыг хуульчилсан билээ .

⁹² “Монгол Улсын иргэний хууль” 101 дүгээр зүйл. www.legalinfo.mn

Өмчийг эрх зүйн зохицуулалтын аргаар нь дараахь байдлаар ангилна:

1. Зөвшмөл /ихэвчлэн/

2. Захирамжилсан /зарим тохиолдолд эд хөрөнгө хураах, дайчлах/ арга байна.

Галт зэвсэг эзэмших, ашиглах, өмчлөхөд зохицуулалтын дээрх хоёр арга аль аль нь хэрэгжих боломжтой юм. Тухайлбал "галт зэвсгийн тухай хууль"-ийн 5 дугаар зүйлийн 1. "...18 нас хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай, Монгол Улсын иргэн цагдаагийн байгууллагаас олгосон зөвшөөрлийн үндсэн дээр галт зэвсэг өмчлөх эрхтэй гэж заасан. Мөн эрүүгийн хуульд заасан хүнд, онц хүнд гэмт хэрэгт, эсхүл галт зэвсэг ашиглаж үйлдсэн гэмт хэрэгт ял шийтгэгдэж, ял шийтгэлгүйд тооцогдоогүй байгаа болон архаг архичин, мансуурах донтой гэж тооцогдсон этгээд галт зэвсэг өмчлөх, эзэмших, ашиглах нь тогтоогдвол түүнийг хурааж авахаар⁹³ зааж өгсөн байдаг.

Галт зэвсэг өмчлөх эрх нь дараахь тохиолдолд үүснэ.⁹⁴

- ✓ Монгол Улсын 18 насанд хүрсэн эрх зүйн бүрэн чадамжтай, иргэн цагдаагийн байгууллагын зөвшөөрлийн үндсэн дээр галт зэвсэг өмчлөх эрхтэй.
- ✓ Харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн зохих шаардлага хангасан харуул хамгаалалтын ажилтанд гэрээний үндсэн дээр зөвхөн албаны үүрэг гүйцтгэх хугацаанд нь галт зэвсэг эзэмшүүлж болно. Галт зэвсэг эзэмшүүлэх гэрээг сум дүүргийн цагдаагийн байгууллагад бүртгүүлнэ.

Зарим иргэдийн галт зэвсэг ашиглах, эзэмших, өмчлөх эрхийг дараахь тохиолдолд хориглоно.

- ✓ Эрүүгийн хуульд заасан хүнд, онц хүнд гэмт хэрэгт, эсхүл галт зэвсэг ашиглаж үйлдсэн гэмт хэрэгт ял шийтгэгдэж, ял шийтгэлгүйд тооцогдоогүй байгаа болон архаг архичин, мансууруулах донтой гэж тооцогдсон этгээд галт зэвсэг өмчлөх, эзэмших, ашиглах эрхгүй.
- ✓ Хуульд өөрөөр заагаагүй бол иргэн, хуулийн этгээд байлдааны зориулалттай галт зэвсэг өмчлөхийг хориглоно.
- ✓ Хуульд өөрөөр заагаагүй бол дипломат болон олон улсын байгууллагад ажиллаж байгаагаас бусад гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэрт галт зэвсэг өмчлөхийг хориглоно.
- ✓ галт зэвсгийн хэв загварыг өөрчлөх, үйлдвэрийн бус аргаар хийж бэлтгэх, ийм галт зэвсэг өмчлөх, эзэмших, ашиглахыг хориглоно.

Өмчийн эрх дараахь тохиолдолд дуусгавар болно.

1. Иргэний хуульд "үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх хэлцлийн үндсэн дээр нэг этгээдээс нөгөөд шилжилж байгаа бол уг хэлцлийг үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн газар бүртгүүлснээр өмчлөх эрх шинэ өмчлөгчид үүсэж өмнөх өмчлөгчийн өмчлөх эрх дуусгавар болдог.

Тэгвэл "Галт зэвсгийн тухай хууль"-ийн 14 дүгээр зүйлийн 1.т"...Иргэн, хуулийн этгээд өөрийн өмчлөлд байгаа галт зэвсэг худалдах бол энэ тухайгаа галт зэвсгийн гэрчилгээ олгосон цагдаагийн байгууллагад мэдэгдэж, гэрчилгээгээ хураалгаж, бүртгэлээс хасуулна. Галт зэвсгийг бүртгэлээс хассан цагдаагийн байгууллага худалдан авагчийн оршин суугаа сум, дүүргийн цагдаагийн байгууллагад энэ тухай мэдэгдэнэ".

2. Өмч хувьчлалын дагуу төрийн өмчийн эрх дуусгавар болж болно.

3. Иргэний хуулиар өмчлөлгүй буюу эзэнгүй эд хөрөнгийн өмчлөх эрх дуусгавар болдог. Жишээ нь: Эзэнгүй үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгийг хуулиар хориглоогүй аргаар

⁹³ "Галт зэвсгийн тухай хууль" 19 зүйл. www.legalinfo.mn

⁹⁴ "Галт зэвсгийн тухай хууль" 5 дугаар зүйл, 2001 он,

олж авсан, эсхүл тухайн эд юмсыг олж авахдаа эрх бүхий этгээдийн эрхийг зөрчөөгүй бол хуульд заасан хугацаа /хөдлөх эд хөрөнгийг 1-5 жил, үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөгчөөр бүртүүлснээс хойш 15 жил/ өнгөрсөн бол өмнөх өмчлөгчийн эрх дуусгавар болно. Гэхдээ гол нь энэ хугацаа дундаа тасрахгүй байх ёстой.

Зарим тохиолдолд өмчлөгчийн өмчийн эрх дуусгавар болж байхад нөгөө этгээдэд заавал өмчийн эрх үүсэхгүй байж болдог. Энэ нь "Галт зэвсгийн тухай хууль"-ийн 19.4-т Хураагдсан галт зэвсгийг устгах, худалдах, шилжүүлэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Энд зааснаар галт зэвсгийг хураан авч устгах тухай шийдвэр гарснаар тухайн этгээдийн өмлөх эрх дуусгавар болж харин нөгөө этгээдэд өмчлөх эрх үүсэхгүй байна.

Иргэн галт зэвсгийг эзэмших, ашиглах, өмчлөх эрх бусад өмчийг ашиглахтай нэгэн адил хэрэгжиж болох авч, галт зэвсэг өөрөө онцгой объект учир галт зэвсгийг эзэмших, ашиглах, өмчлөх нь өөрөө заавал онцгой журмаар зохицуулагдах шаардлагатай юм.

Галт зэвсгийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон хуулийн дэд актууд бий. Тухайлбал: "Галт зэвсэг нийтэд худалдах төвийг сонгон шалгаруулах журам"⁹⁵, "Галт зэвсгийг улсын хилээр оруулахад зөвшөөрөл олгох, гаалийн шалгалт хийх журам"⁹⁶, "Галт зэвсгийг ашиглахад харшлах өвчин, бие эрхтэний байдлын тухай жагсаалт"⁹⁷, "Хураагдсан галт зэвсгийг устгах, хадгалах, шилжүүлэх журам"⁹⁸, "Галт зэвсгийг бүртгэх, гэрчилгээ олгох журам"⁹⁹ гэх мэт журмуудыг удирдлга болгоно.

Хоёр. Цагдаагийн байгууллагаас галт зэвсэг ашиглах, эзэмших, өмчлөх зөвшөөрөл олгож, хяналт тавих талаархи практик хэрэгжилт. Цагдаагийн байгууллагаас галт зэвсэг ашиглах, эзэмших, өмчлөх эрхийн зөвшөөрөл олгох, хяналт тавих үйл ажиллагаа нь нийтийн хэв журмыг бэхжүүлэх, эрх зүйн зөрчилтэй тэмцэх үндсэн аргын нэг бөгөөд түүний үр нөлөөг дээшлүүлснээр нийгэмд галт зэвсгээс учирч болох хор хөнөөлийг багасгах боломжтой.

Галт зэвсгийг Монгол Улсын иргэн ан агнуур, спорт-сургалт, харуул хамгаалалт, цуглуулга, урлагын тоглолтын гэсэн зориулалтаар өмчлөх, эзэмших, ашиглахыг тодорхойлон хуульчилсанаас өөр зориулалтаар төрөл, ангилалыг нь тогтоогоогүй байгаагаас манай улсад байгаа байлдааны зэвсэг, түүний сум, галт хэрэгслийг зориулалтаас бусад чиглэлээр ашиглах, галт зэвсэг эзэмших, эрх бүхий хуулийн этгээд нь гарцаагүй нөхцөлд зэвсэг хэрэглэсэн тохиолдолд гэм буруутан болох, тусгайлсан сургалтанд хамрагдаагүйн улмаас осол аваарь гаргах, үйлдвэрийн бус аргаар хэлбэр загвар хүчин чадлыг нь өөрчлөх, галт зэвсгийг нууж дарагдуулах, хулгайн байдлаар эзэмших зэрэг хууль бус үйл ажиллагааны эх үүсвэрийг бий болгож байна.

Гадаадын зарим оронд галт зэвсэг ашиглах эзэмших зөвшөөрөл олгох талаархи туршлагаас судалж өөрийн оронд нэвтрүүлэх нь зүйтэй юм. Тухайлбал, Австралд галт зэвсгийн зөвшөөрлийг олгохдоо дараах категориудад хуваадаг¹⁰⁰.

Категори А: Винтов (хагас автомат бус) пулемат олон бусад винтов. Бодит шаардлага энэ төрлийн зөвшөөрөл авахад хэрэгтэй.

⁹⁵ХЗДХ сайдын 2002 оны 157-р тушаал

⁹⁶ЦЕГ, ГЕГ-ын даргын хамтарсан 2002 оны 34\36-р тушаал

⁹⁷ХЗДХ сайд, Эрүүл мэндийн сайдын 2003 оны 11\12-р тушаал

⁹⁸ХЗДХ сайдын 2002 оны 186-р тушаал

⁹⁹ЦБҮАЖ-ын код 602, 503 дугаар тушаал

¹⁰⁰ [http://en.m.wikipedia.org/wiki/Gun_\(Firearm\)](http://en.m.wikipedia.org/wiki/Gun_(Firearm))

Категори В: Урдуураа сумлагддаг буунууд. 1901 оноос үйлдвэрлэгдсэн. Мөн бодит шаардлагаа тайлбарлах ёстой. Яагаад А бүлгийн буу тохиромжгүй вэ гэсэн тайлбарын хамт.

Категори С: Хагас автомат винтовууд, 10 болон түүнээс дээш сумтай, пулемат 5 болон түүнээс дээш үетэй. Энэ категори тун чанга хатуу хориотой бөгөөд зөвхөн цуглуулагчдад болон мэргэжлийн мэргэн буучдад өгдөг зөвшөөрөл юм.

Категори D: Категори С тэй ижил. Дээр нь улсын байгууллагуудад энэ төрлийн зэвсэг эзэмших зөвшөөрлийг олгодог.

Категори Н: Гар буунууд. Дохионы буунуудын зөвшөөрөл. Австралид ийнхүү буу эзэмшихэд хориг тавьснаар гэмт хэрэг буурсан байна. 1991 – 2001 оны хооронд галт зэвсгээр үйлдсэн хүн амины хэрэг 47 % буурчээ. Амиа хорлолт мөн буурсан үзүүлэлттэй гарсан байна.

Мөн Герман улсад¹⁰¹ зэвсгийн лиценз 3 өнгийн кодтой олгодог. Үүнд: **ногоон** өнгийн лиценз: тэмцээний зориулалттай буу зэвсэг. **Шар лиценз:** том жижиг пулемат. Үүнд тэмцээний бус зориулалттай. **Улаан лиценз:** мэргэжлийн болоод цуглуулагчдад олгодог лиценз ажээ.

Сонин жишээ болгон дурьдвал галт зэвсэг авч явах зөвшөөрөлийг олон нийтийн дунд шаардлагатай хүмүүст зөвшөөрдөг. Энэ нь нэр хүндтэй хүмүүс биеэ хамгаалах зориулалттай байж болон бөгөөд 3 жилийн хүчинтэй олгогддог.

Жижиг галт зэвсэг авч явах зөвшөөрөл энэ төрлийн зөвшөөрөл хүсэгч заавал мэргэжлийн хүн, эсвэл зайлшгүй хэрэгцээтэй, тусгай мандаттай байх шаардлагагүй. Зөвхөн насанд хүрсэн, итгэл даахуйц болон бусад энгийн шаардлагыг хангасан байдаг.

Үүнтэй адил Монгол Улсад галт зэвсэг эзэмших, ашиглах, өмчлөх эрхийн зохицуулалтыг өөрийн орны онцлогт тохируулан зөвшөөрөл олгох ажиллагааг сайжруулж болох юм.

Цагдаагийн байгууллагын статистик тоо баримтыг сүүлийн 3 жилийн байдлаар харахад улсын хэмжээнд 2010 онд 40894, 2011 онд 43768, 2012 оны байдлаар 44764 галт зэвсэг иргэн, хуулийн этгээдэд бүртгэлтэй байгаагаас 2010 онд 35256, 2011 оны байдлаар 35052, 2012 онд 39953 галт зэвсэг буюу бүртгэгдсэн буюу галт зэвсгийн 2010 онд 86,2, 2011 онд 80,1, 2012 онд 89,2 хувь хамрагдсан байна. Нэгдсэн арга хэмжээний хүрээнд 2010 онд 2735, 2011 онд 3715, 2012 онд 1048 галт зэвсгийн хошуу, хонгионы дээжийг Шүүх шинжилгээний үндэсний төвд хүргүүлэн, 2010 онд 573, 2011 онд 724, 2012 онд 878 галт зэвсгийг шинээр гэрчилгээжүүлж, 2010 онд 596, 2011 онд 350, 2012 онд 314 галт зэвсэг өмчлөгчийн шилжилт хөдөлгөөнийг Галт зэвсгийн тухай хуульд заасны дагуу шийдвэрлэв.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн галт зэвсгийг зориулалтаар нь авч үзвэл ан агнах- 2010 онд 35256, 2011 онд 41131, 2012 онд 41897, харуул хамгаалалтын 2010 онд 1901, 2011 онд 1718, 2012 онд 1621, спорт, сургалтын 2010 онд 156, 2011 онд 566, 2012 онд 692, үзмэр, урлагийн 2010 онд 280, 2011 онд 253, 2012 онд 366, 2010 онд 59, 2011 онд 100, 2012 онд 188 цуглуулгын нийт 2010 онд 40894, 2011 онд 43768, 2012 онд 44764 галт зэвсэг иргэн, хуулийн этгээдийн өмчлөлд байна.

Галт зэвсгийн тухай хууль, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2010 оны 503 дугаар тушаалаар батлагдсан “Галт зэвсгийг бүртгэх, гэрчилгээ олгох”/код-602/ журмыг зөрчин улсын бүртгэлд бүртгүүлээгүй нуугдмал 2010 онд 540, 2011 онд 601, 2012 онд 790 галт зэвсгийг илрүүлж, өмчлөх эрхийн гэрчилгээгүй, хэв загварыг өөрчилсөн, гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд ашигласан 2010 онд 438, 2011 онд 612, 2012 онд 438 галт зэвсгийг түр

¹⁰¹ [http://en.m.wikipedia.org/wiki/Gun_\(Firearm\)](http://en.m.wikipedia.org/wiki/Gun_(Firearm))

хураан авч, хууль бусаар галт зэвсэг, сум худалдан борлуулдаг 2010 онд 67, 2011 онд 77, 2012 онд 76 ченжийг илрүүлэн бүртгэл хяналтад авсан байна.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн статистик мэдээгээр галт зэвсгээр үйлдэгдсэн гэмт хэрэг 2008 онд 71, 2009 онд 49, 2010 онд 27, 2011 онд 39, 2012 оны байдлаар 41 гарсан нь өмнөх онтой харьцуулахад 2 тоогоор буюу 5,1 хувиар өссөн байна. Үүнээс Хөвсгөл, Дорноговь аймагт 6, Говь-Алтай аймагт 5, Сэлэнгэ, Булган аймагт тус бүр 4 гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Цагдаагийн байгууллагаас 262 галт зэвсгийг эрэн сурвалжилж байна.

2010 онд Галт зэвсгийн тухай хуулиар 290 зөрчилд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг 1 сая 270 мянга 69 төгрөгөөр торгож арга хэмжээ авсан нь өнгөрсөн оны мөн үеэс 29.5 хувиар буурсан байна.

2011 оны байдлаар галт зэвсгийн тухай хуулиар 269 зөрчил илрүүлэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг 1 сая 795 мянган төгрөгөөр торгож арга хэмжээ авсан нь өнгөрсөн оны мөн үеэс 41,3 хувиар өссөн байна.

Галт зэвсгийн тухай хуулиар 93 зөрчилд 93 иргэнийг 459998 төгрөгөөр, захиргааны хариуцлагын тухай хуулийн 23 дугаар зүйлд зааснаар 9 зөрчилд 9 иргэнийг 110000 төгрөгөөр торгож, зөрчил гаргасан иргэдээс 3 галт зэвсэг хураасан байна¹⁰².

Галт зэвсэг худалдан авах өргөдөл гаргасан нь 2011 оны байдлаар нийслэлийн 730, орон нутгийн 430, 2012 онд 997, орон нутгийн 503 иргэнд иргэнд Нийслэлийн цагдаагийн газар, Нийгмийн хэв журам хамгаалах газар зөвшөөрөл олгосон байна. Монгол Улсын хилээр галт зэвсэг оруулах зөвшөөрөл хүссэн 2011 онд 51, 2012 онд 62, улсын хилээр галт зэвсэг оруулж, гаргах зөвшөөрөл хүссэн 2011 онд 132, 2012 онд 147 гадаадын иргэнд, спортын уралдаан, тэмцээнд оролцох тамирчдын галт зэвсгийг улсын хилээр оруулж гаргах 2011 онд 70, 2012 онд 43 зөвшөөрлийг спорт холбоодод, нэг бүрийн тусгай хэрэгсэл улсын хилээр оруулах зөвшөөрлийг 2011 онд 7, 2012 онд 10 гэрээт харуул, хамгаалалтын байгууллагад олгосон байна.

Галт зэвсгийн хэрэглэгчийн тоо жил ирэх тусам нэмэгдэх хандлага байгаа бөгөөд цаашид эзэмшигчидийн эрхийг хөндөхгүйгээр эрх чөлөө, эрх ашгийг нь хүндэтгэж, бусад хүний халдашгүй дархан байх эрхийг хамгаалахын тулд төр нэг талаас гэмт хэрэг, захиргааны зөрчил гаргасан этгээдийн эрхийг хязгаарладаг боловч нөгөө талаас галт зэвсэг ашиглах, эзэмших, өмчлөх эрхийн зөвшөөрөл олгохдоо няхуур хандаж, хяналтыг сайжруулах нь нийгмийн өмнө хүлээсэн хаиуцлагыг дээшлүүлэх чухал ач холбогдолтой юм.

“Галт зэвсгийн тухай хууль”-д заасан галт зэвсгийн тодорхойлолтыг улам тодорхой болгох шаардлагатай бөгөөд бусад зэвсгийн чанартай зүйлийг нарийн тодорхойлж, эрх зүйн зохицуулалтанд тусган боловсронгуй болгох шаардлагатай нь харагдаж байна. Тухайлбал, сум хэрэгсэл, хийн зэвсэг, харвах зэвсэг зэргийг худалдан авах, хадгалж, борлуулах асуудлыг “Галт зэвсгийн тухай хууль”-иар нарийвчлан зохицуулах хэрэгтэй нь харагдана.

Сэтгэцийн болон ямар нэгэн гаж донтой, ял шийтгэлийн хугацаа дуусаагүй байгаа хүнд галт зэвсэг эзэмшүүлж, хэрэглэхийг хориглоно гэж зааснаас нарийвчлан, тодорхойлоогүй, яаж зохицуулах талаар ойлгомжгүй байна. Өөрөөр хэлбэл ямар нэг

¹⁰²НЦГ-ын Хэв журмын хэлтсийн тайлан судалгаа.УБ.,2010

сэтгэцийн өвчтэй гэдгийн хэрхэн тогтоох, шаардлагатай бичиг баримтанд эмчийн тодорхойлолт хавсаргах талаар зохицуулалт хиймээр санагдана.

Мөн жирийн иргэн галт зэвсгийн талаар ямар нэгэн ойлголтгүй байж ашиглана гэдэг маш аюултай мэт. Харин цэргийн алба хаасан, галт зэвсэгтэй харьцаж чаддаг хүнд, эсвэл сургалтанд суусан гэрчилгээтэй иргэнд ашиглуулах эрхийг нь өгнө гэж заах нь зүйтэй болов уу. Өөрөөр хэлбэл галт зэвсэг, хэрэглэхээр өргөдөл өгч байгаа иргэнд тавих шаардлагаа өндөрсгөх хэрэгтэй.

Хуульд заасан галт зэвсэг эзэмших насыг 18 нас гэж заасан нь хэтэрхий залуу байна. Түүний оронд цэргийн алба хаасан, 21 насанд хүрсэн, галт зэвсэгтэй харьцах талаар тодорхой хэмжээний мэдлэгтэй болсон иргэнд зөвшөөрөл өгөх талаар хуульд тусгах нь зүйтэй мэт. Магадгүй цэргийн алба хаагаагүй, 21 нас хүрчихсэн иргэн галт зэвсэг ашиглахаар өргөдөл гаргаж болно. Энэ тохиолдолд түүнийг галт зэвсэг ашиглах, хадгалах, харьцах талаар сургалт дамжаанд суулгаж шалгалт өгөөд тэнцвэл галт зэвсэг олгож байж болох юм. Өнөөдөр манайд галт зэвсэг ашиглаж байгаа иргэдийн ихэнх нь түүнийг хаана ямар журмаар хадгалах ёстой вэ гэдгээ мэддэггүй. Тиймээс хамгийн наад захын асуудал болох галт зэвсгээ хаана хэрхэн хадгалж, хэрхэн хэрэглэдэг талаар мэдлэг олгох, дараа нь хүнд ашиглах зөвшөөрлийг нь өгөх нь зүйтэй мэт санагдана.

Эцэст нь дүгнэн хэлбэл цагдаагийн байгууллагаас иргэдийн галт зэвсэг ашиглах, эзэмших өмчлөх эрхийн зөвшөөрөл олгох ажиллагааны эрх зүйн зохицуулалт, түүний онолын болон практик асуудлыг гүнзгийрүүлэн судалж, түүнд дүн шинжилгээ хийж, тогтоосон хууль тогтоомжийг цаашид боловсронгуй болгох үүднээс дараахь санал дэвшүүлж байна.

Галт зэвсэг ашиглах, эзэмших, өмчлөх эрх нь нэг талаас хүний эрх ч нөгөө талд асар их хор хөнөөл дагуулж болзошгүй тул түүнд зөвшөөрөл өгч, хяналт тавьж, түүний үр нөлөөг дээшлүүлэх зайлшгүй шаардлага байгааг тэмдэглэх юун.

Монгол Улсын Үндсэн хуулийн "Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй" гэсэн 19-р зүйлийн 3 дахь заалт ёсоор галт зэвсэг **өмчлөх эрх нь бусад хүний эрхийг зөрчихийг зөвшөөрөхгүй байхад чиглэгдэнэ.**

Судлаач зарим зүйлд анхааран галт зэвсэг ашиглах, эзэмших, өмчлөх эрхийн зөвшөөрөл олгох, хяналт тавих үйл ажиллагаа түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохын тулд дараах саналыг дэвшүүлж байна.

1. Галт зэвсгийн талаархи нэр томъёоны хувьд өөрчлөлт оруулах, бусад хэрэглэгдэхүүнийг томъёолох. Өөрөөр хэлбэл сум хэрэгсэл, хүйтэн зэвсэг, хийн зэвсэг, харвах зэвсэг гэх мэт бусад ойлголтуудыг тодруулж өгөх шаардлагатай байна.
2. Мөн иргэний эзэмших галт зэвсэг ямар зориулалтаар, яаж хэрэглэх талаар нарийвчлан зохицуулалт шаардлагатай байна.
3. Галт зэвсгийн тухай хуулийн 5.2-т заасан "...архаг архичин, мансуурах донтой гэж тооцогдсон этгээд галт зэвсэг өмчлөх, эзэмших, ашиглах эрхгүй....." гэж заасан боловч түүнийг хэрхэн ойлгох, зөвшөөрөл олгох талаар хуульд нарийвчлан заагаагүй.
4. Галт зэвсгийн тухай хуульд заасан хариуцлагыг чангатгах, үр нөлөөг нь дээшлүүлэх талаар сургалт явуулах.
5. Хууль зүйн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар галт зэвсэг өмчлөхийг хориглосон өвчний жагсаалт батлагдсан боловч ямар тохиолдолд эмнэлэгийн аль байгууллага эмч дүгнэлт гаргахыг журамд тодорхой зааж өгөх

6. Галт зэвсэг өмчлөх болон үндсэн болон хамтран эзэмшигч иргэдэд хууль эрхийн мэдлэг, галт зэвсэгтэй харьцах дадлага эзэмшүүлэх, Галт зэвсэг эзэмшигч бүр тусгай сургалтанд заавал хамрагдсанаар галт зэвсэгтэй харьцах аюулгүйн арга хэмжээг сахих ажиллагаа сайжирч, санамсар болгоомжгүй байдлаас гарах осол, хэрэг зөрчил буурахад анхаарах нь зүйтэй.

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

АЛБАДАН АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛЫН АЧ ХОЛБОГДОЛ, ЯЛ ОНОГДУУЛАХДАА ШҮҮГДЭГЧИЙН ХУВИЙН БАЙДЛЫГ ХАРГАЛЗАХ НЬ

*О.Пүрэвсүрэн
ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн
сургуулийн багш, ахмад, магистр*



Хүн төрөлхтөн өөрийн хөгжлийн явцад хамтран амьдрах ёс жаяг, хэм хэмжээг зөрчсөн гэм буруутай этгээдийг цээрлүүлж ирсэн шийтгэлийн төрөл янз бүр байсан ба тэдгээр нь нийгмийн хөгжлийг даган өөрчлөгдсөөр өдий хүрчээ.

Гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг цээрлүүлэх аргын хамгийн түгээмэл төрөл нь “хорих ял” байсан төдийгүй энэ нь гэмт хэрэгтнийг нийгмээс тусгаарлаж, иргэдийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэрэгтнийг залхаан цээрлүүлэх, хүмүүжүүлэх, хохирогчийн хариу авах хүсэл сонирхлыг ямар нэг хэмжээнд хангах зориулалттай бөгөөд түүхийн хөгжлийн явцад хаягдаж гээгдэлгүй дэлхийн аль ч улсын ял шийтгэлийн системд голлох үүрэг гүйцэтгэсэн хэвээр байна. Гэвч уг ялыг эдлүүлэхэд төрөөс зарцуулах өртөг зардал их, хоригдол хорих ял эдлэх явцад нийгмээс хөндийрч төсөөрдөг тул суллагдсаны нь дараа нийгэмшүүлэх арга хэмжээг зайлшгүй авах шаардлагатай. Үүнд зориулж хөрөнгө хүч гаргах төрөөс асар их зардалтай хэрэгждэг ял юм.

Манай улсад хорих ял эдлүүлэхэд гарч байгаа зардлын нэг хоригдлыг хорих ял эдлүүлэхэд 2004 онд шууд бус зардал нь 1441, шууд зардал 793 төгрөг бүгд 2234 төгрөгний зардлыг хоногт зарцуулж байна. Улмаар нэг сард 67020 төгрөгийн зардал гарч байсан. Харин 2014 оны байдлаар нэг ялтанд оногдож байгаа зардал нэг өдөрт 10648 төгрөг, сард 319440 төгрөг байна. /Үүнийг 6000 хоригдлын тоог үзүүлэлтэнд харьцуулахад сард 1.916.640.000 төгрөгний зардал гарч байна. Өнөөдрийн байдлаар төрийн үйлчилгээний албаны ажилтан сард дунджаар 350.000-400.000 төгрөгний цалин авч байгаа гэж бодвол төрийн үйлчилгээний ажилтан бүтэн сарын турш улсынхаа төлөө, амьдралынхаа төлөө зүтгэж олдог мөнгийг гэмт хэрэг үйлдсэн нэг ялтны хорих ял эдлүүлэх ажиллагаанд зарцуулж байна гэж ойлгож болох юм.

Хэрэв ялтанд хорих ялыг эдлүүлээд дараа нь нийгэмшүүлэх арга хэмжээ авахгүй бол тодорхой хугацаагаар нийгмээс тусгаарлагдсан хүн тухайн нийгэмд дасан зохицох чадвар нь суларсан байдгаас дахин гэмт хэрэг үйлдэх, биеийн амар байдлыг илүү үзэх, бусдын хөдөлмөрийг мөлжих, улмаар нийгэмд өширхөх зэрэг үзэл баримтлал тогтох магадлал ч ихээхэн өндөр байдаг. Эдгээрээс үүдэн хорих ялын зэрэгцээ түүний оронд сонгон хэрэглэхэд илүү зохистой, үр нөлөөтэй, өртөг зардал, сөрөг үр дагавар багатай ял бий болсон хэдий ч, энэ талаар зохих судалгаа, эрэлхийх шаардлага зүй ёсоор бий болж

байна. Үүний үр дүн нь дэлхийн олон улс оронд эдүгээ хэрэглэгдэж буй өвөрмөц төрлийн ял болох "Нийгэмд үйлчлэх" /community service/ ял билээ.

Шүүхийн шийдвэрээр, өөрийнхөө үйлдсэн хэргийн төлөө шоронд суухын оронд гэм буруугаа цайруулж байгаагаа нийгэмд тустай ажил хийж харуулах боломжийг ялтанд олгож байгаад уг ялын мөн чанар илрэх юм. Албадан ажил хийлгэх ялыг шүүхээс түлхүү оноох нь ялтныг нийгэмшүүлэх, хүмүүжүүлэх ажилтай шууд хамааралтай төдийгүй улс орны эдийн засаг тодорхой ач холбогдолтой гэж үзэж байна. Энэхүү албадан ажил хийлгэх ялын хэрэглээ, арга зүйг оновчтой улам боловсронгуй болгох нь өнөөгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хийгдэх нэг гэж үзнэ байна.

Иймээс хэргийн холбогдогчид ял оноохдоо зөвхөн үйлдсэн хэргийн байдлыг төдийгүй хувийн шинж байдлыг ч харгалзах нь Эрүүгийн эрх зүйн нэг чухал зарчим билээ. Тэгвэл энэ зарчим нь албадан ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн хүмүүсийн хувьд хэрхэн хэрэгжсэнийг зориуд судалснаар Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцож мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагааг явуулж байгаа мөрдөн байцаагч, шүүгчид улмаар прокуророос анхаарвал зохих зүйлүүд байгааг энд зориуд дурьдаж байна.

Албадан ажил хийлгэх ялыг оноох явцад шүүгдэгчийн хувийн байдлыг тодруулахын тулд дараах хүчин зүйлийг харгалзах нь зүйтэй. Үүнд:

1. Хэргийн холбогдогчийн хувийн зан төрхийг тогтооход юуны өмнө түүний гэр бүлийн орчинг тодорхойлох зүйтэй. Яагаад гэвэл ихэнх гэмт хэрэгтний нийтлэг хэв шинж, зан авир нь тэдний гэр бүлийн хүмүүжил, бага насны амьдрал нь түгшүүртэй таагүй нөхцөл байдлын дунд өнгөрсөн учраас хожим нь тэд гэмт хэрэгт холбогдох, хэрэгтэн болох үндэс болсон байдаг. Гэр бүлийн хүмүүжил доголдол эцэг эхийн хоорондын зөрчил, гэр бүл салалт зэргээс болж багаасаа хайр халамж, хараа хяналт дутуу байдлаасаа болоод хүйтэн цэвдэг сэтгэлтэй, хэрцгий догшин, түрэмгий зантай болдог. Тухайн хэрэгтний гэр бүл, орчны талаарх мэдээллийг тодорхой гаргаж өгч, ингэснээр ял эдлүүлэх шатанд уг ялтантай нийгмийн ажилтан, сэтгэл зүйч чухам ямар чиглэлээр яаж ажиллах вэ? гэдэг асуудал шийдэгдэх нөхцөл бүрдэх юм. Хэрэгтний талаархи гэр бүлийн гишүүдийн үнэлэмж дээр үндэслэн ялыг оноох нь хэрэгтний гэр бүл дотроо эзлэх байр суурь, гэр бүлийн гишүүдийн зүгээс тухайн хүнд хандах хандлага, санхүүгийн болоод халамжийн хараат байдалд байдаг эсэхийг тодорхойлоход ч чухал ач холбогдолтой. Ингэж тодорхойлсноор гэр бүлийн доторх нийгмийн асуудлыг хөндөхгүйгээр, нэг үгээр хэлбэл гэр бүлд үлдэж буй гишүүдэд санхүүгийн болон сэтгэл зүйн ямар нэгэн дарамт үзүүлэхгүй байдлаар ялыг зөв оноох, эдлүүлэхэд нь чухал байна. Жишээ нь: Ялтан гэр бүлийн бусад гишүүдээ тэжээн тэтгэдэг гол хүн нь байвал албадан ажил хийлгэх ялыг нь эдлүүлэхдээ шийдвэр гүйцэтгэгч нь ажиллуулагч талтай тохирч аль болох ажлын бус цагаар нь ажиллуулах гэх мэт.

2. Хэрэг бүртгэлтийн шатнаас эхлэн холбогдогчын ар гэрийнхэнд нь хандахдаа тэднийг сэжигтний гэр бүлийнхэн гэдэг талаас бус, харин тухайн ялтанг засарч нийгэмших ялаа эдэлж дуусгахад нь дэмжиж туслах ёстой жижиг бүлэг хамт олон гэж үзэх нь зохистой.

Ингэснээр хэргийн холбогдогч давтан хэрэг үйлдэхэд нь гэр бүлийн зүгээс нь нөлөөлөх хүчин зүйл бий эсэхийг тодруулах, мөн хэрэг үйлдсэн нь шүүхийн журмаар тогтоогдсон тохиолдолд ямар төрлийн ял оноох нь тухайн хүндээ илүү ач холбогдолтой вэ? гэдэгт шууд нөлөөлнө.

3. Холбогдогч, шүүгдэгчийн хувийн шинж байдлыг харгалзан үзэхийн тулд түүний гэр бүлийн доторх болон хамгийн ойр дотны найз нөхдийнх нь дундаас хамгийн итгэлтэй дотны хүнийг тогтоон оролцуулах нь маш чухал байдаг. Үүнийг уг хүнтэй харилцах харилцааны явцдаа тодруулах бололцоотой юм. Түүнтэй харилцах үед ярианд нь дотны гэх хүний нь нэр удаа дараа давтагдан гарах бөгөөд, тухайн сэжигтний гадаад төрх нүүр

царайны хувилбар зэргээс шалтгаалж дотны хүн нь гэдгийг төвөггүй мэдэж болох юм. Ингэснээр дотны гэх тодотголтой хүнийг мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагаанд эерэг байдлаар ашиглах бололцоо бий болно. Тухайн хүн хийсэн үйлдлийнхээ талаар өөрийн ойр , дотны гэх итгэлтэй хүндээ хэлсэн ярьсан байх магадлал илүү байдаг. Шүүгдэгч, холбогдогчын хувьд хүндэтгэдэг, үгийг нь сонсдог хүнийг мөрдөн байцаагч, шүүгч олж мэдсэнээр тэр хүнээр нь дамжуулж **хэргээ үнэн зөвөөр мэдүүлэх нь чамд ашигтай** гэдгийг ойлгуулах, хэрэг ер нь юунаас болов гэдгийг нь бодиттой тогтоох нөхцөл бүрдэж болно.

Түүнчлэн дотны хүнээр нь дамжуулж сэжигтэнг гэм буруугаа ойлгох, гэмшихэд нь нөлөөлнө. Хожим шүүхээр гэм буруу нь нотлогдон ял оноох үед ялыг шударгаар эдлэх сэтгэл зүйн бэлтгэлтэй болгоход ч ашиглаж болох юм. Гэр бүлийн гишүүдийн болон найз нөхдийн дотор хамгийн ойр дотны гэх хүмүүсийг нь тогтоосноос гарах дараагийн нэг ач холбогдол бол мөрдөн байцаалт шүүн таслах ажиллагааны явцад холбогдогчийг саадгүй ирүүлэх зорилгоор батлан даагчийг тодруулахад ч нөлөөлнө. Мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагааны явцад батлан даагч нь зохих үүрэг хариуцлага хүлээж оролцдог. Тэгвэл дотны хүн нь батлан даагч байснаар мөрдөн байцаалт шүүхээс зайлсхийхгүй, мөрдөн байцаах шүүн таслах үйл ажиллагаанд холбогдогчийн зүгээс саад учруулахгүй байх бололцоо гардаг.

4. Албадан ажил хийлгэх ялын нэг гол зорилго бол хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх төдийгүй сэтгэлдээ гэм буруугаа ухаж ойлгож, тодорхой хамт олны дунд орж ажилласнаар **Би бол бусдад хэрэгтэй юм хийж чадах юм байна шүү. Уг нь элдэв хэрэг төвөгт орж орооцолдож явахын оронд энэ мэт ажил хийж бусдын төлөө байж чадах юм байна гэдгээ хэрэгтэн ойлгох**, эндээс бий болох гол амжилт бол хэрэгтэн нийгэмд өөрийн үнэ цэнээ мэдэх итгэлийн гал очыг бадраадагт л орших юм. Үүнийг бий болгоход шүүгч, мөрдөн байцаагч гол үүрэгтэйгээр оролцох ёстой. Энэ нь тухайн хүний ирээдүйн амьдралтай шууд холбоотой. Иймд шүүгдэгчдэд албадан ажил хийлгэх ял тохирно гэж үзвэл тэрээр хамт олны дотор орж ажиллах чадвартай эсэх, бусадтай хир нийцтэй, ажил үүрэг хариуцуулвал ер нь хир биелүүлж хариуцаж чадахаар юм бэ? гэдгийг анхаарах нь зүйтэй. Энэ нь хэрвээ уг ялыг түүнд оноовол ялтан тодорхой хамт олон дотор орж ажиллаж ял жинхэнэ зорилгоо хангах эсэхийг тодотгох гол хүчин зүйл болох юм. Харин шүүгдэгчтэй уулзах байцаах явцад уг хүн ер нь бусадтай эв нэгдэл муутай, түрэмгий зантай, бусад захирагдах дургүй, харин ч бусдыг эрх мэдэлдээ байлгах дуртай зэрэг шинж илэрвэл албадан ажил хийлгэх ялыг оноох нь хир зохимжтой вэ? гэдэг дээр эргэлзээ гарна. Хэрвээ энэ ялыг оноовол уг ялтан нь ажиллуулагч талдаа бүрэн, үг дуугүй захирагдаж хий гэсний нь хийх болно. Гэтэл төрөлхийн зан төрх нь ямар билээ? Ялтан ажиллуулагчийн үүрэг даалгаврыг биелүүлэхээс татгалзах, сөрөг зүйл гарч эндээс оноосон ял үр дүнгүй болж ялыг нь солих асуудал ч гарч болох юм. Иймээс шүүх гэмт хэрэгт холбогдогчийн хэргийг шийдвэрлэх үедээ түүний ажиллаж байгаа буюу ажиллаж байсан хамт олны дүгнэлтийг харгалзах нь чухал юм. Хамт олны, айл хөрш гэх мэт орчны хүмүүсийн дүгнэлтийг харгалзан үзснээр тухайн хүнийг хамт олон үнэлэх үнэлэмжийг мэдэх төдийгүй мөн өөрийгөө хамт олон дотор хир нэр хүндтэй гэдгээ ойлгон мэдэх ухамсарлан өөрийн нэр хүнд байр суурийг тодорхойлж, өөрийн гэсэн итгэл үнэмшилтэй байх, ирээдүйд тэрээр ажилтан болоод хамт олны дунд орж ажиллаж амьдрах бололцоотой одоо эдэлж буй ял нь зөвхөн хэсэг хугацааны асуудал гэдгийг хэрэгтэн ойлгох, хамт олны талаарх эерэг ойлголттой болгосноор хувь хүний ирээдүйд чухал ач холбогдолтой юм,

5. Мөн ялтны эрүүл мэндийн байдалд анхаарлаа хандуулан ял авсан хүмүүсийн эрүүл мэндийн талаарх тодорхойлолтыг нарийвчлан гаргаж баталгаажуулах шаардлагатай

байна. Ялтны эрүүл мэндийн байдалд анхаарал тавьснаар ял эдэлж байх хугацаанд эрүүл мэндийн ямар нэгэн хүндрэл бэрхшээл тулгарахгүй байх, мөн ялын хугацаа удаашрах, ялаас залхах, зайлсхийх, ялын үр дүнд сөрөг байдлаар нөлөөлөхөөс сэргийлж чадах юм. Тухайлбал: Албадан ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн зарим ялтан ял эдлэх явцдаа доороосоо даарч хөрч бөөр, давсагны замын хууч өвчин нь хөдөлж хүндрэх, өвдөх магадлалтай байна. Ингэснээр ял эдлэлтийн явц удаашрах, сунжирч хойшлох таагүй үр дагавар гарч байгаа юм.

6. Албадан ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн хүний мэргэжил, сайн хийж чадах ажил насыг тодруулах нь ач холбогдолтой. Ийм тодруулга хийдэггүйгээс одоогийн байдлаар 6 дүүргийн тохижилт үйлчилгээний компани дээр голдуу албадан ажил хийлгэх ялыг нь эдлүүлж, ялын хугацааг дуусгавар болгож байгаа хэдий ч энэ цаашид нийгэмд ашигтай болох тухайн ялтны хүмүүжилд хэр зэрэг нөлөө үзүүлэх, ялын үр дүнгийн талаар хэлэхэд тун бүрхэг байгаа юм ,

7. Холбогдогч шүүгдэгчийн тодорхой шинж төрхийн илрэх тодорхой хэлбэр бол хэрэгтээ хандах хандлага, түүнээс учирч бий болсон хохирлоо нөхөж арилгаж буй байдал юм. Шүүгдэгч хохирлоо ямар нэг хэмжээгээр арилгах гэж оролдох, арилгачих юмсан гэсэн сэтгэл гаргаж байгаа нь түүний зан төрхийн сайн талыг харуулах юм. Иймээс хүнд хөнгөн ял оноох субъектив нөхцөл байна гэсэн үг билээ.

8. Албадан ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн хүмүүс нь байнгын оршин амьдрах газар тодорхойгүй хаягийн зөрчилтэй байгаа нь албадан ажил хийлгэх ялыг эдлүүлэх үйл ажиллагаанд хүндрэл учирч байна. Иймээс шүүгчид ял оноох үедээ хаягийг үнэн зөв тогтоож хэрэгт тэмдэглэгээ хийх нь чухал.

Дээр дурьдсан нөхцөл байдлыг тогтоосноор албадан ажил хийлгэх ял бүхий ялтантай ажиллах нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдэд ялтныг нийгэмшүүлэх хөтөлбөр боловсруулахад нь төдийгүй ялыг хэвийн эдлүүлэхэд нь шийдвэр гүйцэтгэгч болон ажиллуулагч талын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх юм. Мөн ялтанд нийгмийн чадвар олгох, ажил хамт олны дундаас ямар хүмүүжил олох, олон нийтийн дунд биеэ зөв авч явах мэдлэг чадварт суралцуулах зан төлөвийг өөрчлөн төлөвшүүлэхэд ч нөлөө үзүүлэх юм. Гэхдээ чухам ямар төрлийн үйлчилгээ үзүүлэх вэ? гэдгийг тогтоохын тулд анхан шатны мэдээлэл болох хэрэг бүртгэлтийн шатнаас бүрдүүлсэн материалууд чухал ач холбогдолтой.

Дээр дурьдсан асуудлууд нь зөвхөн мөрдөн байцаагч, шүүгчид төдийгүй, улсын яллагч, өмгөөлөгчдөд ч бас шууд хамааралтай ялангуяа өмгөөлөгчийн зүгээс өмгөөлж буй этгээдийг үзэж байгаа үзэл, ойлголт нь хэргийг шийдвэрлэх, хэрэгтэнд гэмших сэтгэл төрүүлэх, хэрэгтний шинж байдлыг тодруулахад гол зангидах хүч болох юм.

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АРГА ЗАМ

*Ж.Өнгөтхүү
ХСИС-ийн Шинжлэх ухаан, технологийн
газрын Шүүхийн шинжилгээ судлалын төвийн эрдэм шинжилгээний
ажилтан, магистр, цагдаагийн хошууч*



Сүүлийн жилүүдэд манай улсад үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн гаралт нэмэгдэх хандлагатай байна. Түүний дотор хар тамхины борлуулалт, тээвэрлэлт, хүний наймаа, авлига, хээл хахууль болон бусад олон гэмт хэргээс үүдэлтэй мөнгө угаах зэрэг их хэмжээний орлого олдог гэмт хэргийн төрлүүд зохион байгуулалттай хэлбэрт шилжин орсон нь улс орны аюулгүй байдал, эх орны газар шороо, байгаль орчинд аюул нүүрлэх хэмжээнд хүрч болзошгүй болоод байна.

Өнөөдөр эдгээр гэмт хэрэгтэй тэмцэхэд уламжлалт аргаар тэмцэхээс гадна орчин үеийн шинэ техник, цөмийн болон нано технологийг нэвтрүүлэн шүүх, хууль хяналтын байгууллага, хууль сахиулах байгууллагууд, эрх зүйч, хуульч нарыг бэлтгэх сургалтын бодлогод зоригтой өөрчлөлт шинэчлэл хийж хуучинсаг хана хэрмийг бүхлээр нь нураан унагах цаг үе, дэлхий нийтийн жишиг биднээс зүй ёсоор хүссэн хүсээгүй ч шаардаж байгааг цаг алдалгүй хүлээн авч хэрэгжүүлэх амин чухал эрхэм зорилго болж байгааг анзаарахгүй өнгөрүүлэх эрх бидэнд байхгүй болжээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх үйл ажиллагааны цөм болсон Шүүхийн шинжилгээний байгууллагад бүтэц орон тоо, үйл ажиллагааны орчин, техник, технологийн өөрчлөлт, шинэчлэлт хийх шаардлагатай байна.

УИХ-аар батлагдсан 2014 оны 1-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болох Цагдаагийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйл: Цагдаагийн алба, алба хаагч нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаас гадна хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ил тод, нээлттэй байх, нууцыг чанд хадгалах, олон нийтийн итгэл хүлээх, иргэний дэмжлэгийг авах, төрийн болон төрийн бус байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, иргэдтэй харилцан хамтран ажиллах, шинжлэх ухааны, орчин үеийн техник, технологи, мэдээллийн үнэлгээний ололтыг ашиглах, нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх үндсэн зарчмыг баримтална.

5 дугаар зүйлд: Цагдаагийн байгууллагын тогтолцоо

5.6. Цагдаагийн төв байгууллага нь гэмт үйлдлийг зогсоох, гэмт этгээдийг аюулгүй болгох, баривчлах үүрэг бүхий тусгай бэлтгэл тактикийн бүлэг, тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр дагнасан шүүхийн шинжилгээний нэгжийг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад байгуулан ажиллуулж болно гэх мэт Шүүхийн шинжилгээний байгууллагатай холбоотой олон заалтууд орсон нь сайшаалтай байна.

Цагдаагийн албаны шүүхийн шинжилгээний байгууллага нь:



гэсэн бүтэцтэй бөгөөд **“шинжээч”** гэж шүүхийн шинжилгээ хийх арга зүйг эзэмшсэн, шинжилгээ хийж, дүгнэлт гаргахаар хуульд заасан журмын дагуу томилогдсон, тусгай мэдлэг, мэргэжил эзэмшсэн байна.

Шүүхийн шинжилгээний **“мэргэжилтэн”** гэж криминалистикийн болон эмнэлгийн тусгай мэргэжил эзэмшсэн, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд мэргэжилтнээр оролцох эрх бүхий, цагдаагийн байгууллагын ажилтныг хэлнэ.

Шүүхийн шинжилгээний мэргэжилтэн нь эрх зүйч, инженер, биологич, химич, физикч, математикч болон бакалаврын түвшингийн Цагдаагийн байгууллагад ажиллах хүсэл эрмэлзэлтэй хүмүүсийг криминалистикийн онол арга зүй, техник зүйн чиглэлээр тодорхой хугацаанд сургалтад хамруулан хэрэг, учралын газрын үзлэгийг хийх чадвартай болгон төгсгөнө. Эдгээр хүмүүс нь өөрийгөө хөгжүүлэн дахин суралцаж, Шүүхийн шинжилгээний тодорхой чиглэлээр шинжилгээний арга зүйг Хууль сахиулахын их сургуулийн Шүүхийн шинжилгээний тэнхимд мэргэшүүлэх сургалтад хамрагдан сертификат авснаар шинжилгээ хийх эрх зүйн орчин нь бүрэлдэнэ.

Шүүхийн шинжилгээний мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн гэсэн зэрэглэлтэй байх бөгөөд мэргэжилтэн нь тодорхой нэг чиглэлээр мэргэшсэн байж болно. Гарын мөрөөр мэргэшсэн мэргэжилтэн гэхэд физик, хими болон шинэ ололтот техник, технологийг ашиглан хүйтэн, цас бороотой, байгалийн бэрхшээлтэй үед болон удаж, муудсан гарын мөрийг төрөл бүрийн гадаргуу дээрээс илрүүлэн бэхжүүлэн авах чадварыг бүрэн эзэмшсэн байна.

Шинжээч нь хэргийн газрын үзлэгт оролцдоггүй, шинжилгээ хийлгэх эрх бүхий алба хаагч нарын шинжилгээ хийлгэх тогтоолыг үндэслэн криминалистикийн, бараа судлалын, химийн, биологийн, авто техникийн, галын шинжилгээ хийх арга зүйг эзэмшсэн шинжилгээ хийх эрх бүхий цагдаагийн байгууллагын ажилтан байна.

Шүүхийн шинжилгээний шинжээч, ахлах шинжээч гэсэн зэрэглэлтэй байх бөгөөд шинжилгээний тодорхой нэг төрлөөр мэргэшсэн байх шаардлагатай бакалавр, түүнээс дээш боловсролын түвшинтэй, цагдаагийн байгууллагын шүүхийн шинжилгээний алба хаагч байна.

УИХ-д өргөн баригдаад байгаа Мөрдөх албаны тухай хуулийн төсөлд:

3.1.2. **“Шинжээч-мөрдөгч”** гэж хуульд заасан болзол, шалгуурыг хангаж, тангараг өргөсөн, Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хуульд заасан мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий, шинжилгээ хийж, дүгнэлт гаргах чадвартай хууль сахиулах алба хаагчийг,

3.1.3. **“Шинжээч”** гэж хуульд заасан болзол, шаардлагыг хангаж, тангараг өргөсөн, хууль сахиулах, гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэргэжилтнээр оролцох, шинжилгээ хийх, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий алба хаагчийг,

9.1.6. Шүүх шинжилгээ хийж, дүгнэлт гаргах, улсын хэмжээний шүүхийн шинжилгээний нэгдсэн болон төрөлжсөн сан бүрдүүлэх.

18.1. Мөрдөх албаны алба хаагч нь мөрдөгч, шинжээч-мөрдөгч, криминалистикийн мэргэжилтэн, техникийн тусгай ажилтнаас бүрдэнэ.

Уг хуулийн төсөлд Мөрдөх алба шүүхийн шинжилгээний албатай байхаар хуульчилсан, Шүүхийн шинжилгээний алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй шинжээч-мөрдөгч, криминалистикийн мэргэжилтэн, шинжээч гэсэн албан тушаалуудтай байхаар заасны дээр эдийн засаг, нийгэм, аюулгүй байдлын баталгааг сайн хангахаар хуулийн төслийг боловсруулсан байгаа хэдий ч **криминалистикийн мэргэжилтний** талаар огт заагдаагүй нь учир дутагдалтай санагдаж байна.

Мөрдөх албаны **Шүүхийн шинжилгээний мэргэжилтэн** гэж криминалистикийн болон эмнэлгийн тусгай мэргэшил эзэмшсэн, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд мэргэжилтнээр оролцох эрх бүхий албан хаагч гэж оруулбал зүйтэй болов уу.

Цагдаагийн алба, Мөрдөх албаны дэргэд шүүхийн шинжилгээний алба байгуулахын дээр Тагнуул, Прокурор, Авлига гэх мэт байгууллагуудад шүүхийн шинжилгээний алба байгуулваас эдгээр байгууллагуудад өөрийн онцлог нөхцөл байдлыг хадгалсан шинжилгээнүүдийг түргэн шуурхай хийх бололцоо нь бүрдэнэ.

Тагнуул, Прокурор, Авлига гэх мэт байгууллагуудад криминалистикийн мэргэжилтэн байх шаардлагагүй, шүүхийн шинжилгээний арга зүйг эзэмшсэн **шинжээч** байхад болно гэж үзэж байна.

Дэлхий нийтийн өнөөгийн чиг хандлага гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэхдээ шинэ технологи, нано, цөмийн технологийг ашиглан хамгийн бодит үнэн болох биет нотлох баримтанд шинжлэх ухааны үндэслэлтэй хийгдсэн Шүүхийн шинжилгээний дүгнэлтэнд тулгуурлан улс орныхоо аюулгүй, бүрэн бүтэн байдал, улс орныг мөхөлд хүргэдэг хээл хахуулиас ангижрах, хүний эрх, эрх чөлөөг найдвартай хамгаалан нэг ч иргэнээ хохироохгүй үйлчлэх зам руу шилжин орж, гэм буруутай хэнийг ч шүүхээс ял завшуулахгүйн тулд ашиглаж байна. Энэ тогтолцоог манай улсад нэвтрүүлэх онц чухал цаг мөч ирээд байна.

Мөрдөх албаны **шинжээч-мөрдөгч** нь гэмт хэрэгтэй тэмцэхдээ ил далд нууц ажиллагаатай оролцдог, криминалистикийн мэргэжилтний шүүхийн шинжилгээний арга зүйг бүрэн эзэмшсэн, эрх зүйн мэдлэг боловсролтой ажилтан байх шаардлагатай. Энэ шалгуурыг ХСИС-ийн Шүүх шинжилгээ- эрх зүйч мэргэжлээр бакалаврын боловсролтой алба хаагч хангаж чадна гэж үзэж байна.

Харин мөрдөх албаны **шинжээчээр** энгийн их, дээд сургуулийг бакалавраас дээш боловсролын түвшингээр төгссөн химич, физикч, биологич, эмч төрөл бүрийн мэргэжлээр төгссөн инженерүүдийг сонгон шалгаруулалтаар элсүүлэн тодорхой хугацаагаар шүүхийн шинжилгээний арга зүйг зааж сурган мэргэжлийнх нь чиглэлээр шинжээчээр ажиллуулах нь зүйтэй.

Шинжээч нь хэргийн газрын үзлэгт оролцохгүй гэмт хэрэгтэй тэмцэх, ил, далд нууц ажиллагаанд оролцох эрхгүй зөвхөн шинжилгээний нууцлалыг задруулахгүй байх шаардлагатай байхаас гадна ямар нэгэн хууль сахиулах байгууллагаас хараат бус хөндлөнгийн, бие даасан буруутгах болон хамгаалах 2 талын дунд тэгш эрхтэй шинжилгээний байгууллага байснаар хуулийн өмнө хүн бүр тэгш эрхтэй болгох үндэстэй. Ийм систем рүү дэлхийн олон орон шилжин орж байна. Үүнд: Нидерланд, Эстони, Турк, Тайван, Казакстан зэрэг улсууд. Энэ загвар нь АНУ-ын шилмэл загвар болж байна.

Манай улсад нутагшуулж болох хувилбар байж болох талтай. Хууль сахиулах байгууллагуудын лабораториос гадна Улсын шүүхийн шинжилгээний байгууллага нь Хууль зүйн яамны шууд удирдлаганд байх ба бүсүүдийн Шүүхийн шинжилгээний хүрээлэнгүүд, нийслэл, аймгийн шүүхийн шинжилгээний албадуудын удирдан зохион байгуулах үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулна.



Гэхдээ Улсын шүүхийн шинжилгээний Төв байгууллага нь шинжилгээг гардан хийдэг, шинжилгээ хийхэд туслах үүрэгтэй оролцдог /лаборант, туслах ажилтан, бага эмч зэрэг/ хүний нөөцийг нэмэгдүүлэх, удирдлагын аппаратыг цөөлж чадварлаг, цомхон хууль сахиулах байгууллагуудын шүүхийн шинжилгээний албадын болон хувийн шүүхийн шинжилгээний лабораториудад хийгдсэн маргаантай шинжилгээнүүдийг хөндлөнгийн хяналтын чиг үүрэгтэйгээр шинжилгээ хийгддэг байх ёстой гэж судлаач би судалгаанд тулгуурлан үзэж байна.

Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж буй бүх Шүүхийн шинжилгээний лабораториуд стандартчлагдан магадлан итгэмжлэгдэж байх шаардлагатай.

Дэлхийн улс орнуудын Шүүхийн шинжилгээний байгууллагуудад өөрийн орны болон бүх нутаг, дэлхийн хэмжээний стандартчлалын байгууллагаар магадлан итгэмжлэгдсэн, ялангуяа **хууль сахиулах байгууллагаас хамааралгүй, хөндлөнгийн бие даасан шүүх шинжилгээний байгууллага, лаборатори магадлан итгэмжлүүлсэн байна.**

Үүнээс гадна Нидерланд, Эстони, Гүрж, Турк, Тайланд, Казакстан зэрэг улсууд хувийн шүүхийн шинжилгээний лабораториудтай болж, АНУ-ын сонгомол жишгээр хөгжиж байгаа нь манай оронд нэвтрүүлэх шаардлага гарч байна. Энэ нь буруутгах талын эсрэг хамгаалах өмгөөлөх 2 тал нь тэнцүү болж хүний эрх, эрх чөлөө бүрэн дүүрэн хангагдах талтай.

Иймд манай улсад Улсын Шүүхийн шинжилгээний төв байгууллага, хууль сахиулах байгууллагын шүүхийн шинжилгээний байгууллагууд, Хувийн хэвшлийн шүүхийн шинжилгээний байгууллага гэсэн гурван субъект Шүүхийн шинжилгээний өрсөлдөх чадвар бүхий хүчтэй байгууллага болох шаардлага гарч ирж байна.




Улсын Шүүхийн шинжилгээний байгууллагад цөмийн технологийн хэрэглээний бас нэг чиглэл болох үл эвдрэх сорилын аргыг нэвтрүүлэх нь бодис дундуур нэвтэрсэн буюу сарнисан цөмийн цацрагийг бүртгэх замаар барилгын хяналт, шинжилгээнд цөмийн технологийн аргуудыг хэрэглэн **чанаргүй барилга, байгууламж, зам барих ажиллагаанд дүгнэлт гаргах нь хээл хахууль, авлигын хардалт сэжиглэлт зэргийг нэг бүр шийдвэрлэж чадснаар авлига, хээл хахуулийн хэрэг багасах боломжтой болох юм.**

Улсын шүүхийн шинжилгээний байгууллагыг шинэ нано, цөмийн нарийн техник, технологид суурилсан хүчтэй мэргэшсэн лабораториудыг байгуулж чадваас гэмт хэрэг илрүүлэхэд Хууль сахиулах байгууллагын хараат бус үйл ажиллагаатай нотлох баримтанд шинжилгээ хийх хүчтэй, хөндлөнгийн хяналтын чиг үүрэгтэй шинжилгээ, түршилт судалгааны дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн улсын хэмжээний хүчирхэг чадварлаг цомхон байгууллага болох шаардлага үндэс суурь нь манай улсын хөрсөнд нутагшиж урган хөгжих суурь нь тавигдаад байна.

Дээр өгүүлсэн асуудлыг шийдвэрлэхэд бидний өмнө хүний нөөц, сургалтын орчинг зоригтой өөрчлөн Эрх зүйч мэргэжлээр сургалт явуулдаг их, дээд сургуулиудын хөтөлбөрт “Нотолгооны онол”, “Криминалистикийн техник, арга зүй” хичээлүүдийн багц цагийг нэмэгдүүлэн тэргүүлэх хичээл болгох шаардлага гарч ирнэ.

Хууль сахиулахын их сургуульд Шүүхийн шинжилгээний сургуулийг шинээр нээн Хууль сахиулах байгууллагын, Улсын шүүхийн шинжилгээний байгууллагын Шүүхийн шинжилгээний мэргэжилтэн техник- эрх зүй, шүүхийн шинжилгээний шинжээч- эрх зүйчийн ангийг хичээллүүлэн онол, практикын өндөр түвшинд бэлтгэж, чадварлаг шүүхийн шинжилгээний алба хаагч бэлтгэх нь чухал болоод байна.

Энэ арга замыг шийдэхийн тулд одоогийн шүүхийн шинжилгээ- эрх зүйн ангийн сонсогчийн элсэлтийг нэмэгдүүлэх нь бид мөрдөх албаны боловсон хүчинг бэлтгэж байна гэж ойлгох нь зүйтэй болов уу.



Санал.

1. Дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн хүчирхэг, чадварлаг, хараат бус, хөндлөнгийн хяналтын чиг үүрэг бүхий туршилт, судалгаан дээр тулгуурласан шинжилгээний, эрдэм шинжилгээ судалгааны улсын хэмжээний шүүхийн шинжилгээний албатай болох.

2. Хууль сахиулах байгууллагын онцлогт нь тохирсон Шүүхийн шинжилгээний албадуудыг байгуулах.

3. Хувийн шүүхийн шинжилгээний лабораториудыг байгуулах.

4. Хүний нөөц, сургалтын бодлогын хуулийн тогтолцоонд зоригтой тэсрэлт хийж, дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын жишигт хүрэх.

ТӨР, ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

*Б.Отгондалай
Волгоградын Цагдаагийн академийн
5-р курсын сонсогч, цагдаагийн ахлагч*



ОЛОН НИЙТИЙН ГАЗАР СУУРИЛУУЛСАН ВИДЕО КАМЕРЫГ АШИГЛАХ АСУУДЛЫГ ХҮНИЙ ЭРХИЙН ҮҮДНЭЭС АВЧ ҮЗЭХ НЬ

Техник технологийн хөгжил хурдацтай өсөн нэмэгдэж байгаа 21-р зуунд аюулгүй байдлын тухай бидний бодлыг өөрчилж, тэр дундаа камерийн видео бичлэгийг түүний салшгүй нэгэн хэсэг болгон оруулсан. Олон нийтийн газарт суурилуулагдсан видео камерыг хэрэглэх асуудал нь эрх зүйн талаасаа өөрийн судалгаа шинжилгээ болон шийдвэрийг шаардаж байна.

2012 онд «CCTVImage» сэтгүүлд хэвлэгдсэн мэдээнд Английн Лондон хотын High street хэсэгт судалгаа хийгдсэн бөгөөд түүнд зөвхөн Лондон хотод 500 мянган камер, бүх улс даяар ойролцоогоор 4 сая камер суурилуулагдсан байна гэжээ. Энэ тоо нь Чешира-ийн цагдаагийн байгууллагын хүрээлэлд хийгдсэн “Экстраполяция” гэх хэсэг газрын мэдээллээр бусдыг тогтоох аргаар тогтоогдсон байна. Тогтоогдсон тооны дагуу авч үзвэл 14 хүн тутамд 1 видеокамер ноогдож байна. Мөн тухайн мэдээлэлд дурьдагдсанаар энгийн нэг хүн өдөрт 70 камерын бичлэгт өртөх ба гэхдээ эдгээр бичлэгийн ихэнх нь дэлгүүрт хийгдсэн богино бичлэг байх болно.

Камерын бичлэг хийх гол зорилго нь хүний эрх, эрх чөлөөг гэмт хэргийн шинжтэй халдлагаас хамгаалах юм. Олон нийтийн газарт суурилуулагдсан видеокамерын бичлэгийг ашиглалтын үр дүнгийн үзүүлэлтээр, гэмт хэргийн гаралт гардаг хэсгүүдэд видеокамер суурилуулснаар 90% хүртэл буурдаг гэдгийг харуулсан.¹⁰³

Жишээ татвал, Волгоград Волжский хотуудад “Аюулгүй хот” гэсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ явагдаж байгаа бөгөөд энэ арга хэмжээний хүрээнд томоохон автозам болон уулзварууд, сонгуулийн хэсэг, банкнуудын ойролцоо, ихэнх дэлгүүрүүдэд,

¹⁰³ Г.Москва 2011г

бусад хүн ам олноор цуглардаг газрууд болон гэмт хэргийн гаралт ихтэй хэсгүүдэд видеокамеруудыг суурилуулсан¹⁰⁴.

Нэг талаасаа видеокамерын бичлэг хийх нь бидний аюулгүй байдлыг хамгаалдаг боловч, нөгөө талаас Видеобичлэг хийх нь хуулийн дагуу юу?, видеобичлэг хийх явцад бидний иргэний орон байрны халдашгүй эрхийг зөрчиж байгаа эсэх зэрэг асуултууд урган гарч ирж байна.

Хүний халдашгүй эрх нь өөртөө гэр бүлийн, ахуйн, хувийн зэрэг олон харилцааг өөртөө агуулсан хүний амьдралын үйл ажиллагааны онцлог хүрээлэл юм. Иргэний халдашгүй эрх нь хувь хүний эрх чөлөөний үндэс суурь болдог.

Өнөөгийн нийгэмд иргэний халдашгүй эрх нь хүний үндсэн эрхийн тоонд орсон ба хуулиар хамгаалагддаг эрхийн нэг болсон юм. Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, Хүний эрх эрх чөлөөний Европын конвенци зэрэг олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд хувь хүний халдашгүй дархан байдлыг чухалчлан авч үзсэн байдаг.

Эрх зүйт төртэй улс оронд хүний эрхэнд халдах нь төр, нийгэм, бусад иргэний аюулгүй байдлыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар тогтоосон хэв журмын дагуу байж болно.

Хаа сайгүй суурилуулагдсан видеокамерын бичлэгийн тусламжтайгаар хүний бусдад хамааралгүй мэдээллийг болон өвөрмөц цогц био өгөгдлийг¹⁰⁵ авах боломжийг нээж байна. Өөрөөр хэлбэл видеокамерын бичлэг нь хувь хүний био өгөгдлийн мэдээллээр адилтгал хийх бүхэл системийн гол түлхүүр холбоос нь болж байгаа юм. Орчин үеийн техник технологиуд нь хүнийг өөрт нь мэдэгдэлгүйгээр мөрдөх, хэрэглэж буй утсаар нь болон банкны цахим картаар нь хаана байрлаж байгааг хянах, сансрын видеокамерын тусламжтайгаар түүнд адилтгал¹⁰⁶ хийх боломж олгож байна.

Энэ тохиолдолд видеобичлэгт өртсөн хувь хүний мэдээлэл нь Youtube, V Kontakte, Odnoklassniki зэрэг нийтийн сайтуудад тухайн хүндээ мэдэгдэлгүйгээр тархах боломжтой. Ийм бичлэгийн эзэн нь интернэт хэмээх өргөн сүлжээний ертөнцөд өөрийнх нь орсон видеобичлэг байхыг таамаглах ч үгүй байдаг. Үр дүнд нь хүний хувийн мэдээлэл, хувь хүний өгөгдөл, ажиглалт, шалгалт, ерөнхий хяналтан дор байхгүй байх байдал аюулд өртдөг.

Үүнээс улбаалан хувь хүний амьдралын халдашгүй эрх ямар хязгаартай вэ? Хувийн халдашгүй эрхийн хүрээлэл хаана дуусдаг вэ? гэсэн асуултууд үүсч байна. Ерөнхий 2 үзэл санаа байдаг. Нэг хэсэг нь өөрийн гэрийг орхин гарснаар олон нийтийн газарт орох ба энэ үед хувийн амьдрал дуусч олон нийтийн орон зайд орно гэж боддог. Харин бусад нь хувийн амьдралын халдашгүй дархан байдал нь хаа сайгүй гэрт ч, ажил дээр ч байдаг буюу хувь хүн өөрийн тухай мэдээллийг бусдад мэдэгдэхийг хүсэхгүй байгаа тэр үед мөн байх юм.

Миний үзэж байгаагаар 2 дахь үзэл зөв бөгөөд хэрвээ хувь хүний үйлдэл, эс үйлдэхүйд хуулийн хэм хэмжээг зөрчсөн, зөрчих гэж буй ямар нэгэн асуудал байхгүй үед гэр бүлийн, ахуйн харьцаа, шашинд хандах хандлага, ажлаас гадуурх сонирхол гэх мэтийн бусад бүх харилцаа нь зөвхөн тухайн хүний зөвшөөрлөөр олон түмэнд нээлттэй болох ёстой юм.

Үүнээс бусад тохиолдлуудад хүний амьдралын үйл явцыг бэхжүүлэн хувийн зорилгоор ашиглах нь тухайн хүний хувийн халдашгүй байдлыг зөрчиж байгаа юм. Олон

¹⁰⁴ Новости Волгоградской области 2013г. "Безопасный город"

¹⁰⁵ Биометрические данные- био өгөгдөл /цахим техникийн(камер, гэрэл зургийн аппарат) тусламжтай хийгдсэн цахим хувилбараараа байгаа хүний гадаад биеийн хэмжээс болон бусад мэдээллийг хэлнэ/

¹⁰⁶ Габитоскопическая экспертиза-Дүр зургийн шинжилгээ

нийтийн газарт видеокамераар хийгдсэн бичлэгийн тусламжтайгаар хувь хүний амьдралын тухай мэдээлэл цуглуулах асуудал нь хуулийн шинэчилсэн зохицуулалтыг шаардаж байна.

Хувийн амьдралд оролцсон асуудлаар үүссэн асуудлыг шийдвэрлэсэн хамгийн сонирхолтой хэргийн нэг бол Европын Хүний эрхийн шүүхээс хянан шийдвэрлэсэн “Пэк Их Британий эсрэг”¹⁰⁷ гэх хэрэг юм. Уг хэрэг нь өргөдөл гаргагч амиа хорлохыг завдсаны дараа гудамжинд байрлах камерын бичлэг олон нийтэд ил болсон явдал юм. Уг хэргийг хянан шийдвэрлэсэн шүүгч тухайн камерын бичлэгийг хувийн амьдралын халдашгүй байдлыг зөрчсөн гэж үзээгүй бөгөөд харин тухайн бичлэгийг нийтэлж олон нийтэд ил болгосон явдал нь хүний эрхийг зөрчсөн гэж үзсэн юм. Шүүгч шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол гаргахын өмнө хувийн амьдралд халдаж, халдашгүй байдлыг зөрчсөн эсэхийг тогтоохдоо тухайн хүний “Хувийн халдашгүй байдлын боломжит хязгаар”-ыг тооцох хэрэгтэй гэж үзсэн. Гэхдээ Европын хүний эрхийн холбоонд шийдэгдсэн бусад хэргүүдэд олон нийтийн газарт бичлэг хийлгүйгээр дарсан зураг нь хувийн халдашгүй байдлыг зөрчсөн хэрэг болохгүй гэж үзсэн байна.

Одоогийн байдлаар энэ чиглэлийн хүний эрхийн асуудлууд нь дорвитой шийдэлд хүрээгүй байгаа бөгөөд эрдэмтэн, судлаачдын хамтын ажиллагаа, судалгааг шаардаж байна.

ШҮҮХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТУХАЙ ӨМГӨӨЛӨГЧИЙН ЭРГЭЦҮҮЛЭЛ

Б.Соёл-Эрдэнэ

Хүүхдийн өмгөөлөл төв ТББ-ын тэргүүн, хуульч

Иргэд шүүх гэхээр шүүгчид болон түүний туслах ажилтнууд ер нь шүүхэд хамааралтай бүхнийг ойлгодог. Энэ салбараас огт хол бүр хэзээ ч амьдралдаа шүүхээр асуудлаа шийдвэрлүүлж байгаагүй хүмүүс зарим үед өмгөөлөгч биднийг хүртэл шүүгч гээд яриад явж байдаг.

Уг нь шүүх бол онол, практикийн хувьд засаглалын биеэ даасан нэг хэлбэр юм. Нөгөө талаасаа шүүх нь хууль ёсны үйлчилгээ үзүүлдэг үйлчилгээний байгууллага гэж хэлж болно.

Шүүхийн тухай багц хууль 2013 оны 4 дүгээр сарын 15-аас эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээр шүүхийн шинэтгэл өрнөж байна. Бидний нүдэн дээр шүүхүүд шинэ бүтэцтэй болж, шинэ залуу шүүгчид ажилд томилогдон, шүүгчдийн нийгэм, эдийн засгийн баталгааг хангах чиглэлд төрөөс ихэд анхаарч, бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж, ажлын байр, ширээ сандал бүхий л зүйл нь шинэ болж байна.

Шүүгч нь прокурор, өмгөөлөгчийг сонсдог мэргэжлийн нэг хэл, хуулийн нэг мөр ойлголтоор ярих адилхан нөхцөл бүрдсэн гэж шүүгчдээс бусад хуульчид ойлгож байгаа юм. Гэвч хүний ухамсар, сэтгэлгээний хоцрогдлыг арилгахад урт удаан хугацаа шаардагдах үе байдаг. Өнөөдөр зарим шүүхэд шүүгч нар хуучин арга барил болох хэргийг шийдвэрлэлгүй удаашруулах, тогтоол гаргахгүй удах, хэргийн оролцогч нарыг загнах, илт шударга бус шийдвэр гаргах байдал жирийн үзэгдэл мэт хэвээрээ л байна.

Хэдийгээр эрхэм шүүгчдийн гол багаж болсон хуулиудад зарим нэгэн цоорхой байгаа боловч эрх ашиг нь зөрчигдсөн, гомдол гунигт автсан, бусдад итгэх итгэлээ гээсэн, уурлаж бухимдсан хүмүүст үнэнийг ойлгуулж, хүний эрхийг нь хүндэтгэн харьцах ёстой хүмүүс бол шүүгчид билээ. Гэтэл шүүгчийн харьцаа хандлага, тэдний бусадтай ялгавартай харьцдаг байдлаас шалтгаалан шүүхээр хэргээ шийдвэрлүүлж байгаа иргэд айж эмээх, өөртөө бүх бурууг үүрэх, шүүхэд үл итгэхээс гадна танил талаараа яриулахыг оролдох, шүүх хуралдааныг үндэслэлгүй шахуу шалтгаанаар хойшлуулах зэрэг элдэв бусармаг аргыг хэрэглэхийг оролддог. Шүүх хуралдааныг хойшлуулахад манай зарим нэг өмгөөлөгч нар “Өмгөөлөгчөөсөө татгалзаж байна” гээд хэлчих зэрэг “Мэргэн” зөвлөгөөг хүртэл өгсөн байдаг.

Саяхны нэгэн өдөр өмгөөлөгч миний бие Нийслэлийн давж заалдах шатны шүүх хуралдаанд шүүгдэгчийн өмгөөлөгчөөр орж ажилласан. Хэргийн материалтай танилцан, шүүхэд танилцуулсан шүүгч маань харьцаа хандлагын дараах алдааг гаргасан. Тухайлбал, шүүгдэгчийг илт буруутгасан, дайрч давшилсан, өмнөх шүүхийн гаргасан шийдвэрийг хэлэлцээгүй байж шинээр зүйл анги нэмж шийтгэж болохыг сануулж, хууль зөрчсөн хурал болсон. Хэргийн оролцогч нар тэгш эрхтэй байх ёстой биш билүү? Шүүгдэгчийн эрх ашгийг тууштай хамгаалан ажилласан өмгөөлөгч 1 жил 6 сарын хорих ялыг давж заалдах гомдол гаргасан нь бараг л буруутай гэв. Энэ байдал нь шүүгдэгчид ямар сэтгэгдэл төрүүлсэн нь хэлэлтгүй ойлгомжтой.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 153 дугаар зүйлд бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгах буюу гэмтээх нь гэмт хэрэг мөн гэж заагаад санкцийн хувьд торгох мөн 5 жил хүртэл хорих ялтай байхаар зохицуулалт хийгдсэн. Миний өмгөөлөл хийсэн шүүгдэгч “Г” нь эхнэр “О”-д 8 сая төгрөгийн үнэтэй автомашин худалдан авч өгөхдөө 6 сая төгрөгийг төлсөн байдаг. Гэр бүлийн маргаанаас болж тэр эхнэртээ авч өгсөн машины салхины шилийг хагалжээ. Хохирол 212.000 төгрөгөөр тогтоогдон түүнийг төлсөн. Эдгээр

хүмүүсийн гэрлэлт нь одоо ч хүчин төгөлдөр байгаа юм. Энд гэмт хэргийн бүрэлдэхүүн байна уу? гэдэг маргаантай асуудал юм. Энэ нь гэр бүлийн дундын өмч бодит байдлаар мөн гэж миний хувьд үзсэн.

Гэтэл нэгэн тусгай сургуулийн захирал “Э” гэгч нь прокурорын тогтоолд дурьдсанаар бол сургуулийн төсвийн хөрөнгөөс 9.350.000 төгрөгийг ашиглан завшсан. Энэ нь үлэмж хэмжээний хохирол биш учраас мөн “Төрийн албан тушаалтан” учраас эрүүгийн хэрэг үүсгэх боломжгүй гэжээ. Өөрөөр хэлбэл Монгол Улсын Эрүүгийн хуулийн 153 дугаар зүйл, 263 дугаар зүйлүүдийн хооронд ямар хол ялгаа байгаа нь тодорхой харагдана. Бусдын эд хөрөнгө гэдэгт чухам юу байх вэ гэдэг нь тухайн этгээдийн өмчлөлд биш зүйлүүд орох нь дамжиггүй. Гэтэл төрийн албан тушаалтан албан тушаалаа урвуулан ашиглаж **9.600.000** төгрөг хүртэл бусдын өмчийг завшсан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээхээр болж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт *"Монгол улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна. 14.2 дахь хэсэгт "Хүнийг үндэс, угсаа, хэл, арьс өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэгээр нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна"* гэж заасан “Эцэг” хуулийн заалт Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлтэй зөрчилдөж байна. Үүнийг эрдэмтэн, судлаачид анхааран судлах шаардлагатай бөгөөд энэ мэт Монгол Улсын Эрүүгийн хуулийн хэм хэмжээ Монгол Улсын Үндсэн хуультай зөрчилдөж байгаа явдал практикт өдөр тутам тулгарсаар байна.

